

# ТУСГААР ТОГТНОЛ

№2(46)  
2019

Үндэсний аюулгүй байдал, тагнуул  
судлалын эрдэм шинжилгээ, судалгаа,  
онол, аргазүйн сэтгүүл

Жилд дөрвөн  
дугаар гарна

## ЭНЭ ДУГААРТ

### ТАГНАХУЙН СУДЛААЛ

ТАГНУУЛЫН АЛБА, ТҮҮНИЙ АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙ . . . . .	3
Л.Батдолгор	
ГУРАВДУГААР РЕЙХЫН ХАЧИРХАЛТАЙ АЖЛУУД . . . . .	14
Ц.Насанбат	
Д.НАЦАГДОРЖ, Д.ПАГАМДУЛАМ НАРЫГ ТАГНУУЛЫН АЖИЛД АШИГЛАСАН УУ? . . . . .	24
С.Баттогтох	
ДОТООДЫГ ХАМГААЛАХ ГАЗРЫН ТӨВ СУРГУУЛИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ (1934-1940 ОН) . . . . .	27
Д.Авирмэд	

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ

БАНКНЫ САЛБАР ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ ТУРШЛАГА, СУРГАМЖ. . . . .	34
Р.Амаржаргал	
МОНГОЛ ХЯТАДЫН ХАРИЛЦАА УЛС ТӨРИЙН ШИНЭ СЭТГЭЛГЭЭ БА ХАМТЫН ХҮЧИН ЧАРМАЙЛТ . . . . .	44
Д.Уламбаяр	
ХҮЧИРХИЙЛЛИЙН БУС ТЭМЦЛИЙН АРГА БА “ӨНГӨТ ХУВЬСГАЛ” . . . . .	55
С.Сүхчулуун	
ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМЫН СУПЕР АЮУЛ . . . . .	63
Д. Дэлгэрсайхан	
МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ . . . . .	72
Д.Тунгалаг	
ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ХИЛИЙН ЧАНАДАД ЗОРЧИХ ҮЕД ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ НЬ . . . . .	80
Г.Гэрэлчулуун	

### ГАДААДЫН ТУСГАЙ АЛБАД

ГАДААДЫН ТУСГАЙ АЛБАДЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ . . . . .	86
---	----

# INDEPENDENCE

Research journal of national security,  
intelligence studies

## CONTENTS

### INTELLIGENCE STUDIES

INTELLIGENCE AGENCY AND EMPLOYEE ETHIC . . . . .	3
L.Batdolgor	
UNUSUAL ACTIVITIES OF THIRD REICH . . . . .	14
Ts.Nasanbat	
DID INTELLIGENCE OPERATION USED D.NATSAGDORJ AND D.PAGMADULAM? . . . . .	24
S. Battogtoh	
ESTABLISHMENT AND DEVELOPMENT OF CENTRAL SCHOOL OF HOMELAND SECURITY AGENCY, 1934-1940 . . . . .	27
D.Avirmed	

### SECURITY STUDIES

LESSONS AND EXPERIENCE OF REGULATION ON FOREIGN INVESTMENT IN BANKING SECTOR . . . . .	34
R.Amarjargal	
MONGOLIA, CHINA RELATIONSHIP: A NEW POLITICAL STATECRAFT AND COMMON EFFORT . . . . .	44
D.Ulambayar	
METHODS OF NONVIOLENT RESISTANCE AND "COLOURED REVOLUTION" . . . . .	55
S.Sukhchuluun	
SUPER THREAT OF INTERNATIONAL TERRORISM . . . . .	63
D.Delgersaikhan	
MONGOLIAN MINING SECTOR DEVELOPMENT AND ISSUES TO CONSIDER . . . . .	72
D.Tungalag	
SECURING PRIVATE SECURITY OF GOVERNMENT OFFICIALS WHILE TRAVELING ABROAD . . . . .	80
G.Gerelchuluun	

<b>FOREIGN INTELLIGENCE NEWS IN BRIEF . . . . .</b>	<b>86</b>
---	-----------

## ТАГНАХУЙН СУДЛАЛ

**ТАГНУУЛЫН АЛБА, ТҮҮНИЙ  
АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙ**

*доктор, профессор Л.Батдолгор*

Эртний төрт ёсны уламжлалтай, нийгэмд ёс журмыг хүндэтгэн сахиж ирсэн манай өвөг дээдсээс уламжлан бичиж үлдээсэн “Монголын нууц товчоо” мэт түүхийн олон ном сударт хүн хэрхэн ажиллаж амьдарч, хоорондоо хэрхэн харьцаж, биеэ яаж авч явбал зохихыг сургасан үнэтэй цэнэтэй ёс суртахууны сургаалууд бий. Энэ тухай академич, МУИС-ийн эмерит профессор С.Нарангэрэл “Монголчуудын зан суртахууны гарваль” номдоо тодорхой бичсэн байгаа.

Ялангуяа тагнуулчдын ёс суртахууны тухайд Их эзэн Чингис хаан “Улс гүрнийг тохинуулахад үзэх нүд, сонсох чих болсон хүнээ төрийн дээд эрдэнэ мэт хайрлаж яв. Үл харгис, үнэнч шудрага, цэгц журамтай, эрдэм гүн, билэг хурц хүмүүсийг сайшаан хүндлэх хэрэгтэй. Зусар, харгис, элбэрэл журамгүй этгээдийг жигшин занх ёстой” гэж сургажээ.

1911 онд монголын ард түмэн эрх чөлөөгөө тэмцэн олж манж-хятадаас тусгаарлаж гадаадын хоёр зуу гаруй жилийн дарлалыг таягдан хаясан билээ. Монгол төрийн удирдлага давын өмнө төрд зүтгэх чадвартай, эх оронч, эрдэм мэдлэгтэй,

ёс суртахуунтай хүмүүсийг шилж сонгож байсан нь түүхэн баримтаар нотлогдож байна. Монгол Улсын хаан Богд Жибзундамба хутагтын зарлигаар 1913 оны сүүлчээс 1918 оны эх хүртлэх хугацаанд дагаж боловсруулан нийтлүүлсэн 65 дэвтэр “Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн 7 дугаар дэвтэрт Монгол улсын таван яамд “угаас эрдэм илүү, сахилга ариун, хэрэг дор хичээнгүй, нас идэр залуу, эсвээс тэнхлүүн тушаалыг чадахыг тэргүүн зэрэгт шалгарсанд болгоно. Ховдог, харгис, зөөлөн үхээнц, чадалгүй, хичээнгүй үгүй, өвчтэй, долгин хатан (ааш зан хурц), эрдэм дорыг ... хэлэлцэн... Гурван жилд тутамд нэгэнтээ байцаан дэвшүүлэх, бууруулах, агуулах, байлгахыг тогтооно” гэсэн байна. Хуулийн энэ заалт нь өнөөгийн төрийн албан хаагчийг сонгон шалгаруулдаг ажилтай төсөөтэй юм. Тэр үеийн Монгол улсын таван яамны гурав нь тагнах ажиллагаа явуулж байсан учир эл ёс зүйн журам бас л хамаарч байжээ.

1921-1990 онуудад ч төрийн албан хаагчид, тагнуулын ажилтныг сонгон шалгаруулах, түүний ёс зүйн талыг харгалзан үзэх ажил янз бүрийн

байдлаар явагдаж байжээ. Энэ 70 жилийн хугацаанд анги, намын үзэл суртал баримталж, харийн их гүрний эрхшээл, нөлөөнд байсан боловч Монголын тагнуулын байгууллагыг хуулийн хүрээнд, үнэнч шудрага, ёс зүйтэй үйл ажиллагаа явуулахад анхаарч байсан байдаг.

1929 онд хуралдсан Улсын VII Их Хурал, МАХН-ын VIII Их Хурал ДХГ-ын ажлын талаар хэлэлцээд ДХГ-ын албан хаагчдын мэдлэг, боловсрол, ажил гүйцэтгэх чадвар, сахилга хариуцлага, ёс суртахуунд холбогдох олон чухал зүйл, заалт оруулжээ. Уг тогтоолд: “ДХГ-ын албан хаагчид хэргийн учир чанарыг хянан шинжилж боловсруулсангүйгээр зарим этгээдийг хилсээр хэрэгт холбогдуулан барин хорих, хэргийг даруй нэгэн тийш болголгүй удтал хорьж хүлээлгэх ба харъяат олон газруудад үл зохилдох этгээдийг үлэмжхэнээр хэрэглэж байгаа бөгөөд тэдгээр албан хаагчид нь албан тушаалд эрдэн, тус газрын нэр сүрээр ард олныг айлган дарлах зэрэг үл зохилдох явдал үлэмжхэн гарсан тул үүнээс хойш Засгийн газраас ДХГ-ын аливаа хэрэг явдал ба албан хаагчдыг сайнаар удирдан хянаж, сайжруулан нийт хувьсгалын ба улс төрийн хийгээд ард олны эрх чөлөөнд халдах, харшлах зэргийн үл зохилдох явдлыг хянаж сэргийлэхийг нарийн чанад болгож үнэхээрийн эрх журмыг бат сахиулах...” гэсэн байна.

1929 оны 5 дугаар сарын 31-ний өдөр гаргасан ДХГ-ын ерөнхий даргын 61 тоот тушаалд “тус газрын албан хаагчид болбоос нэгд: ядуу ардын гарт буй хатуу засгийн

ангийн зэвсэг бөгөөд баатарлаг чанга гүйцэтгэх зэвсэг бөгөөд ямагт сэрэмжтэй бэлэн байх, хоёрт: ардын хатуу засгийн хэрэгт буцах няцахгүй биеэ өгөхөд хэзээ ч бэлэн, хиргүй үнэнч шудрага, хувьсгалын чанга сахилгатай ядрахгүй ажиллаж чадах, улс төр эдийн засгийн бүх явдлыг үзэж мэдэх бэлтгэлтэй, хатуу зориг сүрдэхгүй зүрхтэй, эрүүл, гуравт: өөрсдийн ангийн их зорилго, хариуцлага, үүргийг бүрэн мэдэж баатарлаг зорилгыг тойрч хатуугаар нэгдэх, дөрөвт: хувийн явдалд ч хиргүй тунгалаг явж өдөр тутмын ажилд ард ангийн журмыг чангаар баримтлах, тавд: удирдамж заавар хууль цаазад хязгаарлагдахгүй тус газрыг зорилготой холбогдуулан бүх нууц гүйцэтгэх ажлыг дэвхийлэх мэдрэлтэй бөгөөд шаламгай байваас зохихыг” тушаажээ.

1936 оны 3 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны 2 дугаар Бүгд хурал дээр Улсын Бага Хурлын дарга А.Амар ДХГ-ын ажилд оршиж буй алдаа дутагдлыг Ерөнхий сайд П.Гэндэн, тус газрын дарга Д.Намсрай нарын ажлын арга барилтай холбож Дотоодыг хамгаалах газрын хууль зөрчсөн үйл ажиллагаа болон түүний удирдлагын үйл ажиллагааны талаар дараах байдлаар шүүмжилж байжээ.

“...Гэндэн алив нэг хууль дүрэм тогтоох, батлах явдалд хянах, болгоомжлохыг үл хайхрах ба түүнчлэн хууль дүрмийг зөвөөр хэрэглэж буй эсэхийг хянадаггүй бөгөөд улсын дотор ямар нэг их, бага хэрэг үүсэхэд түүний тухай огт санаа зовохгүй буюу хянах, болгоомжлохыг бодохгүй байдаг. Ямар нэг хилс

гомдолтой хэрэг гаравч мөн хайхарч үздэггүй. Хэрэг ял гэгч бол жинхэнэ хийж үйлдсэн дээрээс бүтэж гардагаас биш хэн нэг хүний санааны дураар зохиомол хэрэг ба зохиомол аргаар хийж явуулдаг тийм ёс хаана ч байж хэрхэвч үл болно. Ялангуяа бүдүүлэг нүүдлийн байдалтай бөгөөд гэмт хэргээс биеэ хамгаалах мэдлэг боловсрол нээгдэж чадаагүй манай монгол орноо тийм үнэнгүй зохиомол хэрэг явдал байж хэрхэвч үл болох амой.”<sup>1</sup>

Мөн цааш нь шүүмжлэхдээ: “...Намсрайн эрхэлсэн ажил дээр их л гайхмаар, эргэлзээтэй бөгөөд гүжир гүдүү, хилс ташаа хэргүүд үзэгдсээр байна. Ийм явдал бас хөдөөгийн ажилчдын дотор боловч ихээхэн үзэгдэх, сонсогдох болсон ба улсын дотор гомдол гаргагчдын өргөдөл, мэдүүлэг ч ямагт олширч эргэлзмээр, татгалзмаар хэрэг явдал хэзээд гарсаар байх болсон тул миний бие Гэндэнд энэ тухай бас л хэлж эрхбиш нэг арга хэмжээ авбал зохихыг удаа дараа сануулж хэлсэнд ер төдий л хайхарч үзэхгүй өнгөрүүлдэг ба ... Намсрайд энэ мэтийн хилс гүжир явдлуудыг засаж арилгах тухай хэлэхэд ... харин засах байтугай улам үргэлжлүүлэн явуулсаар иржээ. Түүгээр үл барам ямар нэгэн этгээдээс ирүүлсэн хилс гомдлын тухай хэргийн тогтоол ба уул хэргийг Бага Хурлын Тэргүүлэгчид авч хянах гэхэд ДХГ-ын дарга итгэж үзүүлэхгүй байсан буюу хэрэгтэн ялтнаас Бага Хуралд гомдол мэдүүлэв хэмээн бас нэмж хэрэг ял оногдуулах жишээтэй байсан” гэжээ.

Тагнах үйл ажиллагаа хууль бусаар, хяналтгүй явагдвал туйлын хор уршигтай байдаг тухай гашуун дурсамж ард олны сэтгэлээс эдүгээ хүртэл арилаагүй байгааг Монгол Улсын түүх бэлхэнээ гэрчилнэ.

ДХГ-ын ажилд хяналт тавих гэсэн нам, төр засгийн удирдлагын оролдлого 1 дүгээрт: Тэр үед монгол оронд эрх зүйн орчин боловсронгуй болж хөгжөөгүй; 2 дугаарт: Гадаадын хүчирхэг гүрний болон Коминтерний нөлөөгөөр хүчирхэг гүрний нам, төрийн ба ангийн бодлогыг баримталж монголын ард түмнийг хооронд нь харгалдуулж зарим хэсгийг устгах, бүр улс төрийн эрхийг нь хасах чиг шугам баримталж байсан; 3 дугаарт: Хүний эрхийг хамгаалах байтугай хүний эрхийн талаар хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн баримт бичиг тэр цаг үед байгаагүй зэрэг олон шалтгааны улмаас үнэхээр хэрэгжих тавилангүй байжээ.

1942 оны үед тэр үеийн эрх баригч МАХН Улсыг аюулаас сэргийлэн хамгаалах газар ба түүний харъяа гүйцэтгэх газар, хэлтсийн ажлыг шалгуулсны үндсэн дээр 1942 оны 7 дугаар сарын 25-ны өдөр “ДЯЯ-ны ажлын тухай” тогтоол гаргажээ. Уг тогтоолд УАСХГ-ын “ажилчин нэг бүр өөртөө өндөр улс төрийн мэдрэл ба хатуужлыг олоход онц анхаарал тавих, ялангуяа худал хэлэх, мэхлэх явдал буюу нэр сүрийн хойноос хувийн ашиг тусын төлөөнөө хөөцөлдөгчидтэй онц эрс тэмцлийг тавьж, тийм үл бүтэх этгээд нарыг өөрийн аппаратаас цэвэрлэн зайлуулж байх” гэж заасан нь ажилтны ёс зүйн асуудалд онцгой анхаарч байсныг харуулж байна.

<sup>1</sup> Ш.Агваан.Х.Чойбалсан ба Дотоод явдлын яам. УБ., 1991, т. 13

Дэлхийн II дайны дараа (1945 онд) “УАХБ-ын ажилтан бол нам, засаг, ард түмэндээ хязгааргүй үнэнч хайртай, эх орноо дайсны хорт заналаас хамгаалах талаар өгсөн хүндтэй үүргийг мэдлэгтэй бөгөөд үнэнч шудрагаар биелүүлж чаддаг, биелүүлэхийн төлөө хэзээ ямар нэгэн цагт өөрийн хүч чадал, амь биеийг хайрладаггүй, ямар хэцүү бэрхшээл тохиолдовч шантрашгүй давж чаддаг, тохиолдсон үзэгдэл бүхнийг зөвөөр мэдэрч орчин тойрон, орон цагийн байдалд тохируулан зөвөөр шийдвэрлэн ажиллаж чадах улс төрийн онолын бэлтгэлтэй, төмөр мэт сахилгабаттай, өндөр сонор сэрэмжтэй, ямар нэг үл бүтэх явдлаас зайлсхийж явдаг, хувийн ашгийг хичээдэггүй, чухамхүү намч ёсоор ажилладаг, олон түмнээр хүрээлэгдэж чадсан, ажил хэргийн төлөө үргэлж санаа тавьж байдаг, ажилтны ажиллагааны арга техникийг эзэмшиж ашиглаж чадах авъяас билэг бүхий шалгарсан байх ёстой” гэж заасан байв.

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр УИХ-аас баталсан “Монгол Улсын тагнуулын байгууллагын тухай хууль”-д тагнуулын байгууллагын ажилтанд тавих ёс зүйн шаардлагыг анх хуульчлан баталжээ. Энэ шаардлагад: “Тагнуулын ажилтанд Төрийн албаны тухай болон Авлигын эсрэг хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах, эрхийг нь хязгаарлах, албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, далайлган сүрдүүлэх, албан тушаалаа болон захирагдагчаа хувийн зорилгоор ашиглах, удирдлагын тусгайлан өгсөн

зөвшөөрөлгүйгээр албан ажлынхаа талаар, нийтэд болон бусдад мэдээлэх, мэдээлэл дамжуулах, хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хавсран гүйцэтгэж цалин хөлс авах, ажил хаях, тагнуулын байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох, ажиллаж байх хугацаандаа болон ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа 2 жилийн хугацаанд тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй гадаадад зорчих, төрийн албан хаагчид хуулиар хориглосон бусад зүйлийг хориглоно”<sup>2</sup> гэсэн байна.

Дээрх хууль батлагдснаас хойш 5 сарын дараа 1999 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди тагнуулын байгууллагын бие бүрэлдэхүүнд хандаж: “Эрүүл чийрэг, олон талын эрдэм ухаантай, эх оронч сэтгэлгээтэй, шудрага, тэсвэр хатуужилтай, гүйцэтгэгч овсгоотой, өөртөө хатуу шаардлага тавьдаг, мэдрэмжтэй, даруу түвшин чанар тагнуулын ажилтны дүр төрх мөн. Тангарагаасаа няцдаг, гуйвамтгай, албан тушаалаа урвуулан ашигладаг, бусдын нөлөөнд автдаг, хууль зөрчдөг, хов зөөдөг, чалчаа, хутган үймүүлдэг хүн энэ байгууллагын эгнээнд байх ёсгүй”<sup>3</sup> гэжээ.

“Тагнуулын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 2.1-д “Тагнуулын байгууллагын ажилтан, албан хаагч нь тагнуулын ажилтны тангарагтаа

<sup>2</sup> Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хуулиудын эмхтгэл. УБ., 2003, т. 78-79

<sup>3</sup> Н.Багабанди. Шинэ зуун: Үндэсний аюулгүй байдлын гадаад бодлого. УБ., 2004, т. 39

үнэнч, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ албаны болон хувийн харилцаандаа эрхэмлэн дагаж мөрдвөл зохих төрийн тусгай албаны онцлог, тусгай шаардлагад нийцсэн зан үйлийн цогцыг Тагнуулын ажилтны ёс зүйн хэм хэмжээ гэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Ёс зүйн хэм хэмжээ нь хүмүүсийн нийгэмд биеэ авч явах байдлын ердийн горим журмыг тогтоосноороо нийгмийн амьдралд байгаа аливаа ашиг сонирхлыг зохицуулахад ихээхэн нөлөөтэй.

Монгол Улсад сүүлийн арав гаруй жилийн хугацаанд төрийн албан хаагчдын ёс зүйн олон дүрэм, журам батлагдаж үүнтэй холбогдсон судалгааны олон ном, гарын авлага гарч, судалгааны өгүүлэл бичигдэж байна. Тагнуулын ажил, тагнуулын үйл ажиллагааны ёс зүйн талаар дагнасан судалгаа байхгүй байна. Харин ТЕГ-ын Дээд сургуулийн сэтгэл судлалын багш-судлаач агсан Ш.Батсүх “Тагнуулын үйл ажиллагааны сэтгэл зүйн үндэс” номондоо тагнуул, сөрөх тагнуулын үйл ажиллагааны ёс зүйн асуудлыг нэлээд оновчтой хөндөж гүйцэтгэх ажил, тагнуулын ажилтны ёс суртахууны асуудлын талаар сонирхолтой дүгнэлт хийсэн байна. Судлаач Ш.Батсүх уг номондоо “тагнуул, сөрөх тагнуулын ажил төрийн хууль, ёс зүйн зохих хэм хэмжээнд явагдана. Тагнуулын ажилтанд тавигдах шаардлага ба эзэмшвэл зохих шинж чанар дотор төрийн хууль ба ёс зүй, дэг журмыг хатуу чанд сахих явдал багтана. Тагнуулын ажилтан эх оронч үзэлтэй,

шаргуу туйлбартай, хүлээсэн үүргээ сайн мэдэрч ухамсарладаг, хүнтэй харилцах, бусдыг өөртөө татах чадвар сайтай байх ёстой. Тагнуулын ажилтан өөртөө хяналт шүүмжлэлтэй хандах явдал дутагдвал мэргэшлийн онцлогтой холбоотой бие хүний гажилт үүсч мэднэ. Тагнуулын ажилтан тодорхой хэмжээний бүрэн эрхтэй байдгаас биеэ тоох, бардамнах, бүдүүлэг, энэрэнгүй бус зан гаргах зэрэг сөрөг шинж чанартай болж болно. Мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдон бас хэт сэжиглэмтгий, хүнд итгэхгүй муу санаа гаргах, цаг хугацаанд хавчигдах, мэдээллийн хомсдолтой байдлаас юманд яаруу, өнгөц дүгнэлт өгч шийдвэр гаргах, хүнийг гэмт хэрэгт татан оруулах зэрэг сөрөг зан төлөвтэй болж болно. Тагнуулын ажилтан ба туслагчийн ажлыг цөөн хүний хүрээнд мэдэж үнэлж байдаг учир өөртөө байнга хяналт тавьж шүүмжлэлтэй хандаж байх учиртай, мөн удирдлагын хяналт шалгалт, мэргэжлийн түвшин тогтоох шалгалт, шилэлт, сонголтыг тодорхой хугацаанд хийж байх шаардлагатай. Туслагчтай хамтарч ажиллах сэдэлт төрүүлэх, нэг үзэл бодолд эх оронч үндэсний үзэл, үндэсний нийтлэг зан заншил, бахархал, хууль ёс, хүн төрөлхтний ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг чанд мөрддөг зан байдал зэргийг хамруулж болно” гэж тагнуул, сөрөх тагнуулын үйл ажиллагаанд ёс зүйн зан төлөвтэй холбоотой дүгнэлт өгсөн байна.

Нийгэм ба төрөөс тагнуулын ажилтнуудад өөрсдийн мэргэшлийн зорилтуудыг шийдвэрлэхэд тусгай хэрэгсэл, аргуудыг ашиглах боломж



олгохдоо тэдэнд өндөр шаардлага тавьж асар их итгэл үзүүлдэг. Энэ өвөрмөц онцлог хувь хүн ба түүний хувь заяа (амьдралд)-нд нөлөөлөх эрх тагнах ажлын ажиллагааны дээр дурдсан өвөрмөц онцлогоос урган гарч тагнуулын ажилтанд олгогддог. Тийм учраас нийгмийн өмнө тагнуулын ажилтан өндөр хариуцлага хүлээх ёстой. Түүнээс гадна тагнах ажиллагааны ёс суртахууны агуулгын зарим нэг онцлог байдал түүний нууцлаг шинж чанартай холбоотойг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, нийгмийн зүгээс тагнах ажиллагаа явуулдаг байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд ёс суртахууны хяналт тавих боломж хязгаарлагдмал байдаг. Нийгмийн олон нийт зөвхөн тагнах ажиллагааны зарим үр дүнд л үнэлэлт өгдөг. Энэ үйл ажиллагааны нууцлаг шинж байдлаас шалтгаалаад хүч ба хэрэгсэл, аргаа хуулийн дагуу хэрэглэж байгаа эсэхэд үнэлэлт өгч чаддаггүй. Ийм учраас тагнуулын ажилтнуудын үйл ажиллагаанд нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага, мэргэшлийн байгууллагын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үүрэг, өөрийн үйлдлийн төлөө хүлээх хариуцлагыг үлэмж өндөржүүлэх ёстой. Харамсалтай нь зарим ажилтны туйлын хариуцлагагүй хэлбэрдэх ажиллагааны улмаас тагнуулын ажлын чухал арга хэмжээ нурж байсан баримт байдаг. Тагнах ажиллагааны арга хэмжээнд хамрагдаагүй хүмүүс тагнах ажиллагаа ба тагнах ажиллагааны арга хэмжээнд ёс суртахууны үнэлэлт өгөх боломжгүй учраас зөвхөн

тагнуулын байгууллагын удирдлага, тагнуулын ажилтнууд л өөрсдөө тагнах ажиллагааны арга хэмжээнд ёс суртахууны үнэлэлт өгөхөд хүрдэг. Энэ бол тэдний нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлж байгаа нэг жишээ. Учир нь нууцлалыг чанд сахих зайлшгүй нөхцөл байдал аливаа үйл ажиллагааны жинхэнэ агуулгыг, түүний дотор тэр үйл ажиллагааны жинхэнэ ёс суртахууны шинж байдлыг нууцлахыг шаарддаг. Ийм учраас тагнах ажиллагааны гүн гүнзгий ёс суртахууны агуулга заримдаа хөндлөнгөөс харахад ёс суртахуунгүй мэт сэтгэгдэл төрүүлж болох юм. “Нуусан бүхэн хардлага төрүүлдэг” гэсэн зүйрлэл байдаг билээ.

#### *Гадаад улсуудын тагнах ажиллагааны ёс зүй*

1960-аад оны дунд үеэс тагнах үйл ажиллагаа ба гүйцэтгэх ажлын хүрээн дэхь ёс суртахуунтай холбогдсон харилцааг эрх зүйн харилцаанаас гадна судлах нь зайлшгүй шаардлагатай гэсэн санааг гадаадын зарим судлаач дэвшүүлсэн байна. Харин зарим судлаач эрдэмтэн тагнах ажиллагаанд ер нь ёс суртахуун гэж байх уу? гэж эргэлзсэн бодлоо илэрхийлсэн нь ном хэвлэлд бичигдсэн байдаг. Оросын эрдэмтэн А.Г. Лекарь үүнийг үл зөвшөөрч туршлагагүй, ажилдаа олигтой мэргэшээгүй зарим тагнуулын ажилтны үйл ажиллагаандаа гаргасан ёс суртахуунгүй үйлдэл тагнах ажиллагаа ерөөсөө бүхэлдээ ёс суртахуунгүй болохыг батлаж байгаа хэрэг биш гэж бичсэн байна. Энэ нь ч үнэхээр зөв болох нь судалгааны



явцад батлагдаж байна.

ОХУ-ын эрдэмтэн А.И Алексеев, Г.К.Синилов нар тагнах үйл ажиллагаан дахь ёс суртахууны хэм хэмжээ ба харилцаанд нэлээд дорвитой судалгаа хийсэн байна. Тэд тагнах үйл ажиллагааны ёс суртахууны үндсүүд ба тагнах үйл ажиллагаа явуулах явцад үүссэн ёс суртахууны харилцааг судлахын ач холбогдлыг тодорхойлохдоо арга зальтай, гэмт үйлдлээ нягт нямбай нуун далдалсан эсрэг этгээдтэй тэмцэл явуулах зайлшгүй шаардлагаас урган гарсан тагнах ажиллагааны өвөрмөц олон арга байдгийг заан тэмдэглэсэн байна.

Зарим гадаад улсын тагнах ажиллагаанд баримталдаг ёс зүйн хэм хэмжээнээс жишээ татахад: Өмнөд Африкийн Бүгд найрамдах улсад 1994 онд батлагдсан “White Paper” буюу “Цагаан ном” нэртэй хуульд зааснаар бол “Өмнөд Африкийн шинээр байгуулагдсан тагнуулын албад дараах ёс зүйн хэм хэмжээг үйл ажиллагаандаа баримтлана” гэсэн байна. Үндсэн хууль болон ардчиллын бусад хуульд үнэнч байх; хуулиар тогтоосон дүрэм журамд захирагдах; ардчиллын үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрөх; улс төрийн талаар төвийг сахих зарчмуудад үнэнч байх; мэдээ, мэдээллийг шударга, бодитой, урьдчилсан сэжиг таамаглалгүй үнэлэх үүрэг хүлээх; улс төрийн бодлого боловсруулагчид ба тагнуулын мэргэжлийн хүмүүс хоорондын харилцан итгэлцлийг хөхиүлэн дэмжих”<sup>4</sup> гэжээ.

<sup>4</sup> Kenneth R.Dombroski Transforming Intelligence in South Africa. White Paper on Intelligence. 1994.

АНУ-ын тагнуулын ажилтны ёс зүйн кодекст: “Тагнуулын ажилтан үйл ажиллагаандаа ёс суртахууны өндөр зарчмуудыг удирдлага болгох ба улс орны ашиг сонирхлыг ямарч этгээд нам, эсхүл төрийн байгууллагуудын ашиг сонирхлоос дээгүүр тавина; хууль ба АНУ-ын удирдах байгууллагуудын эрх зүйн хэм хэмжээг мөрдлөгө болгох ба төрийн Үндсэн хуулийн үндсүүдийг зөрчих ажиллагаанд оролцохгүй; шудрага ажилтны нэр хүндийг шудрага бусаар гутаан доромжилж байгаа бол ямарч этгээдэд дэмжлэг үзүүлж эдлэх эрхгүй эрх дархыг олгохгүй, тэднийг албан тушаалд дэвшүүлэхгүй; албаны шийдвэр гаргахад нөлөө үзүүлэхэд ашиглагдаж байгаа баялаг болон давуу байдлыг ажилтан, түүний гэр бүлийн гишүүд ашиглахыг хориглоно; байгууллагын ашиг сонирхлыг хөндсөн хувийн шинж чанартай амлалт өгч болохгүй учир нь тийм амлалт байгууллагын ажилд нөлөөлж болно; өөрийн мэдэлд байгаа нууц мэдээллийг хувийн зорилгоор ашиглаж болохгүй; албан ажлын байдалд харшилж байвал бусад байгууллагатай шууд буюу шууд бусаар харилцаа (арилжааны, эсхүл хувийн материаллаг сонирхолд хамаарах) тогтоохыг хориглоно; төрийн албан тушаалд ард түмний итгэлийг өвөрлөж байгаа гэж итгэн ухамсарлаж ёс зүйн хэм хэмжээг ямарч нөхцөлд хэлбэрэлтгүй мөрдлөг болгож ажиллана”<sup>5</sup> гэж тэмдэглэсэн байдаг.

ХБНГУ-ын тагнуулын ажилтны мэргэжлийн үндсэн шаардлагад:

<sup>5</sup> АНУ-ын ТТГ-ын ажилтны ёс зүйн кодекс. 1978

“өгсөн олон төрлийн үүргийг гүйцэтгэх хүсэл эрмэлзэлтэй, нууцыг хадгалах, өөрийгөө хамгаалах талаар өндөр мэргэшсэн, санаачлагатай, эрүүл саруул ухаантай, өөдрөг зан төлөвтэй, хөдөлгөөний эвсэлтэй, шаргуу, зоригтой, махруу, ажигч, мэдээллийг тогтоох чадвартай, бие бялдарын хатуужилтай, техникийн тусгай төхөөрөмжийг ашиглах чадвартай байх”<sup>6</sup> гэх мэт чанарыг жагсаасан байна.

Түүнээс гадна “Израиль улс дахь тагнуулын ёс зүй”<sup>7</sup> судалгааны өгүүлэлдээ доктор Шломо Шпиро “Израиль улс тагнуулын албаддаа өргөн эрх олгосон. Эдгээр албадын ажилтнууд баривчилж, байцааж, хувийн эрх чөлөөнд халдан, тэрч байтугай амь насыг нь өгүүтгэх эрхтэй. Хууль ба албаны эрх зүйн актаар эдгээр эрх мэдлийг хязгаарлаж эрх мэдлээ хэтрүүлэх, хүнтэй хатуу ширүүн харьцахаас урьдчилан сэргийлэхийг чармайдаг боловч өргөн далайцтай тагнах ажилагааны явцад эрх зүйн зохицуулалт тагнуулын ажилтан бие хүний үйлдлийг хангалттай удирдан зохицуулж чаддаггүй. Тагнуулын ажилтан ихэвчлэн ганцаараа буюу жижиг багаар ажилладаг ба хилийн чанадад ажиллаж байхдаа байнга өөрийн удирдлагад хандах боломжгүй байдаг. Тагнуулын ажилтан бодит асуудалтай нүүр тулж сэтгэл зүйн хувьд хоёрдмол байдалд ордог. Хууль ба бусад зохицуулалтууд тэр бүр асуудлыг шийдэхгүй тагнуулын ажилтан өөрийн сэтгэл зоригоор асуудлыг шийдвэрлэх нь ховор биш

байдаг”<sup>8</sup> гэсэн байна.

Доктор Шпирогийн үзэж байгаагаар бол “хууль ба тагнуулын байгууллагын эрх зүйн хэм хэмжээ асуудлыг зохицуулах нөхцөлд ёс зүйн асуудлууд гарч ирдэг. Эдгээр ёс зүйн асуудлууд тагнуулын ажилтны биеэ авч явах удирдамж болох ба энэ нь тагнуулын ажилтны тодорхой итгэл үнэмшил, нийгэм дахь тагнах ажиллагааны үүргийн тухай үзэл бодол, иргэн ба тагнуулын ажилтны хоорондын үйлдэлд хийх дүгнэлт дээр үндэслэдэг” гэжээ. Цааш нь доктор Шпиро “Бичигдмэл хууль ба байгууллагын эрх зүйн зохицуулалт хоёр дуусгавар болмогц ёс зүйн зохицуулалт эхлэх ба тагнуулын ажилтны үйл ажиллагааг чиглүүлэх “зөвлөмж” болж өгдөг. Цаасан дээр бичигдэж мөрдөн шалгах алба ба шүүхийн албадлагын хүчээр хэрэгждэг хууль ба албаны эрх зүйн хэм хэмжээний актаас ялгаатай нь ёс зүй тагнуулын ажилтнуудын бэлэн байдалд захирагдаж түүнээс илүү хамааралтай байдаг”<sup>9</sup> гэжээ. Судлаач цааш нь судалгааны өгүүлэлдээ: Израилийн тагнуулын ёс зүйд “үнэнийг хэлж байх”, “гадаад, дотоод эх сурвалжаа хамгаалах”, “дотооддоо халхавч хэрэглэхээс татгалзах”, “шашныг хүндэтгэх”, “хувийн ёс суртахууны эерэг шинжийг хадгалах” гэсэн таван үндсэн хэсэг байдаг гэжээ.

Турк улсын судлаач Дианэ М.Жаносек “Европын холбоонд элсэх Турк улсын ёс зүйн шинэчлэлийн үүрэг” өгүүлэлдээ тагнуулын байгууллагын ёс зүйн тухайд: “Туркийн аюулгүй байдлыг

<sup>6</sup> З.Төрмандах, Б.Нармандах. Гадаад орнуудын эрүүгийн тагнуулын ажиллагаа. УБ., 2007, т. 20

<sup>7</sup> www.biu.ac.il

<sup>8</sup> www.biu.ac.il

<sup>9</sup> www.biu.ac.il

хамгаалах байгууллагууд ирээдүйн аюулгүй байдлын байгууллагад ажиллах бие бүрэлдэхүүнийг (бүгд эрэгтэйчүүд, үнэндээ дээд албан тушаалд ямарч эмэгтэй хүн байхгүй) 14 настайгаас нь аюулгүй байдлын тухай үзэл санааг ойлгуулж эхэлдэг. Авилга ба тагнуулын албадын хооронд тогтсон харилцаа бий. Хэрэв авлига хэвлэл мэдээлэл, шүүхийн, хууль тогтоох байгууллагын хяналт, тэнцвэржүүлэлтээр дамжин илүү их хяналттай, олон нийтийн салбарт өргөн тархвал ил тод үйл ажиллагаа багатай нууц салбаруудад авлига улам гүнзгийрэх магадлалтай. Тагнуулын байгууллагуудад голцуу шалгалт, ил тод байдал багатайн улмаас илүү өөрийн дураар ажиллах боломжтой байдаг. Шударга зан байдлыг хувийн ашиг сонирхол давамгайлдаг. Олон нийтийн салбарт дахь авлига тагнуулын албадад тархдаг ба энэхүү тархалт их өргөн учраас урьдаас таамаглахын аргагүй хор хохирол бусдад учруулж болно. Тагнуулын мэдээллийг буруу ашиглавал хувь хүний болон улсын үндэсний аюулгүй байдалд хоёуланд нь аюултай. Жишээлбэл, аюулгүй байдлын ажилтан улс төрч, сэтгүүлч, бизнесийн өрсөлдөгчдөд мэдээлэл дамжуулж болно. Тагнуулын мэдээллийг хүний нэр хүндийг гутаах эсхүл улс төрчид болон улс орны дээд удирдлагыг хахуульдах зорилгоор ашиглаж болно. Улс төрийн өрсөлдөгчид тагнуулын албадыг хувийн зорилгодоо ашиглахыг санаархаж болно. Тодорхой ажиллагаа эсвэл хувь хүнийг тагнаж мөрдөх аюул нь хууль бус төлбөр тооцоо, эсхүл зүй

зохисгүй гэрээ хэлэлцээрийг хүчээр тулгах зорилготой байж болно. Улсын усан боомтын ажилтнууд ба гаалийн ажилтныг хахуульдан эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэснээ нууж байгаа бол, илүү нууц ажиллагаатай, ил тод байдал багатай тагнуулын албадад эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэх асуудал байдаггүй гэх баталгаа байхгүй”<sup>10</sup> гэсэн байна.

АНУ-ын судлаач Мичел Андрегг “Ёс зүй ба мэргэжлийн тагнуул” нэртэй судалгааны өгүүллийг “удиртгал; тагнуулын албадын мэргэжлийн тагнуулчдын бодол санаа ба ёс журам; олон төрлийн тагнуулчдын ялгаатай дүр төрхийн зөв сонголт; шудрага дайны онол цэргийн ба сүм хийдийн ёс суртахуунтай холбогдох нь; бодит нөхцөл байдлыг харьцуулсан хамгийн муу тохиолдлын дүр зураг; эрүү шүүлт ба цаазлах үйлдэл; утга зохиолын хяналт (шүүмж); ирээдүй рүү хандсан асуултууд; судалгаанд хэлэлцэх асуудал, дүгнэлт” гэсэн хэсэгтэй туурвисан нь тагнуулын ёс зүйг тал бүрээс задлан шинжилж гүн гүнзгий ойлгох боломж олгосон байна.<sup>11</sup> Гадаадын хэд хэдэн улсын тусгай албад хэлэлцэн тохирч 2004 онд “Тагнуулын ажилтны ёс зүйн холбоо” нэртэй төрийн бус байгууллагыг бий болгосон байна. Энэ үеэс эхлэн жил тутамд тус холбооны хурлыг хуралдуулж тагнуулын албадын тагнуулын ажилтны ёс

<sup>10</sup> Ms.DianeM.Janosek. The Role of Ethics Reform in Turkey’s Bid to Join the European Union. February 20, 2009. Ehtics in the Intelligence Community 2009.International Intelligence Ethics association.

<sup>11</sup> Michael Andregg. Ethics and Professional Intelligence.The Oxford Handbook of National Security Intelligence.Oxford University press. 2010. page 735-753.

зүйтэй холбоотой илтгэлийг хэлэлцдэг болжээ.

Тагнуулын ажил мэргэжлийн ёс зүйн шаардлага нь: Төр, нийгмийн төлөө үйлсэд үнэнч шудрагаар зүтгэх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж, үнэн сэтгэлээсээ үйлчлэн туслах, аливаа байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд эрх зүйн мэргэжлийн туслалцааг зохих ёсоор үзүүлэх, төр, нийгэм, улс, эх орон, иргэдэд харш аливаа хууль бус үйлдлийг үл тэвчиж түүний эсрэг тууштай тэмцэх, хууль ёсыг зөрчихөөс сэргийлэх, таслан зогсоох, төрийн нууцыг хамгаалах, хээл хахууль, авлига, албан тушаалаа хортойгоор ашиглах зэрэг зохисгүй байдал гаргахгүй байх, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, харилцааны соёлтой байх, биеэ зөв авч явах зэрэг хэм хэмжээг чанд сахих ёстой.

Тагнуулын ажилтан ёс суртахууны ямар нэг доголдолтой байх нь мэргэжлийн ажлаа зохих ёсоор явуулахад муугаар нөлөөлдөгийг практик харуулж байна. Иймд мэргэжлийн талаар сайн байхын зэрэгцээгээр ёс суртахууны хувьд төлөвшсөн, ажил, амьдрал, нийгэмд байр сууриа олж тогтворжсон байх явдал зайлшгүй чухал байдгийг санаж явах учиртай.<sup>12</sup>

“Сайн тагнуулч байя гэвэл нарийн үйл ажиллагааг найдвартай нууцалж, өрсөлдөгчийнхөө өмнө нэр хүндтэй байж, итгэл найдвар олж, аль болох өндөр мяндаг тушаалтан, дээгүүр зиндааныхантай түншилж,

<sup>12</sup> Ш.Лхагвасүрэн. Манай ажилтнуудын ёс зүй. Мэдээлэл. №2. УБ., 1997, т. 36-38

тэр хэмжээний мэдлэг боловсрол, гарын бэл бэнчин, бие сэтгэлийн тэвчээртэй, ухаалаг, тохиолдож болох саад бэрхшээлийг урьдаас харж байх бүрэн боломжийг тагнуулч хүн өөрөө л анхаарч гүйцэтгэх ёстой.<sup>13</sup>

Дээрх байдлаас үзэхэд тагнах ажиллагааг хуулиар зохицуулахаас гадна, хуульчилсан акт (Монгол Улсын жишгээр бол УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр), тагнах ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагын зохицуулалт (Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг тагнах ба гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагын дарга нарын тушаалаар баталсан дүрэм, заавар) дээр гарцаагүй тагнах үйл ажиллагаа ба гүйцэтгэх ёс зүйн зохицуулалт байгаа нь олон улсын жишгээр нотлогдож байна.

## ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын тагнуулын байгууллага, түүний ажилтны үйл ажиллагааг ёс зүйгээр зохицуулагддаг түүхэн уламжлалтай болох нь судалгаагаар нотлогдож байна.

2. Дэлхийн олон улсын тагнуулын байгууллагын үйл ажиллагаа хуулиар зохицуулагддаг болсноос гадна тагнуулын байгууллагын ажилтны үйл ажиллагаа ёс зүйн хэмжээгээр зохицуулагддаг болсон байна.

3. Гадаадын олон улсын тагнуулын албад хэлэлцэн тохирч 2004 онд “Тагнуулын ажилтны ёс зүйн холбоо” нэртэй төрийн бус байгууллагыг бий болгосон. Энэ үеэс эхлэн жил тутамд тус холбооны

<sup>13</sup> Г.Гончигдоо. Гадаадад үүрэг гүйцэтгэж явсан тагнуулчин. Мэдээлэл №3. УБ., 2002. т. 63

хурлыг хуралдуулж, тагнуулын албадын тагнуулын ажилтны ёс зүйтэй холбоотой илтгэлийг хэлэлцдэг болжээ. Холбогдох ном, сэтгүүл гаргаж, тагнуулын ёс зүйн судалгаагаар мэргэшсэн судлаачид, эрдэмтдийн бүтээлийг туршлага болгон тараадаг болсон.

4. 1990-ээд оноос хойш Монгол Улс ардчилсан тогтолцоотой орон болж Тагнуулын байгууллага олон тооны хууль, хууль тогтоомж, бусад эрх зүйн актаар үйл ажиллагаа нь зохицуулагдаж, ёс зүйн журам тогтоогдсон байхад ажилтнууд нь томоохон гэмт хэргийн субъект болох тохиолдол цөөн боловч гарч байгааг нь энэ чиглэлийн судалгаа хийх цаг болсныг харуулж байна.


## ГУРАВДУГААР РЕЙХЫН ХАЧИРХАЛТАЙ АЖЛУУД

**Докторант Ц.Насанбатын “Психотрон зэвсэг буюу сэтгэшэд нөлөөт үйлчлэл. Тусгай албадын нууц төслүүд” номноос цувралаар хүргэж байна.**

*Хаанаас мэдээлэл олж, хэрхэн ашиглахаа  
мэдэх мэдлэг нь амжилтын нууц юм  
А.Эйнштейн*

### “Эмгэг” сэтгэл хөөрөл ба медиум

Нацист Германы удирдагч Гитлер болон түүний дагалдагсад яаж



бүх германчуудыг бодитоор захирч, дуулгавартай байлгаж чадаж байсан нь сонирхолтой юм. Германы ард иргэдийн оюун санааг захирагч нацистуудын

хэмжээгүй эрх мэдлийн нууц юунд байв? Олонхи хүн эмгэг сэтгэл хөөрлөөс амжилттай эхэлсэн ухаалаг суртал нэвтрүүлгийн тухай мэдээж ярьдаг. Гэвч сүүлийн үед олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өөр шуугиан тарьсан таамаглал гарч эхлээд байна. Энэ таамаглалаар бол нацистууд нууц сэтгэцэд нөлөөт зэвсэг (СЭНЗ) хэрэглэн Германы хүн амыг нийтээр нь зомбичилж байсан ажээ. “Оюун ухааны нойр мангасыг төрүүлдэг” гэж ярьдаг нь учиртай байх.

Гитлер жирийн гэхээсээ илүүтэй

медиум шинжтэй хүн байсан бөгөөд өөрийн оюун санааны багш Карл Виллигутээс суралцахын зэрэгцээ 1920-оод оны үед нууц далд ухаан (эзотерик)-ыг сонирхох болсон байна.

*Лавлагаа: Тэр 1919 онд “Туле” хэмээх нууц бүлгэмд элсэж, 1921 онд Е.Блаватскаягийн “Нууц номлол” номтой танилцжээ. Нууц бүлгэмийн хамтрагчид нь немцийн ард түмний ирээдүйн удирдагчдаа дэлхийн нууц түүхийн тухай домгийг дуртайяа ярьж өгдөг байсан гэдэг. Дэлхийн соёл иргэншлийн нууц мэдээллийг агуулдаг гэгддэг санскритаар бичсэн баримт номнууд Германд ихээхэн үнэлэгддэг байв.*

Гэхдээ хэн ч Геббельсийн маш сайн зохион байгуулагдсан үзэл суртал үйлчилж байсныг үгүйсгэхгүй нь тодорхой. Фюрерийн удирдаж байсан хүчирхэг Вермахт (Зэвсэгт хүчин) Европт олон тооны гялалзсан ялалт байгуулж байсан ч Сталинградаас хойш огт өөр байдал үүсч эхэлсэн ба ялангуяа холбоотнууд Германы олон хотыг бөмбөгдөж, Улаан армийн ялалт авчирсан давшилтын дараа



байдал эрс өөрчлөгдсөн нь түүхийн үнэн бөгөөд Герман улс бүх талаасаа бүслэгдэн дайнд ялагдах нь хүүхдэд хүртэл тодорхой болсон байдаг.

Гэвч 1944 онд Германы нийт нутаг дэвсгэр даяар цэргүүдэд гуниг гутрал,

өөрийн фюрерт үг дуугүй захирагдаж байсныг харуулдаг. Үүний хамгийн тод жишээ бол 1944 онд хурандаа Штауфэнбергийн зохион байгуулсан Гитлерийг хороох хуйвалдааныг Германы ард түмэн сайшаан үзээгүй явдал гэрчилнэ.

Хүмүүс дээр анхны өргөн хэмжээний хүмүүнлэг бус, харгис туршилтыг ЗХУ-д ч, АНУ-д ч хийгээгүй. Психотроны технологийн өлгий нь нацист Герман гэж хэлэх бүрэн үндэстэй. Гитлер дээд хүмүүсийн нийгэм байгуулахыг

**Адольф Гитлер – мессия темных сил**

Клиф Алленс (Cliff Allen) – автор книги «Адольф Гитлер – мессия темных сил» (Adolf Hitler – the Messiah of the Dark Forces). Алленс – автор нескольких книг о политике и истории. Он утверждает, что Гитлер был послан на Землю из другой реальности, чтобы изменить ход истории. Алленс утверждает, что Гитлер был послан на Землю из другой реальности, чтобы изменить ход истории. Алленс утверждает, что Гитлер был послан на Землю из другой реальности, чтобы изменить ход истории.

Адольф Гитлер – мессия темных сил. Гитлер был послан на Землю из другой реальности, чтобы изменить ход истории. Гитлер был послан на Землю из другой реальности, чтобы изменить ход истории. Гитлер был послан на Землю из другой реальности, чтобы изменить ход истории.



айж мэгдсэн байдал ажиглагдахгүй байсан гэдэг. Үзэл суртал хуучин шигээ хүчтэй явагдаж бүгд ялалтанд итгэсэн хэвээр л байлаа. Ард иргэд цэргийн аж үйлдвэрт улайран ажиллаж, тэгээд бас ажлын чанар нь огт буураагүй байв. Хэрэв тэд дайнд ялагдвал бүгдийг нь сүйрэл, үхэл хүлээж байсан учир Германчууд улайрч байсан гэж олон хүмүүс үздэг. Гэвч логик зүй тогтлын дагуу сэтгэвэл хүн ялагдана гэдгээ мэдвэл сэтгэл санаагаар заавал унах ёстой. Гэтэл яг ийм үед Германчуудын сэтгэл санаа эсрэгээрээ маш өндөр байлаа. Эцэст нь дайны дараа явуулсан хараат бус судалгаануудаас үзэхэд 1945 оны 4 дүгээр сард Вермахт бут цохигдохын өмнөхөн ч гэсэн ялалтад итгэсэн хэвээр байсан нь тодорхой байдаг.

Германы арми ялагдсаны дараа холбоотнуудын гарт орсон нууц бичиг баримтуудаас харахад тэд ямар нэг хагас зомбичлолын байдалд байж



В члены клуба принималась только образованная элита общества

ной мебелью в стиле «ал-ля Ад» и называемый «Могил», затем жестоко высекали плетью, вывалили в жидкой грязи, заставляли лечь в гроб и в мельчайших подробностях рассказывать рыцарям ордена, облаченным в желтолуисские наряды, о своей сексуальной жизни, о самых потаенных своих желаниях и мечтах. А потом «рыцарям» дружно на вас помочились. Но и это еще не все – в конце сего действа вас ждёт не-  
Символ братства  
Символ братства – это череп и скрещенные кости. Символ братства – это череп и скрещенные кости. Символ братства – это череп и скрещенные кости.

тохиолдлоор оролдоогүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тэрээр: “...Үндэсний социализмаас зөвхөн улс төрийн хөдөлгөөнийг нь олж харж байгаа хүн түүний юуг нь ч ойлгоогүй гэсэн үг” гэж хэлдэг байсан нь түүний далд нууц ямар нэгэн санааг илтгэх мэт.

Улс оронд эрүүл саруул ухаан байхгүй болж ховсчид, хар дом шүтэгчид Туле, Хар нар, Берлиний




нийгэмлэг, Германы одон, Врилийн нислэг зэрэг нууц нийгэмлэгүүдэд харьяалагдаж, тэд удалгүй төрийн гол албан тушаалуудыг эзэлсэн байдаг. Тэдний үзэл суртлын үндэс нь Карл Ланц, фон Лист зэрэг гүн ухаантан эрдэмтдийн бүтээл байсан гэдэг нь ойлгогдож байгаа. Чухам эдгээр нийгэмлэгүүдийн зүгээс зэрэгцээ ертөнцийн “тамын” хүрээний үзэл санааг сурталчилж, интэнгүүдийн ухамсарт хоногшуулж байжээ.

*Давлагаа: Гитлерийг дурсахдаа олон хүн тцүний медиум чанарыг тэмдэглэдэг байв. Медиум бол ертөнцийн төрөл олоогүй (астрал ертөнцийн) амьтдын нөлөөнд орох хүртэл нэрвэгдсэн хүн гэдгийг эзотерик ухааны номд бичжээ.*

Сэтгэцийн паранормаль чадвар эзэмших эрмэлзэл нацист Германы элитийн нийгэмлэгүүдэд тодорхой биеллээ олж, юуны түрүүнд III Рейхын ирээдүйн толгойлогчид, дараа нь СС-ийн элит цэргүүд далдыг шүтэх, сэтгэцийн хүчийг хөгжүүлэх янз бүрийн дасгал, сургууль хийж байжээ.

Германы үндэсний социалист намын удирдагчид (нацистууд) ямар нэгэн дээд хүчнийхэн, эсвэл зөнч, зүүдэнд ирсэн эртний үндэстэн, эсвэл одноос ирэгчтэй харьцах гэж оролддог байсан гэсэн яриа өгүүлэл их байдаг. Германы цэргийн шилдэг, нууц технологиуд, хүн судлалын



мэдлэгүүдийг үнэндээ тийм эх сурвалжаас ухааж олсон гэлцдэг. Энэ бүгд байсан

гэдгийг одоо хүртэл баттай үгүйсгэсэн, эсвэл баталсан зүйл хараахан алга.

### Анэнербэгийн нууцлаг судалгаа

Германы иргэд бодит байдлыг эсрэгээр нь авч үзэж байсны шалтгаан юу байсан бэ? Үүний хариулт нь “Анэнербэ” (Өвгөдийн өв) бүлгийн хэрэгжүүлсэн сэтгэцийн нууц боловсруулалтад оршиж байсан гэж үзэх баримтууд гарч ирж байна.

Анэнербе (Ahnenerbe) - энэ бол нацист Германы хамгийн нууцлаг, хамгийн учир битүүлэг байгууллага байсан. СС-ийн бүрэлдэхүүнд албан ёсоор ордог, зарим эх сурвалжид бол түүний тархи байгууллага юм. Тэнд, бэлтгэгдсэн сайн мэргэжилтнүүд ажиллаж дүрслэл, дүрс бичиг, хэл судлал, арийчуудын түүх, эртний үндэстнүүдийн мэдлэгийг судлан санскрит хэлнээс орчуулга хийж, янз бүрийн үндэстэн омгуудын үлгэр домгийг хүртэл маш нарийн судалж, нууц мэдлэг, угсаатны зүйн судалгаа хийж байв. Чухам СС-ийн сайн санхүүжилтээр Төвд рүү олон удаагийн судалгааны ангиуд явсныг бид мэднэ. “Өвөг дээдсийн өв залгамж” байгууллагын нууцууд одоог хүртэл тайлагдаагүй, маш бага зүйл л мэдэгдэж байгаа. Дайны төгсгөлөөр СС-ийнхэн ихэнх архивын материалаа устгасан, эсхүл нуусан гэж Англи, Америк, Оросын цэргийн тагнуулынхан үздэг байна.

Хурандаа Вольфрам фон Зиверсийн удирдсан тус хүрээлэнгийн судлаач эрдэмтэд одоо их бичигдэж байгаа дэлхийн нэгдсэн энерги мэдээллийн талбайг тэр үед ойлгож эхэлсэн байдаг. 1942 оны 9 дүгээр сард


Германы алдартай эрдэмтдийн нэг Ханс Альтхофф “Анэнербэ” бүлгийн ухамсрын физикийн хүрээлэнд шилжин ирсэн бөгөөд энэ үед СС-ийн удирдагч Г.Гиммлер эрдэмтдийн өмнө: “...Хүмүүсийг дуулгавартай боол болгон хувиргах цоо шинэ зэвсэг зохион бүтээх ёстой” гэсэн үүрэг даалгавар өгсөн байна.

Анэнербэгийн боловсруулсан судалгаа, бичиг баримтууд аль хэдийнээс “нууц”-ын зэрэглэлтэй байсан боловч эдгээр баримтын нэг хэсэг нь азаар ил гарч 1990-ээд оноос Оросын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон номнуудад нийтлэгдэх болсон юм. Тухайлбал, эртний Германы Бурхадын дурсгалд зориулсан “Тоор” гэсэн төсөл хэрэгжиж байжээ. Эртний сурвалжит отгийн сүүлийн төлөөлөгчид болох Виллигут, Карл Мария нар энэ төсөлд маш чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Виллигут өөрийгөө эртний хаадын өв залгамжлагч гэж ярьдаг байв.

Виллигутын овог, гарал угсааны түүхийг Гитлер ихэд сонирхож байсан ч гол зүйл нь үүнд байсангүй, харин гэр бүлийг сахин хамгаалдаг ид шидийн хүснэгтэнд учир нь байв. 1941 онд Виллигут энэ санаагаа Гитлерт хэлжээ. Чухам эндээс л бүх хачин жигтэй зүйл эхэлсэн гэдэг. Ухамсрын физикийн хүрээлэнг удирдаж байсан Маур уг хүснэгтийг судалж үзээд энэ бол ид шидийн тэмдэг үсэг биш харин математик болон физикийн томъёо байна гэжээ. Эдгээрийн заримыг эрдэмтэд ямар ч төвөггүй ойлгож

байсан бол заримыг нь ойлгох түвшинд хүрээгүй байлаа. Энэ хүснэгтийн үндсэн дээр хүмүүст гипофизикийн аргаар үйлчилж дуулгавартай боол болгох пси-аппаратуудыг (психотрон зэвсэг) зохион бүтээх судалгаа, шинжилгээний ажил эхэлжээ. Маур туршилтыг нягт нямбай бөгөөд тасралтгүй хийж байсан ба дайны дараа тэдний зохион бүтээсэн багаж төхөөрөмжийн зураг, үйл ажиллагааг нь дүрслэн бичсэн материал олзлогджээ. Германы эрдэмтдийн судалж байсан хуйлрагч талбай (торсион орон)-н тухай санааг шинжлэх ухаанд гаргаж иртэл даруй 40 гаруй жил өнгөрсөн юм. Харин Анэнербэ энэ онолын судалгааг бүр дайнаас өмнө нээчихсэн бололтой. Гэвч нийтэд хэрэглэх зэвсгийг гаргахын тулд Германчуудад 10-аас доошгүй жил хэрэгтэй байв.

**Лавлагаа:** Улаан армийн 4-р гвардын механикжсан корпусын дарга, Германы Альтштат гэдэг багахан хотыг эзлэх үед тохиолдсон нэгэн явдлын тухай ийнхүү өгүүлжээ: “... хотын орчим бид маш хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. Бидний өмнө зөвхөн настай хөгшчүүд болон сургуулийн сурагчид байсан ч тэд эцсийн дусал цусаа дуустал тулалдаж байлаа. Тэр хотын архан талд байсан ойг дайснууд



маш идэвхтэйгээр хамгаалж байсан. Үүний шалтгаан бидэнд ойлгомжгүй байв. Энд сайн дурынхан, цэргүүд, мөн СС-ийн цэргүүд тулалдаж байсан.

*Манай эхний танкууд ойн зах руу цөмрөн орох цед ойн гүнд хэд хэдэн удаа хүчтэй дэлбэрэлт болсон. Дайснууд ямар нэг чухал объектыг дэлбэлж байна гэж надад санагдаж байлаа. Үүний дараа хуруугаа дохисон мэт байдал шууд өөрчлөгдөж нөгөө цэргүүд, сайн дурынхан нийтээрээ зэвсгээ буулгаж эхэлсэн юм“ гэжээ.*

Гэвч Зөвлөлтийн цэргийн шинжээчид уг сонин объектын зориулалтыг тухайн үедээ мэдэж чадаагүй ажээ. Орон нутгийн хүмүүс энэ явдал болохоос нэг жилийн өмнө СС-ийн цэргийн хүчээр тус объект байгуулагдсан гэж байв. Энэ үеийн гэрчүүдийн хэлснээр Германы бүх нутаг дэвсгэр дээр **сонин антеннууд бий болж** байсан ба тэдгээрийг хэн ч тайлбарлаж чадахгүй байжээ.

Нэлээд сүүлд Америкийн нэгэн физикч эрдэмтэн ийм төрлийн төхөөрөмж нь **хүний сэтгэл хөдлөлд, сэтгэцийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж чадна** гэж тайлбарласан байдаг. Ийм үйлчлэлийн үед уйтгар гунигаас өгсүүлээд хязгааргүй баяр баясгалан хүртэл янз бүрийн байдал үүсдэг ажээ.

Мөн 1930-аад оны орчим дэлхийд ганцхан байдаг сэтгэл судлалын хүрээлэн Германд байсан ба энд дорно дахин, дэлхийн бүх шилдэг мэдлэгийг өөртөө шингээсэн сэтгэцийн өөрөө тогтворжих Европын шинэ үзэл баримтлалыг үндэслэгч агуу их сэтгэл судлаач, ховсч Иоганн Шульц ажиллаж байв. 1932 онд хийсэн Шульцийн нээлт нь хүний организмын нөөц боломжийг ашиглах, нээхэд чиглэгдсэн зарчмын хувьд цоо шинэ хэлбэр болох аутореннинг

бүрэн төгс хийгдсэн ажил байжээ. Шульц өөрийн системдээ олон удаа давтсан үгийн ер бусын үйлчлэлийн тухай Францын судлаач Куэ-гийн нээлт, мэдрэлийн булчингийн хамгийн их сулралын үед хүлээн авдаг психофизиологийн өвөрмөц үйлчлэлийн тухай Америкийн судлаач Жейкобсоны нээлт, ухамсрыг өвөрмөц аргаар өөрчлөхөд бий болдог биеийн болон сэтгэцийн өвөрмөц үзэгдлийн тухай Энэтхэг, Төвд, Хятадын гэгээнтнүүдийн сургаал болон Дорно дахины гол гол амжилтуудыг оруулсан байв. И.Шульц өөрийнхөө нээлтийг **“Аутогенийн дасгал”** буюу **“ауто ховсын шинэ систем”** гэж нэрлэжээ.

Орчин үед АНУ, ОХУ, Франц, Их Британи, ХБНГУ, Хятадын тусгай албадын лабораториудад СэНЗ-ийн боловсруулалтыг хийдэг нь тодорхой байгаа. Тэд Анэнербэгийн санаачилсан ажлыг яг үргэлжлүүлж байгаа, үгүй нь тодорхой бус. Гэвч нацистууд хүн ард руу чиглэсэн зомбичлолын элемент хэрэглэж байсан нь тодорхой баримт юм гэж нэлээд олон судлаачид баталдаг.

Анэнербед маш жигтэй туршилт, судалгаа явуулдаг байжээ. Тухайлбал, тахилгын зан үйлийн судалгааг Германы дээд зэргийн физикчид явуулж, буддын тарнийг био орон зайтай холбон үзэж, чухам ямар тарни, ямар авиа хүний сэтгэлийн тэнхээг нугалж, нууц ухааныг дагахад бэлэн, дуулгавартай хувь хүн болгон хувиргаж болохыг судлах жишээтэй.

Гитлер шинэ, хүчирхэг ари үндэстэнг бүтээхийг хүсч байсан тул хөрөнгө мөнгө хайрлаагүй байна.

Зарим тооцоогоор тэр АНУ атомын бөмбөгийн судалгаанд зарцуулснаас хавьгүй их хөрөнгийг “хүний сэтгэцийг удирдах” судалгаанд зарцуулжээ.

Анэнербэгийн зохион бүтээсэн пси технологи нь хүний тархины “зоригийн талст” буюу өнчин тархины хэсэг дэх онцгой үүтгэлд чиглэгддэг. Тус нийгэмлэг ямар нэгэн “нууц мэдлэг”-ийг чимх чимхээр цуглуулдаг байв. Гадаад улс орныг эзэлмэгц нийгэмлэгийн тусгай анги СС-ийн цэргийн дэмжлэгтэйгээр бүх төрлийн номын сан, архив (хүүхдийн үлгэр, эртний гар бичмэл, шид тарнийн



ном судар, физик химийн лабораторийн судалгааны бүтээл)-ыг бүгдийг нь цуглуулдаг байжээ. Хачирхалтай нь Нюрнбэргийн шүүх хуралд эдгээр материалыг хэлэлцэхээс татгалзаж хав дарсан байдаг.

Тус нийгэмлэгийн шууд удирдлагаар нууц лабораториудад туршилт хийхийн тулд хорих лагериудаас “амьд эрүүл материал”-ыг нийлүүлдэг байжээ. Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэж харгис хэрцгий туршилт хийсний дүнд психотроникийн зэвсгийн анхны загваруудыг тэнд боловсруулсан гэлтэй.

**Хэтийг “мөрөөдсөн” бодит ажил**  
**Нууцлаг** Анэнербегийн бүрэлдэхүүнд физик, хими, сэтгэл судлал, парапсихологи, археологи гэх мэт ШУ-ны олон салбар чиглэлийн 50 гаруй хүрээлэн багтдаг байсан бөгөөд

дайны өмнө болон дайны үеэр их дээд сургууль, судалгааны хүрээлэнгийн олон тооны багш, эрдэмтэд нь нацистуудаас холдож гадаадад дүрвэн гарч явсны дараа ч гэсэн цэрэг, батлан хамгаалах салбартаа том том нээлтүүд хийж, түүнийгээ түргэн хугацаанд хэрэглээнд оруулж чадаж байсны учрыг судлаачид одоо хүртэл тайлбарлахыг оролддог.

Нисдэг тавагны тухайд бүр 1943 оны төгсгөлөөр Люфтваффын (Германы нисэх хүчин) техникийн академид ийм төхөөрөмж бүтээснийг нүдээр үзсэн гэрчүүд ярьсан байдаг. Энэ мэтчилэн санаанд оромгүй, сонирхолтой, бас шинжлэх ухаанд тухайн үедээ байж боломгүй гэж үздэг байсан олон төрөл чиглэлийн судалгааг СС-ийн хамгийн нууц байгууллага болох Анэнербэд явуулж байжээ.

*Лавлагаа: Оросын цэргийн тагнуулын дарга асан генерал Н.С.Батюшин “Цэргийн нууц тагнуул ба түүнтэй хийсэн тэмцэл” (1938 он, Лондон) номондоо Германы цэргийн яамны зэвсэглэлийн нууц тасгийн үйл ажиллагааны тухай ингэж бичжээ: “...1935 онд Хойд тэнгист туршсан удирдлагатай усан доорхи минаны төсөл; газраас удирдагддаг онолын хувьд 15000-20000 метрийн өндөрт хүрч ямар ч цэгт сумаа хаяж чадах стратосферийн нууц болговруулах; нисэх онгоцыг газраас хүчээр буулгах зорилгоор*



*радио долгионы тусламжтайгаар цахилгаан соронзон машиныг соронзлогдохгүй болгох зэрэг туршилтууд хийгдэж байна. Мөн ийм зайд байгаа модон байгууламжийг шатааж чадах “Үхлийн туяа”-ны туршилтууд явуулж байна” гэжээ.*

Вермахтын хувьд жинхэнэ “алуурчин цэрэг” бүтээх тусгай хөтөлбөр боловсруулагдаж байв. Цэргүүдийг огт ядрахгүй байж, биеэ бүрэн хянах, зэвсгээс гэмтэл авахгүй байх, өвтөлт мэдрэхгүй байх, дайсны ухамсрыг жолооддог ховс хийх чадвартай байх зэрэгт сургаж байсан гэдэг. Элит хэсгийн сургалтын гарын авлагад Төвдөөс авчирсан гар бичмэлүүд багтдаг байсан нь сонирхолтой. 1930-аад онд Төвдөд явуулсан экспедицүүд нууц ухааны тухай олон ном зохиолыг олж авчирсан байдаг. Тухайлбал “Виманика Шастра”, “Самаранга Сутрадхаран”-ыг нэрлэж болно. Эдгээр сударт юм бүхнийг шатаах аймшигт зэвсгийн тухай тодорхой зураглан өгүүлж, харийн орныг хэрхэн цус урсгахгүй аргаар эзлэх, бүх хүмүүсийг нь аз жаргалтай боол болгох тухай олон мэдээлэл агуулагдаж байсан гэдэг.

Германы цэргийн тагнуулын албаны дарга алдарт “дуугүй” хурандаа Вальтер Николай 1936 онд “Эзэнт улсын цэргийн яамны сэтгэл судлалын лаборатори”-ийг байгуулж тагнуулчийг сонгон авах, сургаж бэлтгэх шинэ хэлбэр, арга замыг тал бүрээс нь судлах ажлыг эхлүүлжээ. Эндхийн эрдэмтэд мөн зомбиг янз бүрийн эмийн тусламжтайгаар бий болгох, хүний тархинд радио долгионоор нөлөөлөх, мэдээллийг

телепат шугамаар хүний тархинаас шууд авах асуудал зэрэг маш олон судалгаан дээр 2000 гаруй эмч, мэргэжилтнүүд хамтран ажиллаж байжээ.

Вермахт болон СС-ийн сонирхож байсан бас нэг чиглэл бол психотропын буюу хүний сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэлийн судалгаа байлаа. Мансууруулах бодисыг хүний сэтгэцийн үйл ажиллагааг сэргээх буюу сааруулах, эсвэл сэтгэлийн зоригийг мохоох хэрэгсэл болгон ашиглах зорилтууд тавигдаж байжээ. Тухайлбал, “Дахау” хорих лагерьт ховс, психотропын бэлдмэлийн туршилт хийж байв. Мансууруулах бодисын нөлөөгөөр хоригдлууд өвдөлт мэдрэхээ больж, харааны өнцөг нь нэмэгдэж, ховсын үйлчлэлийн дүнд биеэ хэрхэн авч явах талаар итгүүлэгт бүрэн автаж, ямар ч эрүүл ухаангүй үхэр мал мэт өвс идэж байжээ. Энэ чиглэлээр доктор Фоль гэгчийн хийсэн судалгаа барууны тусгай албадынхны анхаарлыг ихээхэн татсан байдаг. 1935 онд Гитлер дайны зорилгоор ашиглах супер сэргээгч бодис олох ажлыг Гиммлерт даалгажээ. Ийм сэргээгч байвал цэргүүд эцэж цуцахгүй байлдах аж. Эртний Германы Тевтоны баатрууд “хув”-ыг маш гайхалтай ид шидтэй чулуу гэж үздэг байснаас санаа авч профессор Цау-гийн нууц лабораторид хувнаас сукцинат хэмээх бодис гаргаж 1938 онд туршилтад оруулахад сайн үр дүн үзүүлжээ. Дэлхийн хоёрдугаар дайны өмнө нацист Герман дайснуудынхаа таамаглаа ч үгүй байсан супер сэргээгч бодисын хангалттай нөөцийг бий болгосон байв.



“Освенцим”-ын хорих лагерьт хоригдлууд дээр хийсэн туршилтаараа хүний дотор эрхтэн болоод цацруулагч төхөөрөмж хоёрын хооронд резонанс үүсгэж болно гэсэн дүгнэлт хийж, түүнийгээ баталсан байдаг. Цацруулагчийг долгионы зөв хэлбэлзэл дээр тохируулсан үед хүнийг үхлийн

өвчнөөс ч ангижруулж болно. Энэ нээлтийн үр дүнгээс хорт



хавдрын эсэд нөлөөлөх судалгаа салбарлан явсан ажээ. Харин цацруулагчийн долгионы амплитутыг өөрчилбөл эв эрүүл хүнийг ч бүрэн өвчлүүлж болох талтай. Шинжлэх ухаан талаасаа үнэлж баршгүй боловч хүмүүнлэг бус гэдгийг энэ ажлыг судалсан Оросын эрдэмтэд цохон тэмдэглэжээ.


Түүнээс гадна угсаатны онцлогийг харгалзсан зэвсгийн тухай мэдээлэл ч олзны материалаас гарч иржээ. Тодорхой генүүдэд үйлчлэх зориулалттай тусгай төхөөрөмж дээр үндэслэсэн асар том хөтөлбөр бэлдэж байсныг дайны дараа л ЗХУ, АНУ-ын тагнуулын албад мэдсэн гэдэг. Фольийг АНУ-д аваачсан бол түүнтэй хамтран ажиллагч өөр нэг эрдэмтэн Манфред фон Арденийг Оросууд олзолжээ.

АНУ-ын “Military researchers” сэтгүүлийн 1999 оны дугаарт дайны дараа америкчууд Германы судалгаа шинжилгээний нууцад хүрч чадсан бөгөөд нацистын олон эмч, эрдэмтдийг АНУ-д аваачин ажиллуулжээ. Үүний дүнд “Paper clip” (Цаасны хавчаар)

гэсэн нууц төсөл гараагаа эхэлсэн билээ гэж бичсэн байна.

*Лавлагаа: Нацистын 600 гаруй эрдэмтдийг АНУ-д аваачин ажиллах, амьдрах таатай нөхцөлөөр хангаж, цөмийн физикийн, цэргийн техникийн, усанд шумбагч онгоцны, нисэх онгоцны болон пуужингийн технологийн нарийн судалгаа шинжилгээний ажилд хамруулжээ. Үүний дүнд АНУ зэвсэглэлийн нэн орчин цөийн технологийг бусдаас тирцүлэн эзэмшсэн юм.*

Нацист Германы эрдэмтэд акустик зэвсгийн асуудлаар мөн ажиллаж байв. Дуу авианы судалгааны хүрээлэнгийн доктор Ричард Валлаушек 1944 онд Тирол хотод Schallkanone буюу “Дуу авианы их буу” гэсэн төхөөрөмжийг зохион бүтээсэн байдаг. Парабол хэлбэрийн тусгалын төвд 3250 мм-ийн диаметртэй ноцоох системтэй инжектор байрлуулж, түүн рүү хүчилтөрөгч ба метан оруулна. Төхөөрөмж нь хийнүүдийн тэсэрдэг холимогийг тодорхой хугацаанд н о ц о о ж асааснаар нам давтамжийн тасралтгүй чимээ (тас няс хийх) үүсдэг.



Туршилтын үед төхөөрөмжөөс 60 м-ээс ойр зайд байсан хүмүүс ухаан алдан унаж зарим нь бүр үхэж байжээ. Гэвч Германд туршилт хийх хугацаа хангалттай байсангүй. 1945 оны 1-р сард судалгаа туршилт хариуцсан комисс Валлаушекийн ажлыг санхүүжүүлэхээ больсон байна.

1943 онд Германы Нисэх

хүчний техникийн академийн доктор Циппермайерийн удирдсан баг Windkanone буюу “Салхин их буу” төхөөрөмжийг зохион бүтээсэн байна. Хийн холимог болон хүчтэй шахсан цагираг руу орох шахагдсан агаарын хөдөлгөөн нь уг төхөөрөмжийн гол сүйтгэгч хүчин зүйл болж өгнө. Ийм цагирагуудыг тэнгэр рүү чиглүүлэн Америкийн онгоцыг сөнөөх боломжтой гэж үзэж байжээ. Туршилтын үед Циппермайерийн их бууны загвар нь 150 м-ийн зайд байгаа самбарыг зомгол болгон эвдэж байсан боловч Хиллерслебен хотын дэргэдэх буудлагын талбай дээр бүрэн хэмжээгээр нь байрлуулсан төхөөрөмжийн салхин цагирагнуудын цохилтын хүч түргэн суларч байна, эдгээр нь онгоцонд хохирол учруулж чадахгүй гэж Цэргийн нөөц бэлтгэлийн яам үзжээ. Доктор өөрийнхөө ажлыг дуусгаж чадаагүй бөгөөд Хиллерслебен хот удалгүй холбоотны цэргүүдэд эзлэгдсэнээр уг төслийн ажил зогсчээ.

### Гитлерийн психотрон зэвсэг

Нацистын эрдэмтдэд өөрийн болон эзлэгдсэн орнуудын хүн амын ухамсрыг нэлэнхүйд нь боловсруулах сонирхол байсан боловч тэдэнд цаг хугацаа хангалттай байсангүй. Хүний ухамсрыг удирдах өргөн хүрээний хөтөлбөрүүд боловсруулалтын шатандаа явж байтал дайн дууссан билээ.

1939 онд СС-ийн бүрэлдэхүүнд багтдаг Анэнербегийн дотор маш нууц байдалд сайн санхүүжсэн сэтгэл зүйн зэвсэг бүтээх болон хүмүүсийг зомбичлох ажлууд эхэлжээ. Түүхчид нацист Германд боловсруулагдаж

байсан “ТООР” төслийн тухай нууц мэдээллийг бага багаар нийтэлсээр байна. Энэ төслийн хүрээнд хүн амын ухамсрыг төөрөгдүүлэх аппаратыг зохион бүтээхээр ажиллаж байв.


Хүсэл мөрөөдлийн талст ууд (“Анэнербе”-гийн архиваас)

1944 онд Германы эрдэмтдэд ямар нэг хэмжээгээр

ажиллах чадвартай төхөөрөмжүүд байсан ба дайны төгсгөлд Германы нутаг дэвсгэр дээр хүн ам болон өөрийн цэрэг дайчдын сэтгэц ба ухамсарт нөлөөлөх 15 орчим станц ажиллаж цэрэг дайчдыг ялалтанд урам зоригтой болгох, удирдагчийг улайран шүтэх, ялалтанд хүрэх хүсэл тэмүүллийг нэмэгдүүлэхэд хандуулж байлаа.

Тэдний үйлчлэл нь юуны өмнө гипотезагийн хүрээний өвөрмөц мэдлэг болох “Эрх чөлөөний кристалл”, “Хүсэл мөрөөдлийн талст”-тай холбоотой. Түүхчдийн ачаар нацист Германы “ТООР” төслийн хүрээнд боловсруулагдаж байсан психотрон зэвсгийн тухай сонирхолтой мэдээнүүд нууц архиваас нийтэд танилцуулагдаж байна. Энэ тухай “Хас тэмдэгтэй чөтгөр. III Рейхийн хар шид” (фон Кранц Ганс-Ульрих) номноос олж үзэж болно.

*Лавлагаа: Гуравдугаар рейхад хүний ухамсрын хяналт, психотрон зэвсэг, харь гаригийнхантай хийж байсан уулзалт, тэднээс авсан байж болох нууц мэдлэг, техник*





*технологийн судалгааны тухай “АНЕНЭРБЭ-Наследие предков. Секретный проект Гитлера”, Г.Кранц, “Астронавты Гитлера”, А.Первушин, “Великие тайны загадки секреты III Рейха”, В.В.Ваденеев, “Мистические тайны Третьего рейха”, Ганс Ульрих Кранц, “Неизвестные летательные аппараты III Рейха”, В.Козырев, “НЛО земного происхождения от III Рейха до наших дней”, М.Козырев, “Оккультные тайны III Рейха”, П.Роланд, “Программы контроля разума в III Рейхе”, Паттон.Р, зэрэг номнууд байдаг.*

Энэ төсөл дээр ажиллаж байсан Германы эрдэмтэд 1944 оны төгсгөл гэхэд хүний сэтгэцэд зайнаас нөлөөлөх зарчмуудыг үндсэндээ олсон гэж үздэг. Эдгээр цацруулагчдын ачаар дайнд бараг ялагдаад байсан Германы цэргийнхэн байж боломгүйгээр амь биеэ үл хайрлан тулалдаж, ард иргэд үг дуугүй Геббельсийн сурталчилгаанд итгэж байсан байж болох талтай.

Харамсалтай нь одоогоор эдгээр мэдээллүүдийг батлах ямар ч баримт бодитойгоор гараагүй байна. Мэдээлэл хичнээн их чухал байх тусам түүний нууцлал улам бүр нарийсч зөвхөн шуугиан дэгдээж хажуугаар нь баяжих хүсэл нь түүхчдэд нэргүй эх сурвалжаас мэдээлэл гаргах сонирхол руу хөтөлж болохыг анхаарах нь зүйтэй.

#### **Гуравдугаар Рейхын өв**

Дайн дууссаны дараа 1945 онд америкчуудад атомын бөмбөг болон пуужингийн техникийг бүтээхтэй холбоотой архив олдсон бол харин оросуудад Германы явуулж байсан пси судлал, физиологийн туршилтын

баримтууд (нийтдээ 26 вагон материал Орос руу ачигдсан гэдэг) хураагдсан байна. 1930-1940-өөд оны үед сэтгэц, физиологийн шинжлэх ухааны судалгааны ажлууд маш их анхаарал татаж, Энэтхэг, Хятад, Төвд, Европ, Америк, Африк, Орост үзэгдээгүй хэмжээгээр дэлгэрч байсан билээ. Сэтгэл зүйн зэвсгийг бүтээх болон хүнийг зомбичлох ажиллагаатай холбоотой ихэнх нууц материалуудаа нацистууд дайны төгсгөл үед устгаж амжжээ.

Германчуудын явуулж байсан туршилтын тухай оросуудын хийсэн дүгнэлтэд: *“...Судалгааны зорилго: пси зэвсгийг зохион бүтээх ... хорих газруудын хоригдлууд дээр хийж байсан нууц туршилтауд нь онцгой чнэ цэнэтэй. Амьд хүмүүс дээр тийм харгис, хцнлэг бус судалгаа хийхийг олон улсын конвенц хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлдог. Иймээс дайны дараа эрдэмтэд амьд хүмүүс дээр тийм туршилт хийх эрхгүй болсон. Иймд өнөөдөр немцүүдийн судалгааны бүх материалууд нь хосгүй ховор ба шинжлэх ухааны хувьд үнэлэхийн аргагүй юм”* гэсэн байна.

Дараагийн дугаарт Оросын тусгай албадын нууц туршилтын талаар өгүүлэх болно.

Үргэлжлэл бий.

## Д.НАЦАГДОРЖ, Д.ПАГАМДУЛАМ НАРЫГ ТАГНУУЛЫН АЖИЛД АШИГЛАСАН УУ?

*докторант С.Баттогтох*

Ардын хувьсгалтай зэрэгцэн эхэлсэн Оросуудын хэлмэгдүүлэлтийн бодит байдлыг дурдвал, Оросын сургагч, зааварлагч нар анх Монголчуудыг 10, 20-иор нь, тухайлбал, 1922 онд “Бодоогийн хэрэг” гэгчээр 14 хүнийг буудаж байсан бол 1934 онд “Лхүмбийн хэрэг” гэгчээр 100, 150-аар нь буудах болсныг үзвэл дараагийн хэрэг гэгчээр хэдэн 1000-аар нь буудаж магадгүй байв. Тэгвэл Монголын эрчүүд бүгд буудуулах аюул нүүрлэж байлаа. Тэгэхээр Монголын удирдагчид энэ их аюулыг хэрхэн зайлуулах арга замыг эрэлхийлсэн бололтой байна.

Ийм арга замыг эрж хайсан нь Ардын хувьсгалын удирдагчид болох Д.Бодоо, Д.Сүхбаатар, С.Данзан, VIII Богд Жибзундамба хутагт нарыг алдсаны дараа 1925 оноос эхэлсэн гэж үзэж болохоор байна. 1925 онд Амар сайд Бээжинд очоод, Зөвлөлт ба Коминтернээс дагалдуулсан 2 хүнийг буцаачихаад, Германы Элчин сайдтай уулзсан ба үүний дараа Монголын охид, хөвгүүдийг Германд суралцуулж эхэлсэн боловч харамсалтай нь “Зүүнтэн” гэх Оросын тоглоомын этгээдүүд төр, засгийн удирдлагад гарч ирэн, тэдний сургуулийг төгсгөлгүй татан авчирч, Монгол-Европын сайн харилцааны эхлэлийг тасалсан юм. Германд

суралцагчдын нэг Д.Нацагдорж тэдний сургуулийг нь төгсгөлгүй авчирсанд ихэд харамсаж байв.

Ер нь Орост нөлөөлөх хүчийг Европоос хайсан нь анх Олноо өргөгдсөн Монгол Улс байгуулагдсан үеэс эхэлсэн бөгөөд хамгийн түрүүнд харилцаа тогтоох орноор эхнээсээ л Германыг сонгосон нь 1912 онд Олноо өргөгдсөн Монгол Улсын Гадаад хэргийн сайд Чин ван Ханддорж Хаант Орост айлчлахдаа Европын улсуудын Элчин сайд нартай уулзах хүсэлт тавьсанд Германы Элчин сайдаас бусад нь татгалзсан хариу өгсөнтэй холбоотой. Харин Германы Элчин сайдтай уулзахыг Ханддорж ванд Оросын ноёд зөвшөөрөөгүй юм.

Эдгээрийг дурдахын учир гэвэл, 1937 оны их хэлмэгдүүлэлтийн аюулыг урьдаас мэдэрсэн Монголын удирдагчид түүнийг зогсоох арга замыг хайхдаа Д.Нацагдоржийг эртнээс бэлтгэн Германд нууцаар гаргасан байж магадгүй гэсэн баримтат таамаг дэвшүүлсэнээ дахин нэг бататгах гэсэнд юм. Үүний урьд, Д.Нацагдоржийг ямар арга хэлбэрээр бэлтгэж, хэрхэн нууцаар хил нэвтрүүлэн гаргасан тухайд баримтат таамаг дэвшүүлсэн хэд хэдэн богино өгүүлэл бичиж, хэвлэлд нийтлүүлсэн билээ. Энэ удаад Д.Нацагдоржийг бэлтгэх, илгээх ажиллагаанд

түүний эхнэр асан Д.Пагамдуламыг оролцуулсан байж болох тухайд баримтат таамаг дэвшүүлсэн богино өгүүллийг толилуулж байна.

Д.Нацагдоржийг Орос, Хятад алиных нь ч хардлага сэрдлэггүй хилийн чинадад гаргах арга хэмжээг далдлах үйл явдлууд нь Д.Нацагдоржийн “үхэл”, түүний “оршуулга” байсан ба түүний “оршуулагч”-ийг мөн урьдчилан бэлтгэжээ. Үүндээ чухамхүү Д.Пагамдуламыг сонгож, Д.Нацагдоржийн нэгэн адил шоронд бэлтгэсэн гэж үзэж болохоор байна:

а. Д.Нацагдоржийг хилийн чинадад гаргах арга хэмжээнд шаардлагатай мөнгө хөрөнгийг төсвийн бус аргаар олж бүрдүүлэх нь уг арга хэмжээний нууцлалаас урган гарсан. Д.Пагамдулам Хятадуудаас хууль бусаар их хэмжээний мөнгө авахын тулд тэдэнд хуурамч баримт бичиг хийж өгсөнийхөө төлөө шоронд хоригджээ. Шоронд байхдаа ч хоригдол хятадуудаас их хэмжээний мөнгө авах гэмт үйлдлээ үргэлжлүүлж, ялын хугацаагаа сунгуулж байсан;

б. Тухайн үед Дотоодыг хамгаалах газрын харьяанд байсан “Засан сайжруулах” буюу Хорих ангийн дарга нь “хоригдол” Д.Пагамдуламд ихээхэн итгэл үзүүлж, уг хорих ангийн бичгийн машины бичээчээр ажиллуулж, нууц бичиг хэргээ хүртэл түүнд хариуцуулан, хагас, бүтэн сайн өдрүүдэд гэрт нь гаргаж “амруулдаг” байсан. Д.Пагамдулам өөрөө энэ байдлаа “Хорих ангийн даргатай садар самууны холбоотой” гэдгээр “ичгүүр сонжуургүй” тайлбарладаг

байсан нь мөн л арга хэмжээний нууцлалтай холбоотой байв;

в. Архинд шатсан Д.Нацагдоржийн шарилыг 2 өдөр дараалан 2 удаа оршуулсан дам мэдээ бий. Эхний өдөр 1 дэх удаа Д.Нацагдоржийн “шарил”-ыг Д.Пагамдулам ганцаар авч явж оршуулсан. Дараа өдөр нь 2 дахь удаад “шарил”-ыг хятад морин тэргэч зэрэг 3-4 хүн авч явсаны дотор ДХГ-ын ажилтан ч байсан. Эл “шарил”-ыг Д.Нацагдоржийн ойр төрлийн хүмүүст үзүүлэхэд дээл, малгай, гутал хувцас, гартаа барьсан трубка-гаанс нь хүртэл Д.Нацагдоржийнх мөн байсан боловч уг шарил толгойгүй, гар нь Д.Нацагдоржийнх биш байсан. Үүнээс үзэхүл, Д.Пагамдулам яалт ч үгүй Д.Нацагдоржийг “оршуулах” нэрээр авч яваад хувцасыг нь сольж авчирсан байж болох ба тийм бол түүнийг нууцаар гадаадад явуулах ажиллагаанд тэр оролцсон болж таарч байна.

Төгсгөлд нь, энэ арга хэмжээний удирдагч, хэрэгжүүлэгч нарын сонголт яагаад гагцхүү Д.Нацагдорж дээр буусныг тодруулан авч үзье. Ер нь эхнээсээ ганц Д.Нацагдоржийг л нүдэлчихээгүй нь мэдээж. Байгаа баримтуудаас эргэцүүлэн харахад, эхлээд 3-4 хүн дотроос Мэргэн гүн Гомбожав, тайж Д.Нацагдорж хоёрыг ялган авч судалсан байна. Тэрхүү хоёр нэр дэвшигчийг харьцуулан судлахын тулд “асуултын жагсаалт” гаргасан бололтой. Өнөөгийн байр сууринаас харвал, тэнд хэнд ч, юунд ч хэрэггүй хачирхалтай асуултууд байв. Тухайлбал, “Архийг аль хэр уудаг вэ?” гэсэн асуулт байна. Энэ

асуултад М.Гомбожавыг “бага уудаг”, Д.Нацагдоржийг “үлэмжуудаг” гэжээ. Хэрэв эцсийн сонголт Мэндбаярын Гомбожав дээр буусан бол тэр ямар дүр эсгэх байсныг таах аргагүй. Харин сонголт Дашдоржийн Нацагдорж дээр буусан учраас түүнийг “архинд шатаад үхчихлээ” гэхэд бусад бүх хүн эргэлзэж гайхахгүй итгэх архичны дүрд тоглуулжээ. Ингэж итгэлтэй хэлж болохуйц баримт ч байна. Тэр үед “архины мөнгөө хүнээс гуйдаг” болтлоо ядуурсан Д.Нацагдорж одоогийн Дүрслэх урлагийн музейн баруун урд байрлах хуучин “Ард” кино театрын тэнд байсан 2 давхар “Континентал” зочид буудалд байрладаг байжээ. “Ядуу архичин” Д.Нацагдорж тэндээс хөөгдчихөлгүй, буудлын төлбөрийг яаж төлдөг байсан нь анхаарал татдаг. Эргэцүүлэн бодвоос энэ бүхнийг Дотоодыг хамгаалахынхан зохицуулдаг байсан бололтой.

Мэргэн гүн Мэндбаярын Гомбожав яагаад эцсийн сонголтод үлдээгүй тухайд, Д.Нацагдоржтой нийлж наргиж цэнгэдэг залуусын нэгэнд М.Гомбожав ч ордог байсан юм. Тэдний дунд бас хоёр гуравхан ч биш хүүхнүүд ирдэг байжээ. Нэг их удалгүй М.Гомбожав тэдний нэгтэй гэр бүл болсон нь Хаант Оросын үеэс Монголд суусан Цогтбадамжавын нэг охин байв. Ингэснээр М.Гомбожав Оросынхны хараанд орлоо гэдгийг ухаарсан Дотоодыг хамгаалахынхан түүнээс зай барьж холдсон нь ойлгомжтой хэрэг юм.

## ДОТООДЫГ ХАМГААЛАХ ГАЗРЫН ТӨВ СУРГУУЛИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ (1934-1940 ОН)

---

*доктор, дэд профессор Д.Авирмэд*

**Товч агуулга:** 1930-аад оны эхэн үед олон улсын нөхцөл байдал хурцадсан нь монголын гадаад, дотоод орчинд нөлөөлж, олон удаагийн бослого, хөдөлгөөн, тэмцлүүд гарах болсноор хууль, хүчний байгууллагуудыг бэхжүүлэх шаардлага гарсан байна.

Энэхүү нөхцөл байдлын өөрчлөлттэй холбогдуулан тэдгээр байгууллагуудыг үндэсний хэмжээнд мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлэх, сургах, мэргэшүүлэх ажлыг өнөөгийн Тагнуулын академийн эх үүсвэр болсон Дотоодыг хамгаалах газрын Төв сургууль хэрэгжүүлж иржээ.

**Түлхүүр үгс:** Төв сургууль, Хязгаарын ба гүйцэтгэх сургууль, Дотоодыг хамгаалах газар, сургалт.

**Brief:** Mongolian internal and external situation affected by the international drastic changes in early 1930s. Multiple demonstrations and conflicts raised during the period that required to strengthen law enforcing agencies. Central school of Homeland Security Agency implemented the role nationwide to provide trained and specialized professional employees for these agencies due to the changing situation. This Central school was the origin of nowadays National

Intelligence Academy.

**Key words:** Central School, Homeland Security Agency, National Intelligence Academy, training.

Түүхийн баримт бичгүүд болон судлаачдын бүтээлүүдэд эл асуудлыг “Төв сургууль”, “Хязгаарын сургууль”, “Хязгаарын ба гүйцэтгэх сургууль” гэх зэргээр нэрлэж ирсэн байна. Энэ нь угтаа бол нэг ойлголтыг хэд хэдэн янзаар тайлбарлан ойлгож ирсэнтэй холбоотой юм.

Ер нь тус сургуулийн үүсэл, хөгжлийн асуудлыг тухайн үеийн монголын гадаад, дотоод нөхцөл байдлын өөрчлөлттэй холбон авч үзэх шаардлагатай.

Уг асуудлыг хөндөн гаргаж ирснээрээ олон асуудалд хариулт өгөхийг оролдож, шинэ шинэ баримт сэлтүүдийг гарган судалгааны эргэлтэд оруулж, тусгай дээд боловсролын байгууллагын болон эрх зүйн боловсролын түүх судлалд тодорхой ахиц гаргана гэдэгт найдаж байна.

Судлаач миний бие өгүүллээ 1-рт тухайн үеийн монголын гадаад, дотоод нөхцөл байдлын өөрчлөлт, 2-рт түүхэн зурвас үед ДХГ-ын Төв сургуулийн үүсэл хөгжлийн тухай

асуудал, 3-рт товч дүгнэлт гэсэн хэсэгтэйгээр бэлтгэсэн бөгөөд эдгээр асуудлуудад зөвхөн судлаачийн үүднээс хандсан санаа, бодлоо та бүхэнтэй хуваалцахыг зорьлоо.

### **Нэг. Тухайн үеийн монголын гадаад, дотоод нөхцөл байдал**

1930-аад эхэн үед олон улсын нөхцөл байдал хурцдаж, Ази, Европын ихэнхи улс орнууд эдийн засгийн хямралд орж, хоорондын зөрчил нь ихээхэн хурцадсан юм. Тэдгээрээс Герман, Итали, Япон улс нь эдийн засгийн хямралаас тогтсон хүнд байдал, дотоодын зөрчлөө гадагш түрэмгийлэл хийх замаар намжаах гэж оролдох болсон нь Ази, Европт дайны шинэ голомтуудыг бий болгожээ. Дэлхийн I дайны дараах арван жилийн дотор өрнөдийн орнуудын хүчний харьцаа дахин өөрчлөгдөж, Герман, Япон, Итали улсуудын зүгээс дэлхийг дахин хуваахыг эрмэлзэн дайнд бэлтгэж эхэлсэн нь олон улсын байдлыг улам хурцатгаж байв. Энэ нь хөрш зэргэлдээ ЗХУ болон БНМАУ-ын гадаад байдал түгшүүртэй болсны гол шалтгаан болсон юм. Нөгөө талаар юуны өмнө 1920-иод оны сүүл 1930-аад оны эхэн үеийн Гоминьданы Хятад, Японы Зүүн хойт Хятад, Манжуур, Өвөр Монголыг эзлэн түрэмгийлэх бодлоготой холбоотой байлаа.

Ялангуяа 1930-аад оноос Япончууд тус улсын зүүн хязгаараар өдөөн хатгалга хийх, тагнан турших, хорлон сүйтгэх элдэв арга явуулгаа улам идэвхжүүлэн цэргийн хүч хэрэглэхээр бэлтгэж байсан. Мөн тус улсын баруун хязгаарын зарим

газраар хасагийн зэвсэгт дээрэмчид хил зөрчин орж ирж, хилийн ойролцоо нутаглаж байсан монгол иргэдийн мал хөрөнгийг дээрэмдэн, хүний амийг бусниулах явдал удаа дараалан гарч тухай бүр монголын хилчдэд цохигдон буцаж байв.

Тухайн үед Хятадад ёс төдий захирагдаж бие даасан эрхтэй байсан Шиньжанд тэгш эрхийг хангасан ардчилсан хувьсгалт тусгаар тогтносон улс байгуулахыг дэвшилт ардчилсан хэсэг нь зорих болсны зэрэгцээ тус мужийг Хятадын захиргаанд бүрэн оруулж, БНМАУ-ыг баруун талаас нь довтолох түшиц газар болгохыг Гоминьданы эрх баригчид хичээж Нинся ба Гансуй мужуудын хуйхуу цэргийн генерал Ма Чи, Ма Вошиян, Ма Хангуй нарт үүрэг болгож байжээ.

Үүнээс үүдэн Монголын баруун хязгаарын нөхцөл байдал хүндхэн болсон бөгөөд ер нь Монголын эрх баригчид баруун талаарх Хятадын цэргийн түрэмгийлэл, халдлагын эсрэг гол бамбай нь Шиньжан гэж үзсэн байна.

Тиймээс ч Гоминьданы эсрэг тэмцэж буй Шиньжаны үндэсний эрх чөлөөний тэмцэл, хөдөлгөөнд Монгол тусалж байсан ба тэд ч МАХН-ын Төв Хороотой харилцаа тогтоож, тусламж хүсч байжээ.

Монголын дотоодод төр, засгийн буруутай бодлого, үйл ажиллагааны улмаас 1930 онд Төгсбуянт, Улаангомын хүрээний лам нарын бослого, 1932 оны зэвсэгт бослого, дүрвэх хөдөлгөөн зэрэг үйл явдлууд өрнөх болсон юм.

Энэхүү дотоодын нөхцөл байдалтай уялдуулан нам, төрөөс

улсын батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэхийн зэрэгцээгээр улсын хил хязгаарыг хамгаалах асуудалд ихээхэн анхаарч хилийн отряд, заставуудыг нэмэн байгуулж, үндсэндээ 1932 онд Цагдан сэргийлэх байгууллага, 1933 онд улсын хилийн хамгаалалтыг Дотоодыг хамгаалах газарт хариуцуулав.

### Хоёр. ДХГ-ын Төв сургуулийн

#### үүсэл хөгжил

Дотоодыг хамгаалах газар нь эхэн үедээ өөрийн гэсэн сургалтын байгууллагагүй байсан учраас албан хаагчдаа сургаж бэлтгэх ажлын анхны хэлбэр нь ЗОУ-ын тусгай албаны ажилтныг дагалдуулан сургах сургалт байсан. Тухайлбал, Д.Сүхбаатараас ДХГ-ын анхны сургагч Матрон (Сорокин) Д.И-д “ДХГ-ын ажилтнуудын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд ЗОУ-ын Аюулаас хамгаалах байгууллагын ажлын туршлагаас монголын нөхцөлд тохируулан хэрэглэх”-ийг зөвлөж байв. Сургалтын энэ хэлбэрийн хүрээнд зөвлөх, сургагч нар 1932 оноос эхлэн долоо хоног бүрийн мягмар, пүрэв гаригт тагнуулын ажилтанд ажлын зааварчилга өгч, Дотоод явдлын яамны Төв сургуульд хичээл заах болжээ. Сургалтын 2 дахь хэлбэр нь тэнхимийн сургалт байсан. Түүнийг Намын төв сургуулийн дэргэд ДХГ-ын ажилтан бэлтгэх курсийг 1925 онд нээснээр эхэлжээ.

1933 онд Ардын Сайд нарын Зөвлөлөөс баталсан “БНМАУ-ын ДХЕГ-ын дүрэм”-ээр тус газарт “Тус улсын албан ба цэргийн газруудад хэрэглэх шинэ хүчнийг бэлтгэхийн

тулд богино хугацааны шифрийн түр сургуулийг үе үе байгуулах”, “хязгаарыг хамгаалах цэрэг ба тус газрын цэргийг байгуулж сургах, хүмүүжүүлэх алба ажлыг явуулах”<sup>1</sup> эрх олгожээ. Эрх зүйн энэ заалтыг үндэслэн ДХЕГ-ын даргын 1933 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 207 дугаар тушаалаар Улаанбаатар хотод “Төлөөлөгчдийг давтан боловсруулах түр сургууль” байгуулж, тусгай, улс төр, эдийн хэлтсийн чиглэлээр тус бүр 3 сарын хугацаагаар хичээллүүлэх болжээ. 1933 оны 12 сарын байдлаар түр сургуульд Цог-Очир, Осорбазар, Дэндэв, Готов, Бизьяа, Түвшинжаргал, Шуумаржав нарын 27 хүн суралцаж төгссөн байна.

1934 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 48 дугаар тушаалаар ДХГ-ын ажилтны цэргийн хэргийн боловсролыг дээшлүүлэх дугуйлан, мөн оны 3 дугаар сард 164 дүгээр тушаалаар орос хэлний орчуулагчийн сургууль, мөн оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 573 дугаар тушаалаар “Хил хязгаар хамгаалах шинэ хүчнийг бэлтгэн гаргах” нэг жилийн сургалттай “түр курс”-ийг тус тус байгуулж, энэхүү сургалтын тогтолцоог байнгын болгох зорилгоор Сайд нарын Зөвлөлийн 1933 оны 8 дугаар нууц тогтоолыг үндэслэн 1934 оны 12 дугаар сарын 6-нд ДХЕГ-ын даргын 994 дүгээр тушаалаар уг сургуулийг “ДХГ-ын Хязгаарын ба гүйцэтгэх ажилтанг бэлтгэх төв сургууль” болгосноор эрх зүй-гүйцэтгэх ажлын мэргэжил олгох сургалт явуулах болсон. Өөрөөр хэлбэл, өнөөгийн Үндэсний тагнуулын

<sup>1</sup> УАХБ-ын түүхэнд холбогдох баримт бичгүүдийн эмхтгэл. УБ., 1977, т. 37



академийн тагнуул, гүйцэтгэх ажлын мэргэжил олгох сургалтын тогтолцоо нь чухамхүү энэ үеэс тавигдсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй бөгөөд эрх зүйн мэдлэг, мэргэжил олгох сургалт нь тагнуул, гүйцэтгэх ажил дээр суурилж цаашдын бие даасан хуулийн сургууль болох нөхцөлийг бүрдүүлжээ.

Төв сургуулийг Улаанбаатар хотын ойролцоо “Их наран” гэдэг газар буюу “Орбит станц”-ын байгаа газар анх байгуулсан бололтой байна.

Анх байгуулагдсан тус сургууль нь 60 орчим сурагчтай 3 салаатай байгуулагдсан бөгөөд захирал нь хурандаа Галсан 150 төгрөг, улс төрийн туслах нь Чойжилжав 130 төгрөг, жагсаал ангийн туслах Артаасэд, сургагч Петров (Кошёк) 400 төгрөг, аж ахуйн дарга Баярхүү 70 төгрөг, тусгай багш Гомбо 170 төгрөг, орчуулагч Довжеев (Дөчөөд оны үед намын шинэ хүчний дээд сургуулийн захирал байсан) 200 төгрөг, эх зохиогч, мөнгөний нярав Цэрэндорж 70 төгрөг, 1-р салааны даргаар эхлээд Балдан дараа нь Банзрагч 70 төгрөг, 2-р салааны даргаар Дэндэв 70 төгрөг, 3-р салааны даргаар Магсаржав 70 төгрөг, нягтлан бодох Гаваа 80 төгрөг, хоол хувцасны түгээгч Банзрагч 70 төгрөг, машины бичээч Норжмаа 100 төгрөг, тогооч Базшир 100 төгрөг, мөн Ёндон 100 төгрөг, цэвэрлэгч Жигмид 65 төгрөг, мөн Бат-Очир 65 төгрөг, сурагчид 80 төгрөгийн цалинтайгаар тус тус ажиллаж байв.<sup>2</sup>

Хязгаарын ба гүйцэтгэх ажилтанг бэлтгэх төв сургууль нь дотроо ДХГ-ын албан хаагчдыг өсвөр наснаас нь эхлэн бэлтгэх Бага сургууль,

ДХГ-ын ба гүйцэтгэх ажилчдыг бэлтгэх сургууль гэсэн 2 бүрэлдэхүүн сургууль байсан ба Бага сургуулийн даргаар Лодойн Цэрмаа, Намдагийн Намжилдорж нарын 10 хүн 1935 оны байдлаар ажиллаж байжээ.

Төв сургууль нь анх байгуулагдах үедээ 60 орчим сурагчидтай байсан бол жилийн дараа гэхэд гүйцэтгэх тасгийн 1, 2 жилийн, жагсаал тасгийн 1, 3 жилийн анги, I, II групптэй, нэг анги дунджаар 25, бүгд 150 сурагчидтайгаар хичээллэх болов.

Сургуулийн сурагчдын бүрэлдэхүүний байдлыг авч үзвэл, тухайн үеийн сургалтын хэрэгцээ шаардлагыг үндэслэн хилийн цэргийн офицер, улсыг аюулаас хамгаалах байгууллагын ажилтан, нам, улс олон нийтийн байгууллагад ажиллаж байсан цэрэг, улс төр, ерөнхий боловсролын анхан мэдлэгтэй хүмүүс нилээд байв. Жишээлбэл, Хилийн отряд, заставт дарга, улс төрийн ажилтнаар ажиллаж байгаад ирсэн Довдой, Борын Цэвэгжав, Бөө, Дамдиндорж, Цэдэндамба, Маналжав, Дотоодыг хамгаалах газрын харьяа байгууллагад ажиллаж байсан Санжмятавын Намсрайжав, Мятавын Бадамбазар, Гомбодорж, орон нутгийн засаг захиргаа, соёл гэгээрлийн байгууллагуудад хариуцлагатай ажил хийж байсан Гүржав, Далхжав, Жадамба, Төмөр, Лувсандамба зэрэг хүмүүсийг дурдаж болох юм.

Тухайн сургуулийн сургалтын хугацаа богино байсан боловч үзэж судлах хичээлийн сэдэв нь их өргөн хүрээтэй байсан нь дараах хичээлийн сэдвүүдээр нотлон харагддаг.

- Цэргийн эрдмийн хичээл (галт

<sup>2</sup> ТЕГ.ТА. Сан-1, Хөмрөг-10, Д-55, Хн-9, т. 1

- зэвсэг, буудлага, жагсаал, хими, тактик, морин сургууль, биеийн тамир гэх мэт);
- Улс төрийн хичээл (нам ба улсын түүх, нам засгийн цаг үеийн бодлого гэх мэт);
  - Ерөнхий эрдмийн хичээл (төрөлх хэл, бичиг, тоо бодлого, газар зүй, байгаль, хими, физик гэх мэт);
  - Хууль цааз, хилийн алба, гүйцэтгэх ажлын тусгай хичээл;
  - Авто машины жолооны ба галын аюулаас сэргийлэх асуудал зэрэг хичээлүүд заагдаж байв.

Жагсаал тасгийн 1 жилийн ангид орох хичээлийн цагийн байдлыг авч үзвэл: тоо бодлого 27 цаг, дэлхийн байдал 22 цаг, түмэн бодис 26 цаг, хими 28 цаг, хэл бичиг 34 цаг, хүнд пулемётын 15 цаг, винтовын 6 цаг, хөнгөн пулемётын 8, акааны 8, докторын тухай 24, дүрмүүд 16 цаг, нийт 199 цагийн хичээл орж байжээ.<sup>3</sup>

Түүнчлэн суралцагсдын тоо, багшлах бүрэлдэхүүний хүрэлцээнээс шалтгаалан тус сургуулийн багш нараас гадна Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Лувсандорж, Шүүх яамны хэлтсийн дарга Гүрсэд, Улсын бага хурлын даргын нарийн бичгийн дарга Өөлдийн Чимид, Багшийн сургуулийн багш Буддарь, Намын сургуулийн багш Цэвэгжав, Дотоодыг хамгаалах газрын хэлтсийн дарга нар болох Тогоо, Самдан, Н.Насантогтох, С.Галиндэв, Л.Рэнцэн, Ч.Мандал, Зөвлөлтийн мэргэжилтэн Кичиков, Алексеев, Кошёк зэрэг багш нар нэмж хичээл

зааж байсан байна.

Төв сургуулийг хаана хаана байр сэлгэж явсан талаар тодорхой баримт олдохгүй байгаа бөгөөд энэ талаар 2-р салааны сурагч байсан Бүтэмжийн Дүйнхоржав, Хорлоогийн Санжмятав нар 1973 оны 3 дугаар сарын 15-ны өдөр: “Сургууль нь 1934 оны намар их Нарангийн зуслангаас Улаанбаатар хотод ирж тэр үед хятад иргэдийн хороолол байсан хятадын 9 гудамжны 4-р гудамжны нэгэн хашаанд байрласан юм. Энэ хашаан дотор хятад маягийн хэд хэдэн дан шавар байшин байсан бөгөөд түүнд сурагчид байрлан, гал тогоо, хичээлийн анги танхимүүд байв. Мөн хашааны дунд нь байсан жижиг хоёр давхар шавар байшинд сургуулийн штаб байрлаж байв.” гэж дурсан ярьсан байдаг.

Төв сургууль нь 1935 оны 7 дугаар сард анхны төгсөлтөө хийсэн бөгөөд шалгалт өгсөн бүх сурагчдаас 15 сурагч онц сайн дүн үзүүлэхэд Дотоодыг хамгаалах газрын даргын тушаал гарч сургуулийг амжилттай төгссөнийг тэмдэглэн баяр хүргэж үнэмлэх олгож байжээ.

Үнэмлэхний утгыг сийрүүлвэл: “Хорин таван оны 7 сарын 17. ... аймгийн, ... сумын, ... багийн ... бол Дотоодыг хамгаалах газрын Хязгаарын ба гүйцэтгэх ажилчдыг бэлтгэх сургуульд нэгэн жилийн хугацааны дотор суралцсан болох тул тэмдэг дарсан үнэмлэх бичиг олгов. Захирал Галсан, жагсаал ангийн туслах Артаасэд, улс төрийн туслах Чойжилжав, сургагч Кошёк” гэжээ.

ДЯЯ-ны харъяа хязгаарын ангиудын улс төрийн ажилтны орон тоог нөхөн хангах зорилгоор Төв

<sup>3</sup> ТЕГ.ТА. Сан-1, Хөмрөг-10, Д-55, Хн-9, т. 3

сургуулийн дэргэд Улс төр, сурган боловсруулах хэлтсийн удирдлагад 2 сарын хугацаатай курс 1937 оны 3 дугаар сарын 3-нд сайдын 41 дүгээр тушаалаар байгуулж, Төв сургуулийн 2 жилийн сургалттай ангиас 10 сурагч, Тусгай хорооноос 5, бусад газраас 5, бүгд 20 хүнийг авч хичээллүүлснээс гадна ДЯЯ-ны удирдах бүрэлдэхүүний цэрэгжил, улс төр, байлдааны бэлтгэлийг дээшлүүлэхийн тулд 1937 оны 12 дугаар сараас 1938 оны 4 дүгээр сар хүртэл Төв сургуулийн дэргэд “Тусгай давтан курс” хичээллүүлэв.

Энэ мэтчилэн дотооддоо дугуйлан, курс, түр ба байнгын сургуульд суралцуулахын зэрэгцээ зарим ажилтанг ЗХУ-ын ДЯЯ-ны дэргэдэх сургуулийн гүйцэтгэх ажлын болон жагсаал ангид 1, 2 жилийн хугацаатайгаар суралцуулж байжээ. Уг асуудлын талаар 1935 оны 1 дүгээр сарын 15-нд ДХЕГ-аас Намын Төв Хороонд “... сүүлийн 3 жилийн дотор ... 50 шахам хүнийг ЗХУ-ын ДЯЯ-ны Хязгаарын ба гүйцэтгэх ажилтны сургуульд явуулан, түүнээс 30 орчим нь суралцан ирж ажилдаа орсон. Энэ оны 5 сард 23 хүн сургуульд суралцаад эргэж ирнэ. Одоо эндээс 25 хүн дахин явуулахаар бэлтгэж буй...” гэж танилцуулж байжээ.

Үүнээс гадна 1936 оноос ЗХУ-ын Аж ахуйн дээд сургуульд элсэлт авах болсон байна. Бүрэн бус мэдээгээр 1932-1937 онд Х.Баярсайхан, Ж.Баясгалан нарын 70 гаруй ажилтан ЗХУ-д зохих мэргэжил эзэмшсэн байна.

Мөн ЗХУ-ын Дотоод явдлын ардын комиссариатын харьяа төв

сургууль (ЦШ), Хилийн цэргийн дээд сургуульд (ВППШ) офицерууд явуулж байснаа 1938 онд өөрчилж, хилийн цэргийн бүрэн дунд боловсролтой ажилтан бэлтгэх зорилгоор Дотоодын ба Хязгаарын цэргийн төгсөх курсын сурагчид, хилийн цэргийн бага дарга нараас хилийн болон холбоо, зэвсгийн мэргэжил олгохоор явуулж эхэлсэн байна. Энэ нь тус улсын хилийн отряд, штаб, заставын үйл ажиллагаанд Зөвлөлтийн хил хамгаалалтын албаны туршлага нэвтрүүлэх, суралцахад хувь нэмэр оруулсан арга хэмжээ болсон юм.

Ийнхүү Хязгаарын ба гүйцэтгэх ажилтанг бэлтгэх төв сургуулийг 1938 оны 6 дугаар сарын 26-нд ДЯЯ-ны сайдын 172 дугаар тушаалаар “ДЯЯ-ны Хил хязгаарыг батлан хамгаалах ба цэргийн хэргийг удирдах газрын харъяа Дотоодын ба хязгаарын цэргийн сургууль” болгож, жил бүр 50 орчим хүн төгсөн гарах болсон байна.

Тухайн үед Төв сургуульд аймаг орон нутгаас мэдлэг, боловсрол сайтай хүмүүс нь шилэгдэж очдог байсан бөгөөд энэ талаар тус сургуульд сурч байсан ахмад ажилтан Х.Загд: “... 1939 онд би сайн дураараа цэргийн албанд явахаар аймгийн төвд анх удаа ирж цэрэг татлагын комисст оров. Тэнд байсан ногоон малгайтай, цамцныхаа заханд нэг тал дээр нь гурван дамар тэмдэг зэрэгцүүлэн зүүсэн залуухан дарга: Чи нисэгч болох уу?, дарга болох уу?, эсвэл дотоод яамны сургуульд орох уу? гэж хэд хэд дараалан асуухад би сүрдэж учраа эс ухаарч аль ч асуултад нь хариу өгч чадаагүйсэн.

Завхан аймгаас шинэ цэрэг ачсан машины цуваа найман хоногийн дараа Улаанбаатар хотод ирж, Бөхөг түргэний цэргийн карантинд 40 гаруй хоног цэргийн сургууль хийсэн юм. Нэгэн өдөр цэргийн каринтин дээр байсан олон мянган цэргийг жагсааж, олон дарга нар ирж (хожим мэдвэл хурандаа Эрэнцэн, Ядамжав нар) бичиг мэддэг цэргүүд урагш тав алхаад гэж командлав. Тэр олон цэргээс ердөө арваад цэрэг эхлэн жагсаалаас урагш гарав. Би ямар бичиг олигтой мэдэх биш дээ гэж бодоод жагсаалаас гараагүй байтал манай салааны дарга Базаррагчаа: “Нөхөр Загд урагш гараач. Чи бичиг мэднэ шүү дээ гэснээр би урагш алхам гарав. Хэд дахин шаардсан боловч тэр олон цэрэг дотроос дөнгөж арван долоон цэрэг гарч Дотоод яамны Төв сургуульд хувиарлагдсан юм”<sup>4</sup> гэж дурсан ярьсан байдаг.

Тус сургуулиас дотооддоо сурган бэлтгэж байгаа боловсон хүчний сурлага, мэргэжлийн мэдлэгийг сайжруулахын тулд 1940 оны 1 сараас эхлэн ДЯЯ-ны Төв сургуулийн дэргэд хичээллэж байсан гүйцэтгэх ажилтны дамжааг Төв сургуулийн захиргаанд шууд шилжүүлэн суралцах хугацааг 1 жил 6 сар болгож, Ардыг гэгээрүүлэх яамнаас шилжүүлэн авсан багш нарыг тус дамжаанд багшлуулах арга хэмжээг авах болжээ.

Төв сургууль нь 1938 онд “Дотоодын ба хязгаарын цэргийн сургууль” гэсэн нэршилтэй болсон үеэс өөрийн гэсэн газар, байртай болсон бөгөөд сургуулийн нийт талбайн хэмжээ нь 10593 м<sup>2</sup>, куб

метрийн хэмжээ нь дунджаар 42400 м болох ба 1 куб метрийн үнэ 40 төгрөг, барилгын нийт үнэ дунджаар 1.700.000<sup>5</sup>, сургуулийн барилгын ажлын даалгаврын тодорхойлолтоор Штабын тасалгаануудад дарга, комиссар, сургагч тус бүр 1 тасалгаа, сургуулийн жагсаалын анги 9 хүн 3 тасалгаа, улс төрийн анги 4 хүн 2 тасалгаа, аж ахуйн анги 10 хүн 3 тасалгаа, мөнгө санхүүгийн 3 хүн 1 тасалгаа, жижүүрийн тасалгаа 1, бүгд 11 өрөө тасалгаатайгаар зохион байгуулагдсан байна.

Эцэст нь дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Төв сургуулийн нэр болон дотоод зохион байгуулалтын бүтэц, сургалтын агуулгаас үзвэл, эхэн үедээ гүйцэтгэх ажлын чиглэл рүү түлхүү анхаарсан байдалтай байжээ.

2. Яагаад “ДХГ-ын Төв сургууль” гэж нэрлэв гэвэл, 1932 онд Цагдан сэргийлэх, 1933 онд Хил хамгаалах байгууллагын тус ДХГ-т харьяалуулж, цагдаа, хил, аюулаас хамгаалах чиглэл, мэргэжлийн хүмүүсийг сургах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн учраас сургуулийн нэрийг Төв гэж нэрлэсэн байж болохоор байна.

3. ДХГ, түүний залгамж болсон өнөөгийн ТЕГ, түүний Үндэсний тагнуулын академийн тагнуул, гүйцэтгэх ажлын мэдлэг, мэргэжил олгох сургалтын тогтолцоо нь 1934 онд буй болжээ. Харин хууль-эрх зүйн мэдлэг, мэргэжил олгох сургалт нь тагнуул, гүйцэтгэх ажил дээр суурилж цаашдын бие даасан хуулийн сургууль болох нөхцөлийг бүрдүүлж өгчээ.

<sup>4</sup> Д.Цогт-Очир. Тагнуулын байгууллагын зарим ахмад ажилтнуудын дурсамж. УБ., 2007, т. 86

<sup>5</sup> ТЕГ.ТА. Сан-1, Хөмрөг-10, Д-55, Хн-41, т. 5

## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**БАНКНЫ САЛБАР ДАХЬ ГАДААДЫН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ  
ТУРШЛАГА, СУРГАМЖ***доктор Р.Амаржаргал*

Эдүгээ дэлхийн дийлэнх оронд гадаадын банкны үйл ажиллагааны зохицуулалтыг тухайлсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон банкны зах зээл дэх үндэсний болон гадаадын банкны тэнцвэрийг тодорхой хэмжээгээр хангах, сул буюу бүрэн хөгжөөгүй үндэсний банкны зах зээлийн хэсэгт орох гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх, “бохир” мөнгө шилжүүлэх сувгийг хаахуйц хоёр талт болон олон талт олон улсын зохицуулалт тохиролцоогоор хэрэгжүүлж байна.

Үндэсний банкны системд гадаадын хөрөнгө оруулалт орсон нөхцөлд тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих асуудлыг А.М.Михайлов, Р.И.Хансевяров, Е.С.Кудакова<sup>1</sup>, А.С.Лишунин<sup>2</sup>, О.В.Хмыз<sup>3</sup> нар шинжилсэн байна.

1 Михайлов А.М., Хансевяров Р.И., Кудакова Е.С. Мировой опыт государственного регулирования банковской деятельности в условиях институциональных изменений. Экономические науки. 2018, № 5 (162).с. 27-31. ISSN 2072-0858

2 Лишунин А.С. Зарубежный опыт управления финансовой безопасностью кредитных организаций. //Интернет-журнал “Науковедение”.2017, Том 9, № 4. – 8 с. ISSN 2223-5167

3 Хмыз О.В. Регулирование деятельности иностранных банков в Российской Федерации. //Банковское дело. 2011, № 37 (469). с. 39-46. ISSN 2071-4904

Мөн гадаадын хөрөнгө оруулалттай банкны үйл ажиллагааг зохицуулах арга зүйн үндсийг А.В.Козырев<sup>4</sup> гүнзгийрүүлэн шинжилсэн байдаг.

Гадаадын банкны нэвтрэлтийг тусгайлан хязгаарлаагүй орнуудад ч тусгай зөвшөөрөл хүссэн гадаадын банкиг үүсгэн байгуулагч хэд хэдэн шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд гадаадын этгээд үндэсний банкны хувь нийлүүлсэн хөрөнгө худалдан авахад нэгдэн нийлэх, нэгтгэх тухай болон шударга өрсөлдөөний тухай хууль тогтоомжоор зохицуулдаг. Түүнчлэн тухайн ганцаарчилсан тохиолдолд лиценз олгодог дэглэмтэй орнууд эдийн засгийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдлын эрх ашгаа харгалзан асуудлыг шийддэг эрхтэй байна.

Үүнээс гадна, төр засгийн болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд тухайн улсын ашиг сонирхолд харш гэж үзвэл үндэсний банкуудыг гадаадын хяналтад шилжүүлэхийг хориглох эрхтэй. Банк санхүүгийн шинэ байгууллагыг байгуулахад тусгай зөвшөөрөл олгох эсэхийг

4 Козырев А.В. Методические основы организации деятельности банков с участием иностранного капитала в Российской Федерации. //Мирэкономки и права.2011, № 6.с. 22-29. ISSN 2075-079X

үүсгэн байгуулагчийн гарал үүслийн улс орноос хамааруулж шийдэх практикийг ОХУ хэрэгжүүлдэг.

Олон улс оронд оршин суугч бус гадаадын этгээдийг банкны салбартаа нэвтрүүлэхийг хязгаарлахын тулд:

- Тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн олон тооны, нарийвчилсан өргөдөл мэдүүлэг;
- Тусгай зөвшөөрөл олгох олон шат дамжлагатай нүсэр процедур;
- Удирдлага болон ажилтан албан хаагчдын ур чадвар, үйл ажиллагааны бүтэц, үүсгэн байгуулагчдын санхүүгийн нэр хүнд зэрэгт тавьсан илт хатуу стандарт, шалгуур;
- Үйл ажиллагаанд тавих зохицуулалтын илэрхий хүнд суртлын механизмын бий болгох зэргийг зориудаар ашигладаг. Энэ бүхэн албан ёсны хязгаарлалтаас илүү чухал хязгаарлагч хүчин зүйл болдог.

Хүлээн авагч эдийн засгийн хувьд гадаадын банкны үзүүлэх нөлөө эерэг болон сөрөг аль аль нь байж болно. Улс орны үндэсний банк санхүүгийн систем хэдий хэр өндөр хөгжилтэй бөгөөд банкны үйл ажиллагааг зохицуулалтын механизм илүү нарийн төлөвшсөн байна, эерэг нөлөө нь төдийчинээ их байна. Өрсөлдөөн нэмэгдэх, туршлага шилжүүлэн авах, гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг дэмжих гэсэн гурван үндэслэлээр гадаадын банкныг оруулах либерал дэглэмийг дэмжигчид маргадаг. Гэхдээ хуучин

социалист системийн хөгжиж буй орнуудын хувьд гадаадын хүчирхэг банктай өрсөлдөх нь сүйрлийн үр дагаврыг авчирч болзошгүй. Үндэсний банкууд хэрээс хэтэрсэн эрсдэл үүрэхэд хүрч, зах зээлийн хэмжээ, ашигт ажиллагааны хувьд алдагдалтай хэсэгт шахагдаж, улмаар дампуурах, эсхүл гадаадын хяналтад шилжих аюултай. Унгар, Польш, Чех улсад ийм үйл явц ажиглагдсан.

Банкны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт хязгаарлагдмал тооны улс орны хүрээнд төвлөрснөөр банкны системийн нэг орноос хамаарах хамаарал нэмэгдэх аюул бий. Энэ нь эдийн засгийн аюулгүй байдал, үндэсний эрх ашигтай шууд холбоотой. Гадаадын банкны үйл ажиллагаа нь ихэвчлэн толгой компани байрших улс орны засгийн газрын улс төрийн бодлогоос шууд хамаардаг. Гадаадын үндэстэн дамнасан банкны бүлэглэл толгой бүтцээ хамгаалан хадгалахын тулд гадаадын салбараа золиослох боломжтой байдаг. Тиймээс нэг орны гадаадын ганц банк зах зээлд өндөр хувь эзлэх жижиг орнуудад болзошгүй аюулын эх үүсвэр авчирдаг.

Ерөнхийдөө үндэсний банкны системийг гадаадын капиталд бодитойгоор нээж нэвтрүүлэх нь улс орнуудын хувьд харилцан адилгүй ялгаатай хэвээр байна. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал:

- Гадаадын хөрөнгө, түүний дотор банкны салбарт түүнийг оруулах талаарх төр, засгийн улс төрийн ерөнхий хандлага;
- Үндэсний банкны тогтолцооны төлөвшлийн түвшин, олон



улсын банк санхүүгийн сүлжээнд интеграцлагдсан байдал;

- Олон улсын болон улс хоорондын хэлэлцээрүүдийн хүрээнд хүлээсэн үүрэг;
- Гадаадын банкуудын нэвтрэлтэд үндэсний банкны хувь нийлүүлэгчдийг оролцуулан бизнесийн хүрээнийхэн иргэд, олон нийтийн хандлага;
- Төрөөс эдийн засгийн аюулгүй байдлаа хамгаалах сонирхол зэрэг болно.

Хөгжингүй эдийн засагтай улс орнуудад хүчин чадавх сул байж болзошгүй банкныг шүүлтүүрээр илрүүлэх, наанадаж банкны өрсөлдөөнийг сулруулахгүйгээр хязгаарлахад зохицуулалтын үндсэн үүрэг оршдог. Харин хөгжиж буй болон социализмын дараах орнуудад эсрэгээрээ хэт өрсөлдөөнөөс зайлсхийх, гадаадын зарим орны илт хүчирхэг банкууд зах зээлийг бүхэлд нь, эсхүл түүний үнэ цэнэтэй хувь хэсгийг монопольлохоос урьдчилан сэргийлэхэд онцгойлон төвлөрөх шаардлагатай гэсэн дүгнэлт хийж болно.

Гадаадын банкинд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих байгууллага нь зарим улсад яаж тогтоосныг хүснэгт 1-д харуулав.

Гадаадын банкны үйл ажиллагаа нь харилцан адилгүй зохицуулалтын дэглэм, үндэсний хэмжээний зах зээл дэх өрсөлдөөний түвшин, төрөлжилт, олон улсын үйл ажиллагааны зэрэглэл зэргээс шалтгаалан өөр өөрийн онцлог шинж чанартай байдаг. Гэвч үйл

ажиллагааны нийтлэг шинж чанарыг дор дурдсанаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Гадаадын үндэстэн дамнасан компаниуд нь гол томоохон экспортлогч, импортлогчдоод үйлчлэхэд анхаарлаа төвлөрүүлдэг;
- Банкны уламжлалт зээл олголтын ашиг гэхээсээ илүү санхүүгийн бусад нарийн үйлчилгээний төлбөр, комиссын төлбөрийн шимтгэлээр орлогын урсгал, ашиг орлогын бодлого хэрэгжүүлэх;
- Банк хоорондын зах зээлийг зээлжих гол эх үүсвэр болгон ашиглах;
- Гадаад валют болон оршин суугч бус гадаадын харилцагчидтай үлэмж хэмжээний ажил гүйлгээ хийх зэрэг болно.

Энэ нь нэг талаас гадаадын банкны үндэстэн дамнасан хүчирхэг бүлэглэлийн чадавхи, нөгөөтэйгүүр тэдний бие даасан бодлого, тодорхой шийдвэр гаргах менежментийн эрх хязгаарлагдмал, салбарын сүлжээ сул, хадгаламжийн бааз хангалтгүй, үйлчилгээний өртөг зардал өндөр зэрэгтэй холбоотой юм.

Улс орнуудад гадаадын банкныг хянаж зохицуулах чиг үүргийг тусгайлсан зохицуулагч агентлаг, эсвэл төв банк гэсэн хоёр субъект хэрэгжүүлдэг байна. Өндөр хөгжилтэй санхүүгийн зах зээл хөгжсөн орнуудад голдуу тусгайлсан зохицуулагч агентлаг байгууллагууд ажилладаг байна. Улс төрийн тогтолцооны онцлогоос хамааран



Хүснэгт 1

Тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих субъект

№	Улс	Зохицуулагч байгууллага
<b>I. Хөгжингүй орнууд</b>		
1	АНУ	Мөнгөн гүйлгээний хяналтын агентлаг. Муж улсын банкны комисс
2	Их Британи	Санхүүгийн үйлчилгээний агентлаг
3	ХБНГУ	Санхүүгийн хяналтын Холбооны агентлаг
4	Франц	Банкны комисс
5	Япон	Санхүүгийн үйлчилгээний агентлаг
<b>II. Хөгжиж буй орнууд</b>		
6	Бразил	Төв банк
7	ОХУ	Төв банк
8	Энэтхэг	Нөөцийн банк
9	БНХАУ	Төрийн зөвлөлийн банкны удирдлага зохицуулалтын хороо
10	Индонез	
<b>III. Шилжилтийн хуучин социалист орнууд</b>		
11	Чех	Төв банк
12	Польш	Төв банк
13	Молдав	Төв банк
14	Армен	Төв банк
15	Киргизстан	Төв банк
16	Казакстан	Санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллагын хяналт, зохицуулалтын агентлаг
17	Монгол	Төв банк

БНХАУ-д Төрийн зөвлөлийн харьяа Засгийн газрын зохицуулагч агентлаг үйл ажиллагаа явуулдаг. Ихэнх шинэ зах зээлийн эдийн засагтай болон шилжилтийн эдийн засагтай оронд Төв банк тусгай зөвшөөрөл олгох болон үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэж байна.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Банкны Зохицуулах Хороо нь банк зээлийн байгууллагууд (санхүүгийн лизингийн компаниуд, траст, хөрөнгө оруулалтын компаниуд)-ыг удирддаг, хяналтын төрөлжсөн байгууллага юм. Төрийн өмчит банкууд (төрийн өмчит банк) тусдаа ангилалд ордог.

БНХАУ-ын банкны зохицуулалт нь маш нарийн хатуу шаардлагыг тавьдаг.<sup>5</sup> БНХАУ-ын Төв банк болох Ардын банкнаас мөнгөний болон валютын ханшийн нэн идэвхтэй бодлого хэрэгжүүлдэг. Ийм учраас тусгай зөвшөөрлийг төв банк бус, харин Засгийн газрын тусгай агентлаг эрхлэн олгодог онцлогтой.

Практикт дүрмийн сангийн хэмжээнд тавигдах хамгийн доод шаардлага нь өрсөлдөөнт орчинг бүрдүүлэх хийгээд системийн санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлдог банкны салбарт нэвтрэх гол хязгаарлалт болдог.

Зах зээлд оролцогчдын тоо өрсөлдөөний түвшинтэй шууд хамааралтай гэж үздэг боловч энэ хүрээнд өрсөлдөөн болон өрсөлдөх чадвар хоорондын оновчтой тэнцвэрийг хадгалах шаардлагатай болдог. Банкны системийн зохицуулалтын зорилгыг хэрэгжүүлэх арга замтай нь уялдуулах нь онцгой чухал. Хөрөнгө оруулалтын хэмжээний хувьд зах зээлд нэвтрэн орох хязгаарлалт сул байх нөхцөлд үндэсний банкууд өрсөлдөх чадваргүй болно.

Өндөр хөгжилтэй оронд гадаадын банкны дүрмийн сангийн хэмжээнд тавих шаардлага харьцангуй бага. Тухайлбал, Европын ихэнх оронд Европын Төв Банкнаас тогтоосон 5 тэрбум евротой тэнцэх босгыг мөрддөг. Евро бүсийн бус орноос Их Британи, Польш улс түүнийг дагаж мөрдөхөөс

гадна хуучин социалист орнууд энэ жишгийг баримталж байна.

Гадаадын зарим улсад банк байгуулах дүрмийн сангийн босго хэмжээг хүснэгт 2-д үзүүлэв.

#### *ОХУ-ын зохицуулалтын онцлог*

ОХУ-ын хууль тогтоомжоор гадаадын хөрөнгө оруулалттай банк зээлийн байгууллага, даатгалын байгууллага болон ашгийн бус байгууллагууд гэсэн хуулийн этгээд байгуулах онцлог зохицуулалтыг тогтоосон байдаг. ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу гадаадын банк ОХУ-д банкны үйл ажиллагааг зөвхөн хоёр л хэлбэрээр явуулах зохицуулалттай. Тухайлбал, оршин суугч этгээдийн банкны дүрмийн санд хөрөнгө оруулах, ОХУ-д төлөөлөгчийн газраа нээх хэлбэрээр оролцох эрхтэй байх зэрэг болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай банк гэж оруулсан капиталын хувь хэмжээг үл харгалзан оршин суугч бус этгээд хөрөнгө оруулсан оршин суугч бүртгэлтэй банк зээлийн байгууллагыг хэлдэг.

Гадаадын банкны үйл ажиллагааг төрөөс зохицуулах механизмын харьцуулалтыг хүснэгт 3-д харуулав.

ОХУ-ын банкны системд гадаадын капиталын оролцооны хязгаарлалтын хэмжээг (квот) Төв банктэй зөвшилцсөний үндсэн дээр ОХУ-ын Засгийн газрын санал болгосноор Холбооны хууль болж баталдаг. Энэ квотыг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид оршин суугч бус капиталын харьцаагаар тооцож,

<sup>5</sup> Наумова Т.С., Олейник Г.С. Иностранный капитал в банковском секторе экономики: институциональная характеристика. // Общество: политика, экономика, право. 2017, № 8. – 8 с. ISSN 2071-9701

Хүснэгт 2

Дүрмийн сангийн босго хэмжээний зохицуулалт

№	Улс ба мөнгөн тэмдэгт	Үндэсний банк		Гадаадын банкны охин компани		Гадаадын банкны салбар	
		Үндэсний валют	Гадаад валют	Үндэсний валютаар	Гадаад валют	Үндэсний валютаар	Гадаад валют
Хөгжингүй орнууд							
1	АНУ	байхгүй	байхгүй	байхгүй	байхгүй	байхгүй	байхгүй
2	Их британи	5 сая €	7 сая	5 сая €	7 сая \$	5 сая €	7 сая
3	Герман	5 сая €	7 сая	5 сая €	7 сая \$	5 сая €	7 сая
4	Франц	5 сая €	7 сая	5 сая €	7 сая \$	5 сая €	7 сая
5	Япон, иен	2 тэрбум	24,4 сая	2 тэрбум	24,4 сая	2 тэрбум	24,4 сая
Хөгжиж буй орнууд							
6	Бразил, реал	17,5 сая	10,7 сая	17,5 сая	10,7 сая	17,5 сая	10,7 сая\$
7	ОХУ, рубль	180 сая	6,2 сая	180 сая	6,2 сая	-	-
8	Энэтхэг, рупи	3 тэрбум	66,3 сая	3 тэрбум	66,3 сая	-	25 сая \$
9	Хятад, юань	1 тэрбум	153,8 сая	300 сая	46,1	100 сая	15,4 сая
10	Индонез						
Шилжилтийн орнууд							
11	Чех, крон	500 сая	28,6	500 сая	28,6	500 сая	28,6
12	Польш	5 сая €	7 сая	5 сая €	7 сая	5 сая €	7 сая
13	Молдав	100 сая	5.9 сая	100 сая	5.9 сая	100 сая	5.9 сая
14	Армян	5000 сая	8.6 сая	5000 сая	8.6 сая	5000 сая	8.6 сая
15	Киргиз, сом	200 сая	3 сая	200 сая	3 сая	200 сая	3 сая
16	Казахстан, тэнгэ	10 тэрбум	44.6 сая	10 тэрбум	44.6 сая	10 тэрбум	44.6 сая

ОХУ-д бүртгүүлсэн нийт банк зээлийн байгууллагад хөрвүүлэн тооцдог. ОХУ-ын Төв банк нь гадаадын хөрөнгө оруулалттай банкуудад олгосон квотын хязгаарт хүрмэгц банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажиллагаагаа зогсоодог.

ОХУ-ын Төв банк Засгийн газартай тохиролцсоны дагуу гадаадын орнуудад хийх ОХУ-ын хөрөнгө оруулалт, Оросын банкны салбар байгуулах үйл ажиллагаагаа явуулахад саад бэрхшээл учруулдаг улсын банканд хязгаарлалт тавих эрхтэй байдаг. ОХУ-ын банк нь үүсгэн байгуулагчдын байрлаж буй орноос оросын банкны системд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан үзэж, ОХУ ба үүсгэн байгуулагч орны хоорондын харилцааны онцлогийг тооцдог. Үүнээс гадна ОХУ-ын банк нь үндэсний банкны системд гадаадын хөрөнгө оруулалтын талаархи гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой тусгай арга хэмжээ авч, хөнгөлөлттэй татварын дэглэмтэй улс орнуудад бүртгүүлэх газар болон гаалийн зохицуулалтын тарифын арга, эсвэл орон нутгийн хөрөнгө оруулалтын талаарх тусгайлан хяналт тавих эрхтэй байдаг.

Гадаадын хөрөнгө оруулалттай банк үүсгэн байгуулахаас гадна гадаадын банкууд ОХУ-ын нутаг дэвсгэр дээр төлөөлөгчийн газраа нээх боломжтой бөгөөд гадаадын зээлийн байгууллагын төлөөлөгчийн газар нээх, үйл ажиллагаа явуулах тухай журмаар зохицуулдаг. Гадаадын зээлийн байгууллагын төлөөлөгчийн газар нь ОХУ-ын нутаг дэвсгэр

дээр нээгдсэн гадаадын зээлийн байгууллагын салангид тусгаар нэгж юм. Оросын банкны салбарын эдийн засгийн байдал, нөхцөл байдлыг судалж, үйлчлүүлэгчдээ зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх, оросын банкны байгууллагуудтай холбоо тогтоож, өргөтгөх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор төлөөлөгчийн газрыг гадаадын зээлийн байгууллага байгуулан ажиллуулж байна.

Гадаадын банкны төлөөлөгчийн газрыг оффшор бүсээс нээх асуудлыг шийдвэрлэхдээ ОХУ-ын Төв банк, гадаадын банкны гарал үүслийн үндэсний төв банк хоёрын хооронд байгуулсан банкны хяналт шалгалтад мэдээлэл солилцох боломжийг олгохуйц хоёр талын хэлэлцээр байгаа эсэхийг харгалзан үздэг. Зөвшөөрлийг гурван жилийн хугацаатайгаар олгодог. Төлөөлөгчийн газрын гадаад ажилтны тоо нь дүрмээр хоёр хүнээс хэтрэхгүй байх ёстой.

#### ***БНХАУ-ын зохицуулалтын онцлог***

1979 оноос эхлэн гадаадын банкууд төлөөлөгчийн газраа Бээжин болон бусад хот, эдийн засгийн тусгай бүсэд нээх эрхтэй болжээ. Хожим нь 1984 онд гадаадын банкуудад гадаад валютын зээлийг олгохыг зөвшөөрч үйл ажиллагааны жагсаалтыг өргөжүүлсэн байна. Оршин суугч бус этгээд, хамтарсан үйлдвэрүүдээс хадгаламж татахыг зөвшөөрснөөр уг эх үүсвэр гадаадын банкны үндсэн харилцагчдын суурийг бүрдүүлсэн. 1985 онд эдийн засгийн тусгай бүсэд салбараа нээх эрхийг гадаадын

Хүснэгт 3

Улс орнуудын банкны зохицуулалтын харьцуулалт

№	Нэр	Армен	БНХАУ	ХБНГУ	Унгар	БНКУ	Киргиз	Польш	ОХУ	АНУ	
1	1-ээс илүү тооны тусгай зөвшөөрөл авах эсэх	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Үгүй	
2	Үйл ажиллагааны төрлөөс хамаарч дүрмийн сангийн доод хэмжээ өөр эсэх	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	---	Үгүй	Тийм	Тийм	Тийм	
3	Гадаадын этгээд дараах хэлбэрээр нэвтрэхийг хориглосон эсэх Үүнд:	Хувьцаа худалдан авалт	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	---	Үгүй	Үгүй	Үгүй	
		Охин компани	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	---	Үгүй	Үгүй	Үгүй	
		Салбар байгуулах	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	---	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй
		Хамтарсан	Үгүй	Үгүй	---	Үгүй	---	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
4	Гадаадын өмчлөлийг зөвшөөрсөн хэмжээ	100	20	---	100	---	---	100	100	100	
5	Хяналтын газар хэнд ажлаа тайлагнадаг:	Засгийн газрын тэргүүн (Ерөнхийлөгч, Ерөнхий сайд)	Үгүй	---	Үгүй	Үгүй	---	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй
		Сангийн сайд эсхүл танхимын гишүүн сайд	Үгүй	---	Тийм	Үгүй	---	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм
		Парламент буюу хууль тогтоох байгууллага	Тийм	---	Үгүй	Тийм	---	Тийм	Үгүй	Тийм	Үгүй
6	Арилжааны банкны тоо	21	289	1919	35	39	22	49	1012	6530	
7	Гадаадын хяналттай банкны нийт банкны системийн активд эзлэх хувь 2010	67.45	---	11.77	82.83	17.37	45.6	62	18	---	

банкуудад зөвшөөрсөн ба “БНХАУ-ын эдийн засгийн онцгой бүсэд гадаадын болон хамтарсан банкуудын үйл ажиллагааг зохицуулах журам” батлан гаргасан байна.<sup>6</sup>

Гадаадын банкны байгууллагын тоо, хэмжээ нэмэгдэх хэрээр тэдгээрийн үйл ажиллагааны зохицуулалтын хүрээг сайжруулах шаардлагатай болсон учир Гадаадын банкны төлөөлөгчийн газрыг байгуулах журмыг 1991 онд,<sup>7</sup> гадаадын капиталын оролцоотой банк санхүүгийн байгууллагыг зохицуулах журмыг 2002 онд<sup>8</sup> тус тус баталсан байжээ.

2018 оноос гадаадын банкнийг хянах тогтолцоонд зарим өөрчлөлт оруулах талаар доорх асуудлыг хэлэлцсэн байна. Үүнд:

- Үндэсний банкуудад гадаадын өмчлөлийн хязгаарлалтыг цуцлах;
- Банкны салбар болон охин компани нэгэн зэрэг байгуулахыг гадаадын банкинд зөвшөөрөх;
- Юаниар үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн гадаадын хөрөнгө оруулагч банкинд “нэг жилийн хүлээх хугацаа” шаардахыг цуцлах;
- Гадаадын банкны салбарын жижиглэнгийн харилцагчийн юанийн хугацаат

хадгаламжийн босгыг 1 сая юанаас 500,000 юань болгож буулгах;

- Гадаадын банкуудын гадаадын хөрөнгө оруулалттай банкууд засгийн газрын бонд гаргахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй болно.

БНХАУ-д олон салбартай гадаадын банкны удирдах салбар юанийн болон дериватив бизнес эрхлэх зөвшөөрөлтэй бол бусад салбар нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах шаардлагагүй болно. Үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын банк эргэлтийн хөрөнгийн нийт активыг БНХАУ-ын бүх салбартаа хуваарилахдаа зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа нөхцөлд шинээр байгуулагдсан салбар, ажлын байранд цаашид эргэлтийн хөрөнгийг хуваарилах шаардлагагүй болох зэрэг болно.

### Дүгнэлт

Дэлхийн улс орон бүр тусгай зөвшөөрөл олгох, дүрмийн сангийн хүрэлцээний хамгийн бага хэмжээг тогтоох зэрэг гадаадын банкны нэвтрэлтийг хянах эрхзүй болон институциональ зохицуулалтыг ашиглаж байна. Банк санхүүгийн зах зээл нь төгөлдөржсөн өндөр хөгжилтэй орнууд гадаадын сул, сэжигтэй банкныг оруулахгүй байх болон мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлыг олон улсын түвшинд нарийн чанд зохицуулж, харин бусад хязгаарлалтын хувьд харьцангуй либерал бодлого хэрэгжүүлж байна. Шинэ зах зээлийн эдийн засагтай орнууд, ялангуяа БНХАУ, ОХУ

<sup>6</sup> Чебаненко Е.Н. Эволюция привлечения иностранного капитала в банковскую систему Китая. //Проблемы современной экономики. 2012, № 1 (41). с. 331-334. ISSN 1818-3395

<sup>7</sup> Иностранные банковские учреждения в КНР. Available from [www:https://www.minfin.ru/common/upload/nifi/bankknr.pdf](http://www.minfin.ru/common/upload/nifi/bankknr.pdf)

<sup>8</sup> Положения КНР “О руководстве деятельностью иностранных финансовых организаций”. Available from [www: http://law.uglc.ru/money.htm/2](http://law.uglc.ru/money.htm/2)



болон бусад хөгжиж буй томоохон орон үндэсний зах зээлээ хамгаалах чиглэлээр хориглолтын хатуу зохицуулалтыг ил далд хэлбэрээр хийж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Михайлов А.М., Хансевяров Р.И., Кудакова Е.С. Мировой опыт государственного регулирования банковской деятельности в условиях институциональных изменений. -// Экономические науки. 2018, № 5 (162). с. 27-31. ISSN 2072-0858

2. Лишунин А.С. Зарубежный опыт управления финансовой безопасностью кредитных организаций. -//Интернет-журнал “Науковедение”. 2017, Том 9, № 4. – 8 с. ISSN 2223-5167

3. Хмыз О.В. Регулирование деятельности иностранных банков в Российской Федерации. //Банковское дело. 2011, № 37 (469). с. 39-46. ISSN 2071-4904

4. Козырев А.В. Методические основы организации деятельности банков с участием иностранного капитала в Российской Федерации. -//Мир экономики и права. 2011, №

6. с. 22-29. ISSN 2075-079X

5. Наумова Т.С., Олейник Г.С. Иностраный капитал в банковском секторе экономики: институциональная характеристика. -//Общество: политика, экономика, право. 2017, № 8. – 8 с. ISSN 2071-9701

6. Чебаненко Е.Н. Эволюция привлечения иностранного капитала в банковскую систему Китая. -// Проблемы современной экономики. 2012, № 1 (41). с. 331-334. ISSN 1818-3395

7. Селищев А.С., Селищев Н.А. Особенности современной инвестиционной банковской деятельности в Китае. -//Вестник Новгородского государственного университета. 2014, № 82. с. 114-118. ISSN 2076-8052

8. Иностранные банковские учреждения в КНР. Available from [www:https://www.minfin.ru/common/upload/nifi/bankknr.pdf](https://www.minfin.ru/common/upload/nifi/bankknr.pdf)

9. Положения КНР “О руководстве деятельностью иностранных финансовых организаций”. Available from [www: http://law.uglc.ru/money.htm/2](http://law.uglc.ru/money.htm/2)

## МОНГОЛ ХЯТАДЫН ХАРИЛЦАА; УЛС ТӨРИЙН ШИНЭ СЭТГЭЛГЭЭ БА ХАМТЫН ХҮЧИН ЧАРМАЙЛТ

---

*доктор, профессор Д.Уламбаяр*

Монгол-Хятадын харилцааг хэвийн болгох асуудал Зөвлөлт-Хятадын харилцаанаас шууд шалтгаалж байсан юм. Зөвлөлтийн удирдагч М.С. Горбачев 1986 оны 7 дугаар сард Владивостокт хэлсэн үгэндээ, Японтой сайн хөршийн харилцаа тогтоох, Солонгосын хойгийн асуудлыг энхтайван замаар зохицуулах, Ази-Номхон далайн орнуудыг оролцуулан Хельсинк маягийн чуулга уулзалт хийх санал дэвшүүлсэнээс гадна “Түүх Зөвлөлт, Хятадын ард түмэнд онц хариуцлагатай үүрэг ногдуулж байна. Хоёр том улсаас олон улсын хөгжлийн олон зүйл шалтгаална. Манай харилцаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц сайжирлаа. ЗХУ Хятадтай сайн хөршийн харилцааны байдал бий болгох нэмэлт арга хэмжээний тухай асуудлыг ямар ч цагт, ямар ч түвшинд хамгийн буурьтай хэлэлцэхэд бэлэн байгааг нотлохыг хүсч байна. Биднийг зааглаж байгаа (холбож байгаа гэж хэлмээр байна) хил ойрын ирээдүйд энхтайван, найрамдлын зурвас болно гэж найдаж байна” гэсэн бол, 1987 оны 7 дугаар сард Индонезийн “Мердека” сонинд өгсөн ярилцлагадаа дээрхийг дахин нотолж, 1988 оны 9 дүгээр сард

Красноярскт хэлсэн үг түвэгтэй байсан хэдий ч Алс Дорнодын олон улсын харилцааны орчин, геополитикийг шинэ сэтгэлгээний үүднээс шинээр авч үзэх боломж олгосон юм. Тэрбээр хэлсэн үгэндээ Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд юуны өмнө цэргийн сөрөг төвлөрлийг багасгах, итгэлцлийг бэхжүүлэх тухай Хятад, Япон, БНАСАУ, болон анх удаа нэр заан Өмнөд Солонгосыг оролцуулан олон этгээдийн хэлэлцээ хийх санал дэвшүүлэв. М.С.Горбачёв 1988 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 43 дугаар чуулганы индрээс дахин шинэ санаачилга дэвшүүлсэн нь зэвсэгт хүчнээ үлэмж хорогдуулж, Монголоос цэргээ гаргана гэдээ анх удаа зарлав. Тэрбээр мөн Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ: Манай орны болон дэлхий дахинд бүтээлдээ Хятадын “дөрвөн шинэчлэл”-ийн үйл явцаар нэн сонирхолтой, олон талаар үр бүтээлтэй үзэл санааг хэрэгжүүлж буй БНХАУ-тай тогтоосон харилцааны чухлыг тэмдэглэсэн нь Бээжингийн удирдагчдын анхаарлыг зүй ёсоор татсан байна.

1980-аад оны туршид олон үе шаттай явагдсан Зөвлөлт, Хятадын

улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр харилцааг сайжруулахад тээг болж буй “гурван харш саад”-ыг арилгах болзолыг Хятадын талаас байнга тавьж байсан нь “ямар ч тохиолдолд аливаа улсын батлан хамгаалах хүчин гагцхүү өөрийн улсын хилийн дотор байрлах ёстой” гэдэгт үндэслэж байв. “Гурван харш саад”-ыг арилгах гэдэг нь нэгд. Монголоос зөвлөлтийн цэргийг гаргах, хоёрт, Кампучиас Вьетнамын цэргийг гаргуулах, гуравт, Афганистанаас зөвлөлтийн цэргийг гаргах, эдгээр асуудлыг шийдвэрлэсэн тухайд л харилцааг хэвийн болгох боломжтой оршиж байв. Тиймээс Бээжингийн удирдагчид “гурван харш саад” гэдэг нь Хятадыг гурван талаас нь бүслэсэн байдлыг хэлж буй юм гэж Зөвлөлтийн талд тов тодорхой ойлгуулж байжээ.

1963 онд АНУ Хятадын өсөн нэмэгдэж болох аюулыг дарахын тулд ЗХУ-д хандаж, хэрэв АНУ цөмийн зэвсэг хэрэглэн Хятадын эсрэг “урьдчилан сэргийлэх” цохилт хийвэл ЗХУ ямар байр суурьтай байхыг тандаж байжээ. Мэдээж ЗХУ түүнийг нь дэмжээгүй. Монголтой хиллэдэг Хятадын цөмийн зэвсгийн туршилтын болон цөмийн бусад барилга байгууламжийн эсрэг АНУ цөмийн зэвсэг хэрэглэсэнсэн бол Монгол Улс хир хохирох байсан нь тодорхой юм. 1969 онд Зөвлөлт-Хятадын харилцаа хурцдаж, хилийн дагуу удаа дараа зэвсэгт мөргөлдөөн гарч байх үеэр ЗХУ-ын удирдлага тухайн үед 50 орчим цөмийн зэвсэгтэй болж байсан Хятадын цөмийн зэвсэг, байгууламжуудын эсрэг цөмийн урьдчилсан цохилт хийх

замаар устгах боломжийг судалж, энэ талаар Варшавын Гэрээний орнуудын холбоотнууддаа аминчлан мэдэгдэхийн дээр АНУ-ын байр суурийг тандаж байсан байдаг.

Өөрийн аюулгүй байдлыг хангах нь бусдын аюулгүй байдлыг ямагт хөндсөөр иржээ. Зэвсэглэлээр хөөцөлдсний гол уг сурвалж үүнд л оршиж байв. БНХАУ оршин тогтнож байсан түүхийнхээ туршид аюулгүй байдлаа дангаараа хангаж байсан гэж үздэг. Мөн Хятад нь найрсаг хөршүүдээр хүрээлүүлж байгаагүй гэж үзэж байсан ажээ. Аль ч улс, гүрнүүдийн хооронд цэрэг-аюулгүй байдлын салбарт харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь хичнээн чухал гэдэг нь эндээс тодорхой байгаа юм.

1989 онд Афганистаны асуудлаар Женевийн хэлэлцээр байгуулагдаж, тус орноос зөвлөлтийн цэрэг гарав. 1989 оны 9 дүгээр сарын эцэс гэхэд Кампучиас Вьетнамын “сайн дурынхан”-ыг бүрэн гаргах тухай Вьетнам, Кампучи, Лаосын 1989 оны 4 дүгээр сарын 5-ны Парисын Энхтайвны бага хурлаас гаргасан хамтарсан Тунхаглал улс төрийн томоохон үйл явдал болов. Нийтдээ Вьетнамын 24 мянган цэрэг, офицер, зэвсэг, хүнд техникүүд гарав.

**“Хил дээрх цэргийн тоог цөөлөх тухай Зөвлөлт-Хятадын хэлэлцээр”-ийг** 1989 оны 2 дугаар сарын 4-нд байгуулсан юм. Дурьдсан хэлэлцээрийн дагуу хоёр улс өөрийн хилийн дагуу төвлөрүүлсэн цэргийн тоог цөөрүүлэх, Афганистан болон Монголоос зөвлөлтийн цэргийг гаргахаар тохиролцсон байна.

Зөвлөлтийн удирдагчдаас гучин

жилийн дараа М.С.Горбачев 1989 оны 5 дугаар сард Хятадад албан ёсны айлчлал хийсэн нь дэлхий дахины анхаарлыг онцгой татсан юм. М.С.Горбачев Хятадын удирдагч Дэн Сяопинтэй уулзахдаа Монгол дахь зөвлөлтийн цэргийн 75 хувийг ойрын үед эх оронд нь буцаах бөгөөд үлдсэн 25 хувийг гаргах боломж, хугацааны тухай асуудлыг БНМАУ-тай хэлэлцэх болно гэжээ. Мөн Зөвлөлт-Хятадын харилцааны сайжрал нь гуравдагч этгээдэд (Монгол Д.У) хохирол учруулахгүй гэж мэдэгджээ.

Зөвлөлтийн удирдагч М.С.Горбачев БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэнтэй уулзах үеэр Хятадын тал Зөвлөлт-Хятадын харилцаа сэргэж, хэвийн болсныг өндөр үнэлэхийн хамт, хоёр орны харилцаа цаашдаа 1950-иад оны үеийнх шиг холбоотны харилцаанд хэзээ ч тулгуурлахгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.<sup>1</sup>

1982 оны 10 дугаар сараас Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын Хятадын талын тэргүүн, ЗХУ-д сургууль төгссөн, “зөвлөлтийн талаарх гол мэргэжилтэн” Цянь Цичэнь 1988 онд ГЯЯ-ны сайд У Сюэцянь-ийн оронд шинээр томилогдсон нь санамсаргүй зүйл биш байв. Тэрбээр гадаад дахь айлчлалаа ЗХУ-аас эхэлж, Москвад хийсэн яриа хэлэлцээний үеэр “гурван харш саад”-аа татаж авснаа нотолж, мөн Монголын тусгаар тогтнолын асуудлаар Хятадын анхны албан ёсны

байр суурийг илэрхийлжээ.

ЗХУ Монголоос бүх цэргээ татахын хамт Хятад, Зөвлөлтийн хилийн дагуух цэргийг хамгийн доод түвшинд хүртэл хорогдуулах, хорогдуулсан цэргээ бусад оронд шилжүүлэн байрлуулахгүй байхыг хүсч байгаагаа Цянь Цичэнь Зөвлөлтийн дипломат албаны тэргүүн Э.Шевардназед мэдэгдээд БНХАУ Монгол Улстай найрамдалтай, сайн хөрш байхыг эрмэлзэж байгаа бөгөөд БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр тус улстай харилцах бодолтой байна гэдгээ нотолсон нь Монголын талын анхаарлыг зүй ёсоор татаж, чухамдаа Монгол, Хятадын ГЯЯ-ны сайд нар харилцан айлчлах дипломатын урьдчилсан нөхцөл болсон байна. Цянь Цичэнь 1988 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнтэй анх удаа уулзаж, түүнийг Хятадад айлчлахыг урьж, дараахан нь ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д. Ёндон айлчлалыг нарийвчлан тохиролцохоор Бээжинд очиж Цянь Цичэньтэй уулзжээ.

Тийнхүү Зөвлөлтийн цэрэг гарч эхлэхтэй давхцан сайд Ц.Гомбосүрэн 1989 оны хавар Хятадын зорив. Тэрбээр айлчлалын өмнөхөн ТАСС-ын улс төрийн тоймчид ярилцлага өгчээ. “Ер нь дэлхийн аль ч нутагт, хэний ч цэрэг үндэснийхээ хил хязгаарын гадна байх ёсгүй гэдгийг та бид ойлгож байна. Гэхдээ энэ бол улс төрийн зохих зориг хүсэл, багагүй хүчин чармайлт гаргаж байж биелэх зүйл юм. Харин бидний ярьж

<sup>1</sup> Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С. Горбачева в Китайскую Народную Республику 15-18 Мая 1989 года. Документы и материалы. Изд. Политической литературы. М.: 1989, стр. 17-18

байгаа тодорхой асуудлын тухайд бол энэ асуудлыг буй болгосон улс төр, түүхийн болон бусад тодорхой хүчин зүйлийг харгалзан авч үзэх ёстой нь мэдээж. Зөвлөлтийн цэрэг БНМАУ-д өөрийн дураар биш, харин манай хил хязгаарын аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн Монголын Засгийн газрын хүсэлтээр манай нутагт орж ирсэн гэдгийг Бээжинд сайн мэдэж байгааг үүнтэй холбогдуулан тэмдэглэе. Ингэхлээр Монголын Засгийн газар л Зөвлөлтийн цэргийг манай орны нутаг дэвсгэрээс гаргах эсэх тухай асуудлыг шийдвэрлэж, энэ талаар Зөвлөлтийн талд санал тавих эрхтэй. Тийм учраас энэ бол БНМАУ, ЗСБНХУ-ын мэдлийн асуудал. Монгол-Хятадын улс төрийн тэнгэрт нэг ч үүлгүй байна гэж батлан хэлэхэд арай эрт боловч БНМАУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болох үйл явц ямар нэгэн саад доголдолгүй жигд явж байна” гэж хэлсэн нь шийдлийн үгийг Москва, Бээжинд биш, Улаанбаатарт хэлнэ гэсэн санаа байв. Гэвч эцсийн шийдлийг хоёр хөрш хоорондоо тохиролцон гаргасан билээ. Ц.Гомбосүрэн сайдын айлчлалын үеэр “БНМАУ, БНХАУ-ын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “БНМАУ-ын Ерөнхий консулын газрыг БНХАУ-ын Хөх хотод сэргээн байгуулах тухай хэлэлцээр”, “Иргэд харилцан зорчих журмын тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурав. Монголын сайдыг БНХАУ-ын дарга Ян Шанкунь хүлээн авч уулзах үеэр АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнхийг

Хятадад айлчлахыг урьсан байна.

ЗХУ-ын ГЯЯ-ны Азийн асуудал эрхэлсэн орлогч сайд Игорь А.Рогачёв 1989 оны 3 дугаар сард Улаанбаатарт ажлын айлчлал хийх үеэрээ нэгэн шинэ баримт дэлгэсэн нь Зөвлөлтийн цэргийг гаргах тухай яриа хэлэлцээ ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхэлж байх үед 1986 онд Монгол-Зөвлөлтийн хооронд нууц байдалд явагджээ. Э.А.Шеварнадзе 1986 оны 1 дүгээр сард ЗХУ-ын ГЯЯ-ны сайдын хувиар БНМАУ-д анх удаа бие даасан айлчлалаа хийж, улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын талаар санал солилцож, энэ үеэр БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтооход саад болж байсан хойд хөршийн “moratorium” буюу “түр азнах” хоригийг нэг мөр шийдвэрлэсэн юм. Түүнчлэн маш чухал нууц асуудал болох БНМАУ-аас Зөвлөлтийн цэргийг гаргах тухай асуудал хөндөгджээ. Энэ тохиролцооны дагуу 1986 оны намар цэргийн эхний хэсэг Хятадын Синьцзян-Уйгуртай хиллэж байсан Говь-Алтай, Ховд аймгаас эх орондоо буцсан байна. Улмаар 1989 оны 5 дугаар сараас Монголоос Өвөрбайгалийн 39 дүгээр армийн бүрэлдэхүүнд багтаж байсан цэргийн бүлэглэл (военной группировки) болох танкийн 2, мотобуудлагын 3 дивиз (1861 танк, 2531 байлдааны хуягт машин), нисэх хүчний 1 дивиз (190 бөмбөгдөгч болон сөнөөгч, 130 нисдэг тэрэг), 1461 артиллерийн их буу, радар-локаторын цогцолбор, 120 мянган цэргээс 50 мянга 320 хүнийг гаргасан байна. Нийтдээ 50 гаруй цэргийн хотхон, бааз байрлаж

байжээ. 1979 оны 2 дугаар сард БНХАУ БНСВУ-д түрэмгийлсний дараа тухайн жилд ЗХУ-аас 1 тэрбум шилжих рублийн буцалтгүй тусламжийн хүрээнд сүүлийн үеийн танк, их буу бусад зэвсэг хэрэгсэл авсан байна.

Түүнчлэн Богд хан уулын урд хормойд байрлаж байсан Радиасоронзон долгион барих, пуужингийн довтолгооноос эсэргүүцэн хамгаалах тагнуулын маш нууц томоохон хоёр цогцолбор станцыг нууцалж, удал хэлэлцсэний эцэст татан буулгасан байна. Эдгээр станцууд бүс нутгийн хэмжээний стратегийн тагнуулын ажиллагаа явуулж байсан байна.

Цэрэг, зэвсэг техник гаргах ажиллагаа хоёр үе шаттайгаар явагдаж 1992 оны 12 дугаар сард бүрэн шувтарчээ. Үүнтэй нэгэн зэрэг Монголд ажиллаж байсан зөвлөлтийн 20 гаруй мянган мэргэжилтэн, ажилчид ч мөн нутаг буцжээ.

1980-аад онд ЗХУ-ын ЭСЯ-нд ажиллаж байсан дипломатч, монгол судлаач Ю.Н.Кручкин нэгэн баримт дэлгэснийг энд эш татмаар байгаа юм. Тэрбээр “ЗХУ тухайн үед жилд Монголын 4.5 сая малыг толгойг нь 3 рублээр үнэлж авч байсан байдаг. Монгол Улс зөвлөлтийн томоохон мэргэжилтнүүдийг ердөө сарын 3 ам. доллараар ажиллуулж байсан байдаг. Мэдээж хэрэг мэргэжилтнүүд маш өндөр цалин авч байжээ. Гэхдээ тэр цалингийн 97 хувийг ЗХУ төлж байсан юм. XX зуунд ийм хямдхан гадаадын мэргэжилтэн ажиллуулж байсан өөр улс байхгүй. Хоёрдугаарт тэр мэргэжилтнүүд дандаа нэрд гарсан алдартай хүмүүс байсан

байдаг” гэжээ.

ЗХУ-ын “зөвлөмжөөр” БНМАУ-ын Засгийн газар ЗХУ-д хүсэлт тавьж, тийнхүү Зөвлөлтийн хориглолтын бус давшилтын зориулалттай цэргийн асар том бүлэглэл Монголд “түр” байрлаж байсан билээ. Монгол Улс Зөвлөлтийн цэргийн асар том давшилтын хүчийг өөрийн нутагт байрлуулж байсан атлаа Японы Окинава, Өмнөд Солонгост байрлаж байсан АНУ-ын цэргийн баазыг тэдгээр улсуудаас гаргахыг шаардаж байсан юм. Монголын удирдагч Ж.Батмөнх 1985 оны 6 дугаар сард Монгол-Болгарын найрамдлын цуглаан дээр хэлсэн үгэндээ: “АНУ Ази тивд байрлуулсан цэргийн хүчээ улам зузаатгаж, энэ тивийн өргөн уудам газар нутгийг цөмийн дайны талбар болгохоор санаархаж байна. АНУ Японы милитаризмыг сэргээх явдлыг элдвээр өөгшүүлж, Алс Дорнодод цэргийн томоохон эвслийн гол цөм болгох зорилгоор Япон, Өмнөд Солонгостой цэрэг-улс төрийн холбоо байгуулж байна”<sup>2</sup> гэжээ. Тухайн үед БНМАУ-ын удирдлага өөрийн нутаг дэвсгэрт 120 мянган цэргийн бие бүрэлдэхүүнтэй, танкийн 3 дивиз, нисэх хүчний 1 дивиз бүхий хориглолтын бус, давшилтын зориулалттай Зөвлөлтийн цэргийн асар том бүлэглэлийг “өөрийн хүсэлтээр түр” байрлуулж байсан атлаа Япон, Өмнөд Солонгост байрлаж байсан АНУ-ын цэргийн баазыг тэндээс гаргахыг шаргуй шаардаж байв.

Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь 1989 оны найм, есдүгээр

<sup>2</sup> Батмөнх Ж. Илтгэл, хэлсэн үг. УБ.: 1986, 245 дахь тал



сарын заагт Монгол Улсад хариу айлчлал хийж, хоёр орны харилцаа бүрэн хэвийн болсныг нотлов. Айлчлалын үеэр БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхзүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд гарын үсэг зуржээ.

БНХАУ-ын хувьд 1978 оны 12 дугаар сард хуралдсан ХКН-ын ТХ-ны 11 дэх удаагийн чуулганы III бүгд хурлаас эхлүүлсэн эдийн засгийн шинэчлэлийн бодлого амжилтанд хүрэх эсэх нь Хятадыг тойрсон геополитикийн бүсэд гадаад таатай орчинг буй болгон, удаан хугацаанд хадгалах явдал байсан нь тодорхой байв.

Хятадын гадаад бодлого, практик үйл ажиллагаанд гарч байгаа шинэ нөхцөл байдал, хандлагыг гадаад, дотоодод системтэй танилцуулах зорилгоор БНХАУ-ын ГЯЯ-наас эрхлэн жил бүр хэвлэн гаргаж байх “Хятадын гадаад харилцааны товч лавлах-1987” номын анхныхыг 1987 онд Бээжинд хэвлэн гаргажээ. Хятадын ГЯЯ-ны сайд У Сюэцянь оршил бичсэн 12 бүлэг, хавсралт бүхий энэ номд Хятадын 1986 оны гадаад харилцааны тойм хийгээд 1949 оноос хойших Хятадын гадаад харилцааны түүхийг товч өгүүлжээ.

Хоёр орны харилцаа 20 гаруй жил зогсонги байдалд байснаа 1980-аад оны эхэн үеэс хоёр талын хамтын хүчин чармайлтын үр дүнд сэргэн мэдэгдэхүйц ахиц гарч эхэлжээ. 1982 оны 2 дугаар сараас улсын хилийг нэг удаа хамтран шалгаж эхэлсэн бөгөөд 1984 оны 7 дугаар сард ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Ёндон

БНХАУ-д айлчлах үеэр хоёр тал Монгол, Хятадын хилийг анх удаагаа хамтран шалгасан тухай Протокол, түүний хавсралт газрын зурагт гарын үсэг зуржээ. Мөн БНХАУ-ын ГЯЯ-ны сайд У Сюэцяньтай уулзаж ярилцахад Хятадын сайд “Энхтайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр БНМАУ-тай худалдаа-эдийн засаг, соёлын салбарын харилцааг хөгжүүлэх эрмэлзэлтэй байна” гэсэн байна. 1986 оны 8 дугаар сард Хятадын ГЯЯ-ны орлогч сайд Лю Шуцин Монголд айлчилж, ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Ёндонтой хоёр талын харилцаа ба харилцан сонирхож байгаа олон улсын асуудлаар хэлэлцээ хийж, Монгол-Хятадын хоорондын консулын анхны конвенцид гарын үсэг зурав.

БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын Хорооны орлогч дарга Пэн Чун тэргүүтэй парламентын төлөөлөгчид 1987 оны 6 дугаар сард Монгол Улсад айлчилж, төлөөлөгчдийг АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх хүлээн авч уулзжээ. БНМАУ-ын АИХ-ын дарга Л.Ринчин тэргүүтэй АИХ-ын төлөөлөгчид 1988 оны 9 дүгээр сард БНХАУ-д хариу айлчлав. Монголын парламентын төлөөлөгчдийг БНХАУ-ын дарга Ян Шанкунь, БХАТИХ-ын Байнгын Хорооны дарга Вань Ли нар хүлээн авч уулзжээ. Л.Ринчин айлчлалынхаа хүрээнд ХКН-ын ТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн эрхлэгч Жу Ляньтай уулзаж, намын харилцааны асуудлаар санал солилцож, түүнийг 1989 онд БНМАУ-д айлчлахыг урьсан байна.

1988 оны 11 дүгээр сард БНМАУ-ын СнЗ-ийн орлогч дарга Ч.Сүрэн БНАСАУ-д айлчлаад эх орондоо буцах замдаа Бээжинд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Тянь Зиюаньтай уулзаж, хоёр орны хооронд худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлаар санал солилцож байжээ.

БНМАУ-ын ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Ёндон 1988 оны 12 дугаар сард БНХАУ-д айлчилж, БНМАУ, БНХАУ-ын хооронд хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай гэрээнд гарын үсэг зурав. 1985 оноос хоёр улсын ГЯЯ-ны сайд нар НУБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы үеэр уулзаж ярилцсан нь байр сууриа ойлголцоход тус дөхөм болж, уулзалт тогтмолжих төлөвтэй болов.

1988 онд МАХН, ХКН-ын харилцааг сэргээх анхны алхам хийгдсэнээс гадна ХКН-ын ТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн тасгийн дарга Жай Вэньлян өөрийн элчин сайдынхаа зочноор Улаанбаатарт ирж, МАХН-ын ТХ-ны албаны хүмүүстэй уулзаж, намын харилцааны асуудлаар санал солилцож, намын төлөөлөгч, намын баримт бичиг, төв хэвлэл, намын дээд сургуулийн багш нар солилцох, НТХ, ЭСЯ-ны хооронд шууд харилцаа тогтоох шууд харилцаж байх дөрвөн санал тавихад Монголын тал зарчмын хувьд зөвшөөрсөн хариу өгч байжээ.

МАХН-ын ТХ-ны V Бүгд хурал Монгол Улсад гадаад харилцааны салбарт багагүй дутагдал оршиж байгааг анх удаа хурц шүүмжилсэн

юм. Үүнд: нэгд, Улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, хоёрт, гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах, гуравт, олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд олон түмний санаа бодлыг судалж сонсох, нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах явдал дутагдалтай, дөрөвт, ил тод байдал хязгаарлагдмал, голдуу тунхаглах, лоозонгнох шинжтэй байгааг шүүмжлээд үзэл суртал, бусад ялгааг шалтаг болохгүйгээр энхтайвнаар зэрэгцэн орших, итгэлцэх, сайн хөрш байх үндсэн дээр өндөр хөгжилтэй Өрнөдийн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит байдалд нийцсэн олон улсын харилцааны ирээдүйтэй хандлага болсныг анх удаа онцлон тэмдэглэсэн юм.<sup>3</sup>

ХКН-ын ТХ-ны гишүүн, ТХ-ны Гадаад харилцааны хэлтсийн эрхлэгч Жу Лянь тэргүүтэй төлөөлөгчид 1989 оны 7 дугаар сард Монгол Улсад айлчилж, МАХН, ХКН-ын харилцааг бүрэн сэргээв. Эдгээр үйл явц хоёр талын хамтын хүчин чармайлтын үр байв.

1956 онд БНХАУ-аас Монголд буцалтгүй тусламж үзүүлж, 1958, 1960 онд хөнгөлттэй зээл хоёр ч удаа олгож иржээ. Хятадын тусламжаар Монголд нийтдээ 20 гаруй объект

<sup>3</sup> Ж.Батмөнх. “Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилтын тухай” илтгэл. МАХН-ын Төв Хорооны V Бүгд хурал. УБ., 1988, 108-109 дэх тал

барьж, Монголын саналыг үндэслэн дуусгаагүй үлдээсэн 7 объектыг 1973 оны 3 дугаар сард тухайн үеийн үнээр Монголын талд шилжүүлж байжээ. Хятад ажилчдыг Монголын үйлдвэр, барилга, байгууламж дээр ажиллуулах тухай 1955, 1960 оны хэлэлцээрийн дагуу 1955-1964 онд БНХАУ олон тооны ажилчид, мэргэжилтнээ илгээж, Монгол Улсын шинэ бүтээн байгуулалтын үйлсэд зохих хувь нэмрээ оруулсан юм. Монголын Засгийн газрын шаардлагаар 1964 оны 4 дүгээр сард Монголд тусалж байсан хятад ажилчид, тэдний гэр бүлийнхэн нутаг буцжээ.

Монгол, Хятадын худалдаа 1950-иад он, 1960-аад оны эхээр хурдацтай хөгжиж, худалдааны эргэлт харьцангуй өндөр байснаа 1960-аад оны дунд үеэс аажмаар буурч, 1970-аад оны сүүлчээс хойш дахин бага багаар өссөөр иржээ. 1985 онд хоёр орны хооронд хилийн худалдаа хөгжүүлэх баримт бичиг солилцож, улмаар хэрэгжүүлж эхлэв. 1986 онд хоёр орны худалдааны хэмжээ 24.9 сая швейцарь франк болж өмнөх оны протоколын дүнгээс 66 хувиар өссөн байна. Энэ нь Монгол Улс төмөр замын транзит тээврийн орлогын 60 хувьд нь 13.8 сая швейцарь франкийн бэлэн бараа бүтээгдэхүүн импортоор авсантай холбоотой байв. 1986 оны 4 дүгээр сард Бээжинд 1986-1990 онд харилцан бараа нийлүүлэх ба төлбөрийн тухай Монгол-Хятадын Засгийн газар хоорондын анх удаагийн урт хугацааны худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд дурдсан хугацаанд худалдааны нийт эргэлт 51-52 сая швейцарь франк

хүрэх ёстой байв. 1987 онд хоёр орны худалдааны нийт эргэлт 27 сая швейцарь франк, 1988 онд 46 сая швейцарь франк болсон бөгөөд түүний дотор улсын худалдаа 22.7 сая, хилийн шууд худалдаа ба бараа солилцоо 23.9 саяд хүрчээ.

1988 оны 7 дугаар сард Улаанбаатарт Монгол, Хятадын хилийн худалдааны хэлэлцээний 8 дахь үе шат болж өндөрлөжээ. Хэлэлцээнд Монголын талаас гадаад худалдааны Монголэкспорт, төрөл бүрийн барааны Импэкс, Материалимпэкс, Хоршоолол Импэкс, Дорноговь аймгийн Худалдаа бэлтгэлийг удирдах газар, аймгийн Материал техникийн хангамжийг удирдах газар, Хятадын талаас ӨМӨЗО-ны Гадаад худалдааны танхим, Хилийн худалдааны компани, түүний Эрээн хотын салбарын төлөөлөгчид оролцжээ. Энэ удаа Замын-Үүд, Эрээн хотын төлөөлөгчид анх удаа шууд хэлэлцээ хийж бараа солилцох зарчим, нөхцлийн талаар анхны гэрээ байгуулсан явдал шинэ алхам болов. Хоёр орны хилийн худалдаа 1986 онд 1.4 сая, 1987 онд 2.8 сая 1988 онд 17 сая швейцарь франк болж огцом өсчээ.

Хоёр талын зөвхөн 1989 оны 12 дугаар сарын хилийн худалдааг өнөөдөр тэмдэглэхэд нэн сонирхолтой. Тухайлбал: Монголын тал 120 тонн хаягдал төмөр, 60 тонн яс нийлүүлж, оронд нь 400 ширхэг халуун сав, 3000 ширхэг будаатай шаазан аяга, 1000 хайрцаг хүж, 400 боодол хамрын тамхи, 300 ширхэг хадаг, 1-7 насны хүүхдийн хос гутал 600, 13-16 насны хүүхдийн хос гутал 300, 500 ширхэг

даавуун шаахай, 300 ширхаг том хүний биеийн тамирын хувцас, 1000 ширхэг нусны алчуур, 300 ширхэг 25-ын сумтай үзэг авч байжээ.

1978 оноос эхлэн Монгол, Хятадын хоорондын худалдааны тооцоог чөлөөлт валютаар хийх болж, швейцарь франкийг төлбөрийн нэгж болгохоор тохиролцжээ.

1986 оноос эхлэн зуны улиралд Монголын нисэх онгоц, галт тэрэг Улаанбаатар-Бээжингийн хооронд жуулчид, зорчигч тээвэрлэж, 1987 оноос Улаанбаатар-Бээжингийн хооронд онгоц тогтмол нислэг үйлдэх болов. Төмөр замын тээвэр, цаг уурын мэдээ тогтмол солилцох болсон байна.

1983 оны 11 дүгээр сард Монголын чөлөөт бөхийн баг Хятадын талын урилгаар айлчилж, хоёр орны соёл, урлаг, спортын солилцоог сэргээв. 1984 онд Хятадын чөлөөт бөхийн баг Монголд хариу айлчилж, Хятадын дүрслэх урлаг, чимэглэлийн үзэсгэлэн Улаанбаатарт нээгдэв. Монголын ардын зураач Цүлтэмийн уран бүтээлийн үзэсгэлэн 1985 онд Бээжинд нээгдэж, Монголын ардын дуу бүжгийн чуулга, Өвөр Монголын урлагийн хэсэг харилцан айлчлан тоглолт хийв. Мөн оны 10 дугаар сард Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн дарга Б.Мягмаржав тэргүүтэй төлөөлөгчид Хятадад айлчлав.

1986 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо Соёлын солилцооны төлөвлөгөөнд гарын үсэг зурж, жил болгон сунгах болов. Энэ нь 1967 оноос хойш хоёр орны Засгийн газар гарын үсэг зурсан соёлын солилцоо хэрэгжүүлэх

анхдагч төлөвлөгөө болов. Дурдсан төлөвлөгөөний дагуу хоёр улс багш, мэргэжил дээшлүүлэгч харилцан солилцож, Монголын багш нар Бээжингийн их сургуульд багшилж, зохиолчдийн төлөөлөгчид солилцож, Монголын ХАА-н судалгааны хэсэг Хятадад очиж, Хятадын монгол хэл, утга зохиол судлаачид Монголд айлчилж, Шаньдунгийн циркийн хамтлаг Монголд айлчлан тоглов. Монголын талын урилгаар Хятад-Монголын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн Жан Вэйле тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилжээ.

Хоёр орны харилцааны энэхүү таатай уур амьсгалыг дагалдаад МҮЭ-ийн ТХ, МХЗЭ-ын ТХ, Монголын Эмэгтэйчүүдийн Хороо, МЭТНБХ-ны Гүйцэтгэх Хороо, Монголын Зохиолчдын Эвлэл, МСХ-ны төлөөлөгчид БНХАУ-д айлчлах болов.

Ийнхүү БНМАУ, БНХАУ-ын хамтын хүчин чармайлт, олон улсын харилцааны таатай уур амьсгалын үр дүнд 1980-аад оны сүүлчээс хоёр орны харилцаа бүрэн хэвийн болов.

1990 оны 5 дугаар сард БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат БНХАУ-д айлчилсан нь Монголын төрийн тэргүүн анх удаа гадаад дахь айлчлалаа Хятадаас эхэлснээр өмнөх шинэ удирдагчдын нэн тэргүүнд ЗХУ-д айлчилдаг арга барилтай огт адилгүй хэрэг болов хэмээн гадаадын хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн онцгой анхаарлыг татахад хүргэсэн юм. 1991 оны 8 дугаар сард БНХАУ-ын дарга Янь Шанкунь БНМАУ-д айлчилсан нь хоёр орон 1949 онд дипломат

харилцаа тогтоосноос хойш Хятадын төрийн тэргүүний Монголд хийсэн анхны айлчлал болов.

1994 оны 4 дүгээр сард БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн Монгол Улсад Хятадын Засгийн газрын тэргүүний хувиар айлчилж, хоёр орны харилцааны болон дэлхий дахины өөрчлөгдөн буй нөхцөл байдлыг харгалзан улс төр, эрхзүйн суурь зарчмыг шинээр тодорхойлсон баримт бичиг “Монгол Улс, БНХАУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ”-нд гарын үсэг зурсан нь нэн чухал ач холбогдолтой үйл явдал болов.

1998 оны 12 дугаар сард БНХАУ-ын дарга Зянь Зэмийн урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадад төрийн айлчлал хийж, хоёр тал “Хамтарсан мэдэгдэл” гаргаж, хоёр орны харилцааг ХХI зуунд хандсан урт хугацааны тогтвортой, сайн хөршийн найрсаг харилцааны ирээдүйн хөгжлийн хандлагыг тодорхойлов. 1999 оны 7 дугаар сард БНХАУ-ын дарга Зянь Зэминь Монгол Улсад төрийн айлчлал хийж, хоёр орны сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны агуулгыг нэмэн баяжуулж, харилцан итгэлцлийг улам бэхжүүлэв. ХХ зууны хоёр орны харилцааны түүх нь эрчимтэй хөгжил, зогсонги байдал, хамтын хүчин чармайлт, харилцаа сэргэсэн үе шатуудыг дамжин хэвийн голдиролд орсноор ХХI зуунд илүү үр бүтээлтэй хамтран ажиллах шимтэй хөрсийг буй болгосон он жилүүд болов.

## НОМЗҮЙ

1. Горбачев М.С. Перестройка и новые мышление для нашей страны и для всего мира. Изд. Политической литературы. М.: 1988

2. Горбачев М.С. Избранные речи и статьи. Изд. Политической литературы. М.: 1989

3. О.Чулуун (Ч.Далай). БНМАУ ба БНХАУ-ын харилцааны асуудал. УБ., 1974

4. Далай Ч. Отношения между МНР и КНР (1949-1984 гг.) Автореф. докт. дисс.

Инст. Истории АН МНР, УБ., 1986

5. Монгол Улс. Гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. IX боть. (1990-2001). УБ., 2001

6. Китайская Народная Республика: 1984 политика, экономика, культура. М.: 1987

7. Китайская Народная Республика: 1986 политика, экономика, культура. М.: 1988

8. Китайская Народная Республика: 1987 политика, экономика, культура. М.: 1989

9. Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990

10. Китайская Народная Республика: политика, экономика, культура в 1989-1990 годах. М.: 1992

11. М е ж д у н а р о д н ы й Ежегодник: Политика и экономика-1988. М.: 1988

12. М е ж д у н а р о д н ы й Ежегодник: Политика и экономика-1989. М.: 1989

13. Энциклопедия Нового Китая.  
(перевод на русский язык с сокр.)  
Изд. “Прогресс”, М.: 1989

14. Проблемы Дальнего востока.  
Жур: ИДВ АН СССР. № 1988-1992

15. Мировая экономика и  
международные отношения. Жур:  
ИМЭМО АН СССР. № 1988-1991

16. Визит Генерального  
секретаря ЦК КПСС, Председателя  
Президиума Верховного Совета  
СССР М.С. Горбачева в Китайскую  
Народную Республику 15-18 Мая  
1989 года. Документы и материалы.  
Изд. Политической литературы. М.:  
1989

17. БНМАУ-ын Улс Ардын Аж  
Ахуй-70 жилд (1921-1991) УБ., 1991

18. БНМАУ-ын Эдийн засаг,  
нийгмийн хөгжил 1921-1988 онд.  
Статистикийн эмхтгэл. УБ., 1989

19. “Цаг үе” сэтгүүл. Монгол  
пресс. УБ., № 1986-1990



## ХҮЧИРХИЙЛЛИЙН БУС ТЭМЦЛИЙН АРГА БА “ӨНГӨТ ХУВЬСГАЛ”

докторант С.Сүхчулуун

*“... Дайны урлагийн дээд цэг бол дайснаа тулалдахгүй, цус урсгахгүй ялах явдал юм.”*

*Күнз*

Сүүлийн он жилүүдэд улс төрийн шинжлэх ухаан болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр “өнгөт хувьсгал” хэмээх нийгэм, улс төрийн шинэ үзэгдлийг ихээхэн ярьж дүгнэлт хийн, энэхүү ажиллагааны үүсэл, гарвалын талаар хэлэлцэх болжээ. Тэгвэл зарим судлаачид “Өнгөт хувьсгал” гэдэг нь хэдий шинэвтэр ойлголт хэдий ч эхлэлийг өнгөрсөн үеэс улбаатайгаар тайлбарладаг.

Нийгмийн шударга бус үзэгдэл, төрийн удирдлагын алдаатай бодлого үйл ажиллагааг хүчирхийллийн бус аргаар, ард нийтээр эсэргүүцэх үзэл санааг XIX-XX зууны их сэтгэгч Г.Д.Торо, Л.Н.Толстой, Махатма Ганди, Мартин Лютер Кинг нар дэвшүүлсэн. Тэд “Хүчирхийллийн эсрэг хүчирхийллийн аргаар тэмцэх бус, харин хүчирхийллийн бус аргаар тэмцэж байж амжилтад хүрнэ” гэсэн онолыг шашин, гүн ухаан, зан суртахууны хосолмол шинж чанарт үндэслэн номлож байжээ. М.Ганди Их Британийн колоничлолоос Энэтхэгийг чөлөөлж, М.Л.Кинг АНУ-д арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг халахын төлөө хийсэн ард түмний эрх чөлөөний хөдөлгөөнийг удирдан

амжилтад хүргэснээр өөрсдийн боловсруулсан онол, номлолын үнэн зөв, хүчирхийллийн бус тэмцэл асар хүчтэй болохыг амьдрал практикт нотолсон байна.

Хүч үл хэрэглэх үзлийн орчин цагийн “өнгөт хувьсгал” онол арга зүйн үндсийг Харвардын их сургуулийн профессор Жийн Шарп боловсруулж, түүний судалгааны материалууд ТТГ-ын “Өнгөт хувьсгал хийх арга зүйн гарын авлага” болжээ.

Өнөөдөр ихэнх судлаачид “өнгөт хувьсгал бол тухайн улсад улс төрийн системийг хямруулахад чиглэгдсэн ард иргэдийн тархийг угаасан идэвхтэй үйл ажиллагаа” бөгөөд энэ нь “улс төрийн тодорхой зорилгод хүрэхийн тулд нэгэн загвар гэж хэлж болох тухайн үед бий болгосон нийгмийн сэтгэлзүйн үелзэл дээр мэдээллийн орон зайг ашиглан тоглосон технологи юм” гэсэн тодорхойлолтыг дэвшүүлээд байна.



*“Хувьсгалд өөрийн цнэт зүйлээ алдагсад энэ цгийг хэрэглэх дургүй байдаг юм.” Л.Д.Троцкий.*

Хэрэв хувьсгал мөн юм бол бусад хувьсгалаас юугаараа ялгаатай юм? гэсэн асуулт гарч ирэх байх.

Төв болон Зүүн Европт гарсан 1989 оны хувьсгалын талаарх ойлголт нэлээд маргаан дэгдээж, судлаачдыг хоёр хэсэгт хуваажээ. Хувьсгал биш гэж үздэг хэсэг нь хувьсгалын нийгмийн шинж чанар нь ойлгомжгүй, гадны нөлөөлөлтэй, зарим оронд олон нийтийн байгууллагуудын оролцоо сул гэх зэрэг шинжүүдийг гаргаж тавьсан байдаг.

“Өнгөт хувьсгал” нь:

- Удирдагчийг засгийн эрхээс огцруулах үйл явц зөвхөн хүчирхийллийн бус арга хэрэглэхээс гадна зарим шаардлагатай үед (Ирак, Ливи, Сири) зэвсэгт түрэмгийлэл үйлддэг;
- Улс төрийн гол хүч нь улс төрийн нам бус, төрийн бус байгууллагуудын өргөн хүрээтэй холбоо-эвсэл байдаг;
- Хууль дүрэм, үйл явдал өрнөх явцад бус, харин дараа нь хувьсгалт үйл явц хууль зүйн дагуу болсон гэж зарласнаас хойш хэрэгждэг;
- Хүчирхийллийн бус тэмцлийн үед сөрөг хүчний тал хууль зөрчихийг үл тоох ба ихэнхдээ биеийн хүч, зэвсэг хэрэглэдэггүй;
- Хувьсгал зохион байгуулах ашигтай үе нь улс төрийн сонгууль байдаг;
- Сөрөг хүчнийхэн өөрийн

ялалтаа урьдчилан мэдэгдэх ба бусад үр дүнг хуурамч гэж үздэг;

- Үндсэн арга нь хотын төв талбай дахь олон нийтийн цуглаан, засгийн газрын гол барилгууд руу очиж, боломжийг боогдуулах, эсвэл эзлэн авдаг зэргээрээ онцлогтой.

Өнгөт хувьсгал гарсан улс орнуудын алинд ч сонгодог “хувьсгалын тохироо” бүрдээгүй байдгаараа онцлогтой юм.

Хувьсгалын тохироо гэдэг нь “Доодчуул нь өмнөх шигээ амьдрахыг хүсэхгүй, Дээдчуул нь өмнөх шигээ захирч чадахгүй болохыг хэлнэ.” гэж В.И.Ленин тэмдэглэн хэлсэн байна.

### *Улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх “Өнгөт хувьсгал”-ын тогтолцоо*


Ерөнхийлөгч Рональд Рейганы үед хүчирхийллийн бус тэмцлийн үзэл санааг АНУ-ын эрх ашигт үл нийцэх улс төрийн дэглэмийг өөрчлөхөд ашиглах онол, арга зүйн гол үндсээ болгосон төрийн гадаад бодлогын хэмжээнд хэрэгжүүлэх улс төр, санхүү, зохион байгуулалтын зарчмын чанартай арга хэмжээг авсан байдаг. Тухайлбал, 1983 онд АНУ-ын Ардчилсан нам, Бүгд Найрамдах намын хамтарсан ажлын хэсгийн боловсруулсан “Ардчиллыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг ерөнхийлөгч баталж, даян дэлхийд ардчиллыг хөгжүүлэх, төлөвшүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой дор дурдсан төрийн бус байгууллагуудыг тодорхой чиг үүргийн дагуу байгуулсан. Үүнд:

- “Ардчиллыг дэмжих үндэсний сан” (үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, санхүүжилтийг хуваарилах)/;
- “Ардчиллын олон улсын хүрээлэн”, “Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэн” (үйл ажиллагааг газар дээр нь зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх);
- “Олон улсын хувийн үйлдвэрлэгчдийн төв”, “Олон улсын хөдөлмөрчдийн эв нэгдлийн Америкийн төв” (үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг төрөл бүрийн сангаас хөрөнгө босгох);
- “Нээлттэй нийгэм хүрээлэн, Соросын сан”; (үйл ажиллагааг санхүүжүүлэх, төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэх, сургалт

зохион байгуулах);

- “АНУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг” (үйл ажиллагааг санхүүжүүлэх, улс төрийн дэмжлэг үзүүлэх);
- “Альберт Эйнштейний Хүрээлэн” (гадаад улсуудын сөрөг хүчнийг сургаж бэлтгэх, онол арга зүйн гарын авлага боловсруулах)/;
- “Тухайн улсад суугаа ЭСЯ” (үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох дэмжлэг үзүүлдэг) зэрэг болно.

АНУ-ын сенатор Жон Маккейн удирдагч М.Каддафийн дэглэмийг нураасны дараах үр дагавар нь “ардчилсан өөрчлөлтийг эрмэлзэгч” бусад улсад дохио өгөх болно. Энэ нь Башар Асад, Йемен болон бусад дарангуйлагч нарт өгөх нэг ёсны



сануулах дохио юм. “Арабын хавар”-ын цууриаг Орос, Хятадаас эхлээд Израил хүртэл бүх дэлхий сонсох болно. Нэгэн залуу талбайд өөрийгөө шатааж, Тунист эсэргүүцлийн давалгаа эхлүүлснээс хойш бид хурдацтай өөрчлөгдөж буй дэлхийг харж байна” хэмээн мэдэгдсэн байдаг.

“Өнгөт хувьсгал” хийх санхүүгийн гол эх үүсвэрийг “Зүүн Европ дахь ардчиллыг дэмжих” чиглэл бүхий америкийн сангуудаас гаргасан. Энэ хөрөнгө бол АНУ-ын Төрийн департаментын төсвийн тал хувийг эзэлсэн. Сербид дээрх сангуудаар дамжуулан 90 сая долларын санхүүжилт, харин Украины “Өнгөт хувьсгал”-д 85 сая долларын санхүүжилтийг тус тус гаргажээ. Жорж Сорос 2004 онд Давосын эдийн засгийн чуулган дээр Гүржийн идэвхтнүүд “сарнайн хувьсгал” хийхдээ түүний санхүүжилтийг авсан гэж албан ёсоор хэлсэн. Жорж Бушийн засаглалын үед ардчилсан өөрчлөлт хийхийн тулд нийтдээ 5 млрд доллар зарцуулсан талаарх баримт ч байв.

### “Өнгөт хувьсгалын технологи”

АНУ-ын геополитикийн ашиг сонирхолд нийцээгүй аливаа улс орны улс төрийн дэглэмийг өөрчлөх бодлого нь цогц шинжтэй, нарийн боловсруулсан технологийн дагуу хэрэгждэг байна. Энэхүү технологи нь дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдаг. Үүнд:

*Хүн амыг дайчлах.* Хувьсгалыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай чухал нөхцөл нь улс төрийн байнгын өндөр идэвхжилтэй

олон нийт, нийгмийн бүлэг, олон нийтийн байгууллагуудаас бүрдсэн байх;

*Сүлжээ зохион байгуулах.* Салаа мөчир мэт задаргаатай, хүчтэй нөлөө бүхий “эсэргүүцлийн хүч” байгуулагдсан байх бөгөөд өөрөөр хэлбэл “сөрөг хүчнийг дэмжигч нөлөө бүхий хүч”-ийг бүрдүүлэх ба босогчид эрс шийдэмгий итгэл үнэмшилтэй, зохих дадлагатай болсон байх;

*Засгийн эрхийг булаан авах.* Тухайн засгийн эрх баригчдыг солих, эсвэл сонгуульд нэрдэвшигчийн ажиллагааг хааж боогдуулах, шаардлага хангах боломжийн толгойлогчийг нэр дэвшүүлэх;

*Ард түмэнд эрх баригч засгийн сөрөг дүр төрхийг бүрдүүлэх.* Эсрэг этгээдэд нийгэм, соёлын хэм хэмжээний саад бий болгож, улс төрийн дэглэмийн дотоодын хууль ёсны сэтгэл зүйн үндсийг эвдэх;

*Олон нийтийн ухамсрыг далдаас удирдах.* Мэдээлэл-сэтгэл зүйн арга хэрэглэх ба олон нийтийг удирдахад маркетинг буюу өнгөт хувьсгалын “брэндинг”-ийн технологи өргөн ашиглах; (төрөл бүрийн уриа лоозон, энгэрийн тэмдэг, хүчтэний оролт, тууз, концерт, компьютер тоглоом, олонд танигдсан дуунд өдөөн хатгасан шинжтэй гуйвуулсан текст оруулах, хошин шог, улс төрийн агуулгатай хүчлэлдэйн кино. Бүхий л хувьсгалын удирдамж болсон “Дайснууд бидний эсрэг” гэсэн хялбар бөгөөд ойлгомжтой үзлийг олон нийтийн ухамсарт суулгаж бэхжүүлэх).

*Бэлгэдэл бий болгож хэрэгжүүлэх.* Өнгөт хувьсгалын

арга технологийг хэрэгжүүлэх уриа лоозон, бэлгэдэл хэрэглэх; (Өнгөт хувьсгал өнгө, бэлгэ тэмдэгт их ач холбогдол өгдөг. Учир нь тэмдэгт зүйл нь аман мэдээллийн харьцаанаас иргэдийн сэтгэлзүйд илцүтэйгээр нөлөөлдөг. Тэд хувьсгалынхаа бэлгэ тэмдгээр “улаан сарнай”, “улбар шар”, “өнгө зангидсан гар”-ыг зүгээр ч нэг санамсаргүйгээр сонгодоггүй).

*Хамгийн их дэмжлэг авахуйц нутаг дэвсгэр-газар орныг сонгон авах.* Тухайн улсын газарзүйн хувьд өнгөт нэр дэвшигчийн имиджийг бүрдүүлж буй дэмжигч иргэд, сөрөг хүчний нам, эсэргүүцлийн жагсаал, цуглаан зохион байгуулагчдын байрлаж буй нутаг дэвсгэрийг сонгох; (Энэхүү газар нутаг нь сөрөг хүчний байр суурийг бэхжүүлж, түгээх түшиц газар болдог. Жишээ нь, Украины хувьд ийм газар нутаг нь Тусгаар тогтнолын талбай-Майдан ба Украины баруун мужууд, Гүржид нийслэл Тбилис байсан. Ийм газар нутагт сонгуулиар тодорсон ерөнхийлөгчийн эрхийг “де-факто” хүлээн зөвшөөрдөггүй).

*Үнэн, шударга нотолгооны бааз бүрдүүлэх.* Өөрсдийн байр сууриа хууль ёсных болгохын тулд шалгаагүй бодит бус завсрын үр дүнг олон нийтэд шуурхай хүргэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг хүчнийг дэмжигч гадаадын ажиглагчдын үзэл бодлыг түгээх зэрэг субъектив, ихэнхдээ хуурамч мэдээлэл (“fake news”) түгээх аргыг ашиглах; (Иймэрхүү ажиллагааны эцэст сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны үр дүнг нийгмийн олонхи хүлээн зөвшөөрөхгүй байдалд хүргэдэг).

*Олон нийтийн ухамсарт ялалт зайлшгүй гэдэг итгэлийг бүрдүүлэх.* “Ард түмний эсрэг хүч хэрэглэж болохгүй”, “ард түмнийг ялж болохгүй” гэх үзэл санааг нийгмийн ухамсар, хүчний байгууллагуудын ажилтнуудын ухамсарт суулгаж өгөх; (Жишээ нь, В.Ющенкогийн вэб сайтад “Ющенко ялалт байгуулахад 40, 30, 5 хоног үлдлээ гэсэн гүйж буй мөр байршуулсан байдаг. Энэ нь олон нийтийг хамтын далд удирдлагатай сэтгэл хөөрлийн дэглэмд хүргэдэг).

*Төрийн байгууллага, бүтэц засаг захиргааны барилга байгууламж, ХМХ-ийн редакцын үйл ажиллагааг хааж боогдуулах.* Хямралын үед төрийн удирдлагын байгууллагууд улс орны хэвийн амьдралыг хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх, онцгой асуудлыг шуурхай шийдвэрлэх, онцгой шийдвэр гаргахад хаалт хийх; (Эсэргүүцэгчид зөв ажилласан тохиолдолд хааж боогдуулах арга нь нийгэмд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Энэ нь гадна талдаа ардчиллын төлөө тэмцэл мэт харагдуулна).

*Сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх.* Сонгуулийн үр дүнд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлэн, урьдчилан бэлдсэн хүч хэрэглэж, дарамт үзүүлэх, эсэргүүцэх зорилго бүхий эсэргүүцлийн хөдөлгөөнийг зохион байгуулах; (Ийм нөхцөлд эрх баригч засгийн газар хямралыг “ардчиллын бус аргаар”, хүч хэрэглэн шийдвэрлэх аваас түүний нийгэмд эзлэх байр суурь илт унах тул үнэн хэрэгтээ барьцаанд ордог).

*Нийслэлийн ач холбогдол.* Үндсэн арга нь хотын төв талбай дахь олон







- Засгийн эрхийг булаан авахад чиглэсэн олон нийтийн эсэргүүцлийн жагсаал цуглааныг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд хүч хэрэглэсэн үйлдэл гаргах;
- Тухайн улсад улс төрийн орчин өөрчлөгдөх нөхцөл байдлыг үүсгэх. (Өнгөт хувьсгал өрнөсөн туршлагаас харахад энэ үе нь нэгээс хэдэн хоног буюу харьцангуй богино хугацаанд үргэлжилнэ. Үр дүн нь гудамжинд гарч ирсэн жагсагчдын тоо, лидерүүдийн идэвхтэй ажиллагаанаас илт хамаарна).

**Тавдугаар шат – Шинэ засгийн газрыг хууль ёсных хэмээн зарлах**

Гадны удирдах хүчин, хууль ёсны хүрээнд шинэ засгийн газрыг “хууль ёсных” хэмээн зарлах. (Энэ үеийн онцлог нь олон нийтийн сэтгэл хөдлөл хүчтэй бүлэглэсэн, төрийн удирдлагын бодит тогтолцоо нурсан, нийгэм, улс төр, эдийн засгийн хямрал тод илэрсэн байна. Энэ үе нь гаргасан шийдвэрт ямар нэгэн хориг тавина гэхээс айж эмээхгүйгээр гаднын удирдагч хүчний стандартын

дагуу амьдралын шинэ хэв загварыг тогтооход хамгийн тааламжтай үе байна. Хуучин засгийн газрыг хууль ёсных бус хэмээн зарлах таатай боломж юм)

**Зургаадугаар үе шат – Хууль эрх зүйн орчинд эргэж ирэх**

Төрийн удирдлагын албан тушаалтнуудыг томилж, засгийн босоо удирдлагыг өөрийн стандартын дагуу байгуулах зэрэг болно.

**“Өнгөт хувьсгал”-ын өрнөл**

- 1989 онд Чехийн “Хамба хилэн хувьсгал”. Үүнтэй төстэй ажиллагаа Зүүн Европын зарим оронд гарсан;
- 2000 онд Сербид “Бульдозерийн хувьсгал” эхэлж, улмаар ерөнхийлөгч асан Слободан Милошевичийг огцруулан, Гаагийн шүүхэд өгснөөр дууссан;
- 2003 оны Гүржид “Сарнайн хувьсгал”;
- 2004-2005 оны зааг дээр Украинд “Улбар шар хувьсгал”;
- 2005 оны 5 дугаар сард Киргизэд “Алтанзулын хувьсгал”;
- 2005 он Ливаны “Хуш модны



- хувьсгал”;
- 2006 оны Белоруссын хувьсгал;
  - 2008 онд Арменид хувьсгал хийх оролдлого;
  - 2009 оны Молдавын хувьсгал;
  - 2010 онд Киргизэд гарсан 2 дахь хувьсгал;
  - 2014 оны “Евромайдан Европын холбоог сонгох Украины сонголт”-ыг тус тус нэрлэж болно.

Мөн Узбекистанд бослого гаргахыг завдсан, Азербайжанд төрийн эргэлт хийх бэлтгэлийг илчилсэн зэрэг тогтворгүй байдлыг бий болгох урсгал нь 2003-2005 онд гэнэтийн байгаагүй гэдэг. Үнэхээр сүүлийн хэдэн арав гаруй жилийн хугацаанд улс төрийн хямралын цикл нь Ойрхи Дорнод, Магриб, Хятад, Бразилд ч болж байсан.

Дэлхийн хэмжээнд ардчиллыг төлөвшүүлэн хөгжүүлэх бодлогыг АНУ-ын үе үеийн ерөнхийлөгч нар өнөөг хүртэл хэрэгжүүлсээр ирсэн байна. Дэлхийн хэмжээнд ноёрхлоо бататгах зорилгоор АНУ нь бусад улсын дотоод хэрэгт хэрхэн түрэмгийлж оролцсон талаар Америкийн судлаач Уильям Блумын тооцоогоор:

- Гадаад улсын засгийн эрх мэдлийг унагах 50 гаруй оролдлого хийсэн. Эдгээр улсын төр засгийн тэргүүн нь ардчилсан сонгуулиар сонгогдсон байжээ;
- 30 гаруй улсын ардчилсан сонгуульд хөндлөнгөөс

бүдүүлгээр оролцсон;

- Гадаад улсын төр, засгийн удирдагчийн амь насанд 50 гаруй удаа халдсан;
  - 30 гаруй улсын хүн амыг бөмбөгдсөн;
  - 20 гаруй улсын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг нухчин дарахад хөндлөнгөөс оролцсон;
- Бас өөр нэг судлаачийн тэмдэглэснээр Вашингтоны дэмжлэгтэйгээр Югославын дэглэмийг 1999 онд унагаснаас хойш АНУ дэлхийн 64 улсад засгийн эрхийг хууль бусаар булаан авахад оролцсон байна.

Өнгөт хувьсгал хэдий хүчирхийллийн бус тэмцлийн арга ч гэлээ жагсагчдыг хүчээр тараах гэсэн оролдлого нь аймшигт эмгэнэлд хүрсэн тохиолдол нэг биш. Жишээ нь, “Евромайдан”-ы үеэр Киевт 98 хүн нас барж, Киргизийн нимбэгэн хувьсгалаар 48 хүн буудуулж, 1500 хүн шархадсан байдаг. Монгол Улсад 2008 оны 7 дугаар сарын 1-ний хэрэг явдлаар 5 хүн амиа алдаж, хэдэн арван хүн гэмтэл бэртэл авсан билээ. Энд дурдахад 7 сарын 1-ний хэрэг явдал дэлхийн өнгөт хувьсгалын жагсаалтыг “ноолууран хувьсгал” гэсэн нэртэйгээр нэмсэн байдаг. Тэгэхээр “өнгөт хувьсгал” гэдэг нь аяндаа гардаг зүйл биш бөгөөд доороосоо дэмжлэг авч, санаатайгаар нарийн зохион байгуулсан үйл явц ажээ.

## ОЛОН УЛСЫН ТЕРРОРИЗМЫН СУПЕР АЮУЛ

*доктор, дэд профессор Д. Дэлгэрсайхан*

Аюулыг төрүүлж буй эх булгаас нь хамаарч байгалийн, нийгмийн, техногенийн гэж хуваан авч үздэг. Байгаль, техногенийн аюулын цар хүрээ өсөн нэмэгдэж дайны аюултай дүйх, давах түвшинд ирж байгаа ч терроризмын аюулын түвшин эрс өсч, ухамсартайгаар үйлдэгдэж, дэлхий нийтийн сэтгэл санааг зовоож байна. Аюулт үзэгдэл, үйлдэл, ажиллагаа ихсэхийн хэрээр түүнээс сэргийлэх, хамгаалах, тэмцэхэд чиглэсэн ухамсарт үйлдэл, үйл ажиллагаа мөн өсөн нэмэгдэж байна. Энэ чанараараа нийгмийн хөгжлийн явцад үүсч бий болсон зарим аюул (дайн, бослого, терроризм)-ыг нийгмийн хэсэг бүлгээс зориуд зохион байгуулан төрүүлж байна. Дайн, терроризмын аюул бол нийгмийн онцгой үзэгдэл, хэдийгээр нийгэм бүхэлдээ түүнийг буруушааж, түүнээс сэргийлэх, зогсоохын төлөө байдаг ч хэдэн мянган жил үргэлжилсээр, тэлсээр, хувьсан өөрчлөгдсөөр өнөө үетэй золгоод байна.

Терроризмын аюул нэн эртнээс уламжлагдаж ирсэн хөгжлийн түүхтэй ч ХХ зуунд нэг хэсэгтээ намжмал байдалтай байснаа “галт уул” лугаа дахин сэргэж, улам бүр эрчимжиж, даяар, супер шинжтэй болоод байна. НАТО-гийн Ерөнхий командлагч асан Джон Галвин энэ

асуудлаар хэлэхдээ: “Хүйтэн дайнд бид яллаа. Далан жилийн тасалдлын дараа бид сүүлийн 1300 жилийн гол сөргөлдөөний тэнхлэгтээ буцаж ирлээ. Энэ нь Исламтай хийх их зөрчилдөөн юм” хэмээсэн байхад, Уэсли К.Кларк (мөн НАТО-гийн командлагчаар 1997-2000 онд ажиллаж байсан) “Ойрхи Дорнодын асуудлаар баримталж ирсэн уламжлалт хүчний бодлого нь бага зэргээр тэнд суларсан нь Америкт дайсагнасан хандлагатай цөөн тооны байгууллагын нэг бол Аль-Каида”<sup>1</sup> хүчээ авч өнөөгийн төрхөө олоход нөлөөлжээ.

Дайны аюулаас сэргийлэх, хамгаалах, энх тайван байдлыг сахин хамгаалахын тулд хүн төрөлхтөн олон талт ажил, арга хэмжээг авч, НҮБ-ыг байгуулан тэмцсээр ирсний үр дүнд “том дайн”-ы аюул багасч ирсэн ч “терроризм” гэсэн зах хязгаар нь тодорхойгүй нэгэн аюул дэлхий нийтийн анхаарлыг татах боллоо. АНУ-д 2001 оны 9 дүгээр сарын 11-нд тохиолдсон, Москвад 2002 оны 10 дугаар сар, 2003 оны зун, мөн Бисланд үйлдэгдсэн гашуудалд үйл явдлуудаас хойш огт өөр маягийн дайн-олон улсын терроризмын дайн эхэлсэн болохыг дэлхий нийтэд ойлгуулсан юм.

<sup>1</sup> Уэсли Кларк. Как победить в современной войне. т.137

Олон улсын терроризм шинэ зууны нэг томоохон аюул болон гарч ирэхдээ ердийн тэсэрч дэлбэрэх бодис, гранат, бөмбөг, буу, сум, галт хэрэгслийг түгээмэл ашиглаж, тодорхой дайсантайгаа бус, гэм буруугүй ард иргэд, олон нийтэд амь, нас, эд хөрөнгөд нь занал учруулах, дайралт хийх ажиллагаа явуулж, нийгмийг айлган дарамтлах тактикаар ажиллаж байна. Технологийн хөгжлийг даган террорист халдлага боловсронгуй болж байна. Уулын өвгөнийнхөн хашишаар мансууран амиа золиослодог байсан бол Оросын народникууд бөмбөг тэсэлдэг байлаа. Харин Аль Кайдагийнхан Боинг хөлөглөж, Аум Шинрикогийнхан хорт бодис цацдаг болжээ. Одоо террористууд цөмийн зэвсэгтэй болох цаг ойрхон байна. Терроризм зөвхөн Засгийн газруудыг чичрүүлдэг цаг үеэ өнгөрөөж, хүн төрөлхтний бүхий л соёл иргэншилд заналхийлдэг даяар шинжтэй боллоо.

Бодит байдлаас харахад, терроризмын үй олноор устгах зэвсэг (ҮОУЗ)-ийг ашиглах аюул, түүний онцлог шинжийг стратегийн, оператив-тактикийн гэсэн хоёр түвшинд авч үзэж болох байдал ажиглагдаж байна.

Тэдэнд улс, нийгмийн хууль, ёс суртахуун үйлчлэхгүй, зөвхөн дайны үеийн байдлаар аливаад хандах, өөрсдийн зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө улайран, шунахайран тэмцэх байдал давамгайлах болов.

Энэ эрин бол даяаршлын гэх тодотголтой, хөгжил дэвшил, мэдээлэл, аюул занал энэ бүгд далайц хэмжээ, цар хүрээ нь даяар шинж

чанартай болсон шинэ зуун юм. Тиймээс аюулгүй байдлын асуудлыг авч үзэж шинжлэхдээ мөн л даяар хандлагатай нь холбохгүйгээр түүний мөн чанарыг ойлгож, түүнтэй тэмцэх ажил, арга хэмжээг оновчтой зохион байгуулж чадахгүй юм.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх тухай асуудлыг манайхан үндсэн хуульдаа тусгасан энэ цаг үед хүний аюулгүй байдлыг хангах нь төр, нийгмийн асуудалд хандах анхдагч зарчим болж байна. Терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, аюулгүй байдлыг хангах нь энэ үүднээс түүнд хандах юм бол эрэмбийн хувьд нэгдүгээрт тавигдах асуудал болжээ.<sup>2</sup>

Монгол Улсын нутаг дэвсгэр цөмийн зэвсэггүй бүс байх, цөмийн хэрэгслээс ангид байлгах бодлого баримтлах, тийм хэрэгслийг байрлуулахгүй байх нь даяар аюулаас ангид байх үндсийг бүрэн бүрдүүлж чадахгүй хэмээн үзэж байна. Цөмийн болон бусад үй олноор устгах зэвсэг (ҮОУЗ)-ийг заавал пуужин, байлдааны онгоц, их буугаар хэрэглэнэ гэж бодож, сэтгэх нь учир дутагдалтай болж байна.


Ердийн иргэний агаарын тээврийн онгоц болон шуудан холбооны хэрэгсэл тэдгээрийг хаана ч хүргэх боломжтой болсон байна. Энэ нөхцөлд ҮОУЗ-ийг тээвэрлэгч хэрэгслийн цохилтоос хамгаалах агаарын довтолгооноо хамгаалах болон ҮОУЗ-ээс хамгаалах цэрэг, тагнуулын хэрэгслийн ач холбогдол, тэдгээрээс хэрэгжүүлэх

<sup>2</sup> Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсын терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс. УБ., 2006. – 232 х

арга хэмжээний үр ашгийн тухай ярих нь учир дутагдалтай асуудал болж буй бөгөөд тэр тусмаа цөмийн хэрэгслээс ангид байлгах бодлого, үйл ажиллагааны хүрээнд ч үл хамаарах асуудал болон хувирав.

Террористууд ҮОУЗ-ийг эзэмшихийн төлөө чармайн зүтгэж байгааг дээд хэмжээний улс төрчид баттай үндэслэлд тулгуурлан ярьж байна. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч Обама: “Алькайда шиг террорист бүлэглэлүүд цөмийн зэвсгийг гартаа оруулбал хэрэглэх нь дамжиггүй юм”<sup>3</sup> гэж хэлсэн байна. Террористууд ҮОУЗ-ийг хэрэглэн террорист халдлага үйлдэхтэй холбоотой “супертерроризм” гэсэн нэр томъёог судлаачид өргөн хэрэглэдэг боллоо. Супертеррорист ажиллагааг хэн ч явуулж болох нөхцөл байдал бий болсон байна. Хэрвээ үй олноор устгах зэвсэг (ҮОУЗ)-ийг террористууд эзэмших юм бол терроризмын аюул даяар шинж өсөн нэмэгдэж, улмаар супер шинжийг агуулах болно. 1986 оны 4 сарын 26-ны шөнө 1 цаг 23 минутад Чернобылийн АЦС-ийн IV блокт дэлхийн түүхэнд гарсан хамгийн том цөмийн осол гарсан юм.<sup>4</sup> АЦС-т дэлбэрэлт болох үед агаарт 190 тонн цацраг идэвхит бодис алдагдсан байна. Цөмийн хөдөлгүүрт байсан 140 тонн цацраг идэвхит түлшний 8 тонн нь гадаад орчинд тархсаныг хожим тогтоосон байна. АЦС-д дэлбэрэлт болсоноос хойш 14 хоногийн турш

түймэр дэгдэж, Чернобылийн орчимд байсан хүмүүс Хиросимо хотод дэлбэрсэн атомын бөмбөгнөөс 90 дахин их цацрагийн хордлогод өртсөн байна. Дэлбэрэлтийн үеэр 30 км-ын эргэн тойрон газар, нийтдээ 160 мянган квадрат км талбай бүхий Украин Улсын хойд хэсэг, Беларусь, Оросын баруун хэсэг цацраг идэвхт бодисоор хорджээ. Нийт хордсон 60 мянган квадрат км газар нутаг дээр 2,6 сая хүн амьдарч байлаа. АЦС дэлбэрсэний дараа 4 сарын 27-ны өдрийн 14 цагт Украины Припять хотын бүх оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх ажил эхэлсэн байна. 3 цагийн дотор Припять хотоос 45 мянган хүнийг гаргажээ. 1986 оны сүүлээр Чернобылийн атомын цахилгаан станцын ойр орчмын 188 суурин газрын 116 мянган хүнийг



<sup>3</sup> <http://www1.voanews.com/learningenglish/home/world/Seeking-to-Secure-All-Nuclear-Materials-in-Four-Years-91116959.html>.

<sup>4</sup> Чернобылийн АЦС-ийн осол. <http://www.bolod.mn/modules.php?name=News&nID=14241>; [http://mendkhuu.blogspot.com/2009/07/blog-post\\_28.html](http://mendkhuu.blogspot.com/2009/07/blog-post_28.html)



нүүлгэсэн гэсэн албан ёсны баримт байдаг. Чернобылийн атомын цахилгаан станцын сүйрлийн дараа хохирол арилгах ажилд 600 мянган хүн оролцсон байна. Энэ бол өнөө үеийн терроризмын аюулын онцлог супер шинжтэй байхын нэг нотолгоо юм.

Нөгөө талдаа атомын цахилгаан станцын ашиглалтын хүрээ тэлж байна. Тухайлбал, АНУ - 103, Франц улс - 58, Япон - 55, ОХУ - 31, Өмнөд Солонгос - 20, Англи - 19, Канад - 18, Герман - 17, Энэтхэг - 16, Украин - 15, Хятад, Шведи - 10, Испани - 8, Бельги - 7, Чех - 6, Словак, Швейцарь - 5, Финлянд, Венгри - 4, Аргентин, Бразили, Болгар, Мексик, Пакистан Өмнөт Африк тус бүр - 2, Армени, Литва, Нидерланд, Румын, Словени тус бүр - 1 атомын цахилгаан станцтай байна. Франц улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 88 хувийг, Литва 68,6, Словени 56,1 хувийг тус тус цөмийн эрчим хүч эзэлж байна. Цөмийн эрчим хүчний эзлэх хувь нь Азийн орнуудын хувьд тухайлбал, Өмнөт Солонгост 44,7, Арменид 42,7, Японд 29,3, Энэтхэгт 5,5, Пакистанд 2,8, Хятадад 2 хувь байна. 2020 он гэхэд ОХУ цөмийн цахилгаан эрчим хүчний хүчин чадлаа 2 дахин, Хятад 5 дахин нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Энэтхэгийн хувьд 2022 он гэхэд 8 дахин нэмэгдүүлэх зорилттой ажиллаж байна.

Үй олноор устгах зэвсэг (ҮОУЗ)-ийг хэрэглэх хэмжээ, хөнөөх аюулын цар хүрээ нь хүн төрөлхтний түүхэн соёл иргэншлийг устгах түвшинд хүрснийг нийтээр хүлээн зөвшөөрч, түүнээс ангижрахын төлөө их

гүрнүүдээс эхлэн жижиг буурай улсууд ч хүчин чармайлт гарган зарим талдаа ахиц дэвшлийг олж байгаа ч түүний олноор устгах чанарыг ашиглан айлган сүрдүүлэх хэрэгсэл болгох, терроризмын үндсэн супер зэвсэг хэмээн үзэх үзэл бодлыг бий болголоо.

Дээрх хоёр хандлага нь ҮОУЗ-ийн даяар том аюулыг багасгахын хамт хэрэглээний түвшинг бууруулж, нийтлэг байдлаар дэлгэрэх занал болгон хувиргаж байна. ҮОУЗ нь их гүрнүүдийн хоорондын стратегийн тэнцвэрт байдлыг хадгалах, том дайныг хазаарлан тогтоох хэрэгсэл байснаа өнөө үеийн гол тэмцлийн хэлбэр болох терроризмын тактикийн түгээмэл хэрэгсэл болон хувирах хандлагад ороод байна. Энэ нь дараах хэд хэдэн хүчин зүйлтэй нягт холбоотой хэмээн үзэж байна.

**Нэгдүгээрт**, ҮОУЗ (цөм, хими, биологийн зэвсэг)-тэй, түүнийг стратеги, тактикийн объектод хүргэх зөөгч хэрэгсэлтэй улс орны тоо цөөрөх бус олширсоор, тэдний тоо одоо 30 гараад байна. Эдгээр улс оронд дараах дөрвөн бүлэг улсууд багтаж байна. Үүнд:

“А” бүлэгт - ҮОУЗ-тэй, түүнийгээ олон улсын хэмжээнд зарлан тунхагласан, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын таван гишүүн улс (АНУ, ОХУ, Хятад, Их Британи, Франц)-ууд буюу “цөмийн клуб”-ынхэн.

“В” бүлэгт - ҮОУЗ-тэй болчихсон, түүнийгээ олон улсын хэмжээнд зарлан тунхаглаагүй, ҮОУЗ-ийг хориглох олон улсын хэд хэдэн гэрээ, конвенцод нэгдэн ороогүй улсууд



(Израиль, Пакистан, Энэтхэг, Хойд Солонгос, ӨАБНУ) буюу ийм зэвсгийн тархалтын төлөөнөө хариуцлагаас зайлсхийх тайлбар, мөчөөрхөл гаргагч, олон улсын конвенцоор бол “албан бус зэвсэгтэй улсууд” багтаж байна.

“С” бүлгийнхэнд ҮОУЗ-ийг үйлдвэрлэн гаргахад шинжлэх ухаан технологи болон эдийн засгийн чадавх нь бэлэн, шаардлага тулгарвал тийм зэвсэгтэй болох “зааг дахь” улсууд (Япон, Өмнөд Солонгос, Тайван, Сингапур, ХБНГУ, Итали г.м.) багтаж байна.

“D” бүлгийнхэнд буюу ҮОУЗ-тэй болох далд бодлого, хөтөлбөртэй ч шинжлэх ухаан, технологийн хувьд тийм зэвсгийг эзэмших түвшинд хараахан хүрээгүй “зааг орчмын” улс (“Х” улс) - ууд орж байна. Ийм улс орнууд бодлого үйл ажиллагаагаа ихээхэн нууц байдалд явуулж буйгаас тэдгээрийг тогтоох, тэр тусмаа одоо энд нэрлэх боломж байхгүй байна. Гэсэн хэдий ч гадаадын олон судлаач, мэргэжилтнүүд тийм улс орныг гадаад бодлого, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог шинж тэмдэг бүхий үйлдэл, ажилбарынх нь байдлаар тогтоох боломжтой хэмээн үздэг.<sup>5</sup> Ийм нөхцөл байдал дэлхий дахинаа бодитоор буй болсон нь ҮОУЗ-ийн далд аюул нэлээд түгээмэл, нийтлэг шинж чанартай, дэлгэрэх хандлагатай болсныг харуулж байна.

**Хоёрдугаарт,** ҮОУЗ-ийг зохион бүтээх, үйлдвэрлэх, турших, хадгалах үйл ажиллагаанд тавих олон улсын хяналт, шалгалтын механизмын үр өгөөж хангалттай түвшинд хүрч

<sup>5</sup> Наталия Ивановна Калинина. Оружие массового уничтожения: мифы и реальность

чадаагүй байна. Олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцуудын тоо, хамрах хүрээ хангалтгүй, түүнд хамрагдахгүй үлдэх улс орнууд олон байна. Үй олноор устгах зэвсгийг хориглохтой холбоотой мөрдөж буй конвенцуудын биелэлтэд хяналт тавих механизм дутмаг, үр өгөөж нь сул байна. Наад зах нь цөмийн зэвсгийн үндсэн бүтээгдэхүүний олзворлолт, боловсруулалт, импорт, экспорт, тээвэрлэлтэд тавих олон улсын үр өгөөжтэй механизм байхгүй байгаа нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, зохион бүтээх, үйлдвэрлэх, хадгалах, нөөцлөхийг хориглох тухай конвенцыг биелүүлэх, дагаж мөрдөх ажлыг хүндрүүлж байгаа г.м.

**Гуравдугаарт,** ҮОУЗ-ийг зохион бүтээх технологийг энгийнжүүлэх, загвар, хийцийг “багасгах” ажиллагаа эрчимтэй явагдаж байна. Цөмийн зэвсэг гар цүнхэнд, химийн зэвсэг хуруу шилэнд, биологийн зэвсэг захидлын дугтуйд багтах болтол нь хэмжээ, загварыг нь жижигрүүлж байна. ҮОУЗ-ийг үйлдвэрлэн гаргах ажиллагаа лабораторийн түвшинд шилжиж байгаа нь түүнийг зохион бүтээх технологи асар энгийн болсон болохыг харуулж байна.

**Дөрөвдүгээрт,** дээр дурдсан нөхцөл байдал нь террористуудад ҮОУЗ-ийг эзэмших найдварыг төрүүлж, тийм зэвсгийг эзэмшихийн төлөө улайран зүтгэх боломжийг олгож байна. Террористуудын зарим (Аум Синрикё) нь химийн зэвсгийг Токиогийн метронд туршаад үзсэн.<sup>6</sup> Осама Бин Ладен ҮОУЗ-

<sup>6</sup> Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсын терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс.т.89

ийг тэд эзэмших нь “бурханы захиа даалгаврыг хэрэгжүүлж буй хэрэг, шашны өмнө хүлээсэн үүрэг”<sup>7</sup> хэмээн үзэж байна.

**Тавдугаарт,** террористууд ҮОУЗ-ийг эзэмшихэд санхүү, эдийн засгийн бүхэл бүтэн тогтолцоо үйлчлэх бололцоо байна.<sup>8</sup> Олон улсын хэмжээнд мөнгө, санхүүгийн чөлөөт урсгал бий болсон явдлыг тэд ашиглаж, шаардлагатай газарт, хэрэгцээтэй цаг мөчид, зохих хэмжээний хөрөнгө мөнгийг төвлөрүүлэх боломжтой байна. Энэ байдлыг хаан боох механизмыг бүрдүүлэхэд хүндрэл тохиолдож байна. “Бүх нийтээр” мөнгө, санхүүгийн даяар урсгалыг хаах боломжгүй бөгөөд ялангуяа ядуу, буурай хөгжилтэй улс орнуудын ард түмэнд олон улсын зүгээс үзүүлэх тусламж нь нэн тулгам шинж чанартай, шуурхай байх шаардлагатай юм. Террористууд ядуу, буурай хөгжилтэй улсуудад олон улсын зүгээс үзүүлж байгаа мөнгө, санхүүгийн тусламжийг өөрсдийн үйл ажиллагааг далдлах хэрэгсэл болгох боломж байна.

**Зургадугаарт,** ҮОУЗ-ийг тэмцлийн хэрэгсэл болгон ашиглах арга ажиллагаа, тактикийг иргэний нөхцөлд нийцүүлэх гэсэн оролдлого ихсэж байна. Өөрөөр хэлбэл, терроризмын гар хөл бологч туйлширсан үзэлтэн, шашны тулгуур үзэлд гүн итгэгч, салан тусгаарлах боломж нь хаагдмал үндэстэн, ястны зарим нэг төлөөлөл, улс төр, эдийн

засгийн эрх мэдлийн төлөө улайран зүтгэгч нар ҮОУЗ-ийг оновчтой, үр “өгөөж” өндөртэй хэрэглэх арга ухааныг хайн сүвэгчилж байна.

**Долдугаарт,** цөм, химийн зэвсгийн үйлдвэрлэл, тархалтад хяналт тавих үр өгөөж багатай ч олон улсын механизм үйлчилж байхад<sup>9</sup> биологийн зэвсгийн хувьд тийм механизм огт байхгүй байгаа нь энэхүү зэвсгийн далд аюулыг өргөжүүлж байна. Орчин үеийн биологийн шинжлэх ухааны ололт амжилт улам нарийсан гүнзгийрч, түүн дэх олон нууцыг нээн танин мэдэх боллоо. ХХI зууны шинжлэх ухааны анхны том нээлт энэ салбарт гарлаа. Энэ хэмжээгээр биологийн зэвсгийн шинэ аюул бүхий нууцыг нээн илрүүлж байгаа нь тодорхой.

ҮОУЗ-ийн далд аюул нэлээд түгээмэл, нийтлэг шинж чанартай, дэлгэрэх хандлагатай болсныг харуулж буйн дээр дурдсан бодит нөхцөл байдал нь хүн төрөлхтөн, дэлхийн бүх улс орон хамтын хүчин чармайлт гаргах зайлшгүй шаардлага бий болсоныг харуулж байна. ҮОУЗ-ийн занал тактикийн түвшинд ихэсч буйг багасгах, зогсоох арга хэмжээг дэлхийн хэмжээнд хэрэгжүүлэх шаардлага, хэрэгцээ бий болжээ.

Үүний тулд нэгд, ҮОУЗ-ийн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаагаа улс, үндэстэн бүр эргэн харж, явал энэхүү зэвсгийн аюул, заналын түвшинг бууруулах, багасгах, арилгах вэ? гэдэгт хариулт өгөх өөрт болон бусад улс орны хувьд байж болох гарцыг олох шаардлагатай

<sup>7</sup> Ц.Дашзэвэг. Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. т.36

<sup>8</sup> Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсын терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс. т.31

<sup>9</sup> Ц.Дашзэвэг. Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. т.36

байна. Энэ талаар санал бодлоо солилцож, гарц олох шаардлага бий болов.

**Хоёрт**, аль ч улсын ашиг сонирхол дэлхийн нийтийн нийтлэг сонирхол, эрх ашигт нийцсэн тохиолдолд ҮОУЗ-ийн талаар баримтлах бодлого, явуулах үйл ажиллагаа мөнхүү нийтлэг сонирхол, эрх ашигт чиглэх болно. Иймд аль ч улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилгод дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс олон улсын эрх зүйн баталгаа гаргаж өгвөл ҮОУЗ-ийн талаар баримтлах бодлого, явуулах үйл ажиллагаанд өөрчлөлт оруулж болох юм. Үүнд цэрэг, техникийн хувьд хүчирхэг, эдийн засгийн өндөр хөгжилтэй улс, их гүрнүүдийн гүйцэтгэх үүрэг маш чухал болоод байна.

**Гуравт**, “цөмийн клуб”-ынхан өөрт буй цөмийн химийн зэвсгийн нөөцийг багасгах, устгах гэрээ хэлэлцээрийг байгуулж, түүнийг хэрэгжүүлж эхлэх юм бол дэлхий дахинаа ҮОУЗ-ийн аюулын түвшин улам багасгаж, итгэл найдварыг төрүүлэх бөгөөд өмнө дурдсан “В”, “С”, “D” бүлгийн улсуудын хувьд ҮОУЗ-ийн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах үндсийг тавих болно. АНУ, ОХУ-ын цаашдын шинэ гэрээ хэлэлцээрүүд үүнд ахиц, дэвшил авч ирнэ гэж дэлхийн хамтын нийгэмлэг найдаж байна. Харин Их Британи, Франц, Хятад улсын зүгээс энэ чиглэлд алхам хийхгүй байгаа нь эргэлзээ төрүүлж болох юм. Урьд өмнөх шигээ АНУ, ОХУ хоёрыг өөрсдийн цөмийн зэвсгийнхээ 50 хувийг, эсвэл гуравны хоёрыг устгасан тохиолдолд “цөмийн

клуб”-ын бусад гурван улсын хувьд “ногоон гэрэл” асаж болох юм гэсэн хандлагаа давтан гаргах нь хэтэрхий “хувиа хичээсэн” үйлдэл болно.

**Дөрөвт**, ҮОУЗ-д тавих олон улсын механизмаас гадна үндэсний хэмжээнд төрийн бус байгууллагуудаас түүнд тавих хяналтын механзмыг бүрдүүлэх арга замыг олох хэрэгтэй байна. ҮОУЗ-ийн тархалтад тавих хяналтыг үр өгөөжтэй болгоход дараах арга хэмжээнүүд нэн чухал байж болох юм. Үүнд:

- ҮОУЗ-ийн үндсэн материал, бүрэлдэхүүн хэсгийг үйлдвэрлэдэг объектын хамгаалалтыг сайжруулж, хулгайлагдах боломжийг бүрэн хаах;
- Цөм, химийн зэвсгийн үндсэн түүхий эдийн олзворлолт, боловсруулалт, тээвэрлэлт, импорт, экспортод тавих олон улсын болон дотоодын хяналтын механизмыг бий болгох;
- Батлан хамгаалах, цэргийн аж үйлдвэрийн цогцолборт, ялангуяа цөм, хими, биологийн салбарт ажиллаж буй эрдэмтдийн хариуцлага, ёс суртахууныг дээшлүүлж, дан ганц эх орноо хамгаалахад бус дэлхий нийтийн эрх ашгийг хамгаалахад, зэвсэг хийхэд бус зэвгээс хамгаалах чиглэлд судалгаа, шинжилгээний ажлаа явуулах ухамсарт хөтлөх;
- Аль ч улс орон өөрийн эрдэмтэн судлаачдаа эх орондоо ажиллах нөхцөл бололцоогоор хангаж,

- “тархи урсах” боломжийг хаах;
- Дэлхийд болон аль ч улс оронд ҮОУЗ-ийн талаар нарийн мэргэшсэн эрдэмтэн, судлаач нарын дагаж мөрдөх ёс суртахууны болон хууль зүйн хэм хэмжээг боловсруулан гаргах;
  - ҮОУЗ-ийн чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил эрхэлдэг эрдэмтэн судлаачдын хувьд “тархи урсах” боломжийг хаахад чиглэсэн нийгмийн хамгаалал, ахуйн хангалтад аль улсын төр, засаг онцгойлон анхаарах;
  - Улс бүр өөрийн дотоод дахь хяналтын механизмын үр өгөөжийг дээшлүүлэх үүднээс иргэний сайн дурын байгууллагууд, төрийн бус олон нийтийн санаачилгын байгууллагууд ҮОУЗ-ийн талаарх Олон улсын конвенцын биелэлтэд тавих хяналтад оролцох боломжийг нээж, тэдэнд санхүү, эдийн засгийн урамшуулал олгож байх.

**Тавд,** даяар аюул, заналаас даяар хамгаалалт, даяар хамтын хяналтын механизм бүрдүүлж байж түүнийг хазаарлан тогтоохоос биш, олон улсын хяналтын институтүүдийн дагнасан хүч хэрэгслээр хэрэгжүүлэх үндэслэл бага юм. Иймээс НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн ҮОУЗ-ийг үл дэлгэрүүлэхэд тавих хяналтын механизмыг сайжруулахын тулд Олон улсын хэмжээний иргэний, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах арга замыг олох хэрэгтэй

юм. Энэ нь ардчилсан нийгмийн иргэний хяналтын үр өгөөжтэй нэг хэлбэр байж болох юм.

**Зургаад,** ҮОУЗ-ийн талаар “дуулгаваргүй улс”-д үзүүлэх олон улсын дарамт, шахалтын өнөөгийн механизм хязгаарлагдмал, үр өгөөж багатай байгаа учир үр ашиг өндөртэй өөр механизмыг нээн олох хэрэгцээ шаардлага байна. Дан эдийн засгийн хүрээн дэх хязгаарлалт явцгүй болох нь харагдаж байна.

**Долоод,** Аюултай хүч агуулсан төхөөрөмж, байгууламжуудын хамгаалалт, найдвартай ажиллагааг дээшлүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний далайц хэмжээг өргөжүүлэх шаардлага улам өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, ҮОУЗ-ийн үр дагаврыг нэмэгдүүлэх аюултай атомын цахилгаан станц, атомын хөдөлгүүрт хөлөг онгоц аваарт орох, ус сангийн далангийн хаалт сэтрэх зэрэг нь олон хүний амь насыг эрсдэлд оруулах, байгаль орчинг бохирдуулах, эдийн засагт ихээхэн хохирол учруулах зэргээр дам аюулыг агуулдаг учир тэдгээрийн хамгаалалт, найдвартай ажиллагааг сайжруулах нь чухал юм. Чернобиллийн атомын цахилгаан станцын сүйрэл дээрх аюулын цар хүрээ ямар их болохыг илтгэн харуулдаг.

**Наймд,** Олон улсын конвенц, гэрээ хэлэлцээрээр хориглоогүй хуучин ҮОУЗ-ийн шинэ салбар, цоо шинэ төрлийн ҮОУЗ-ийг зохион бүтээх далд аюул оршсоор байна. Хэрэв ийм зэвсэг шинээр гарч ирэх юм бол ҮОУЗ-ийн тактикийн төвшингийн занал төдийгүй даяар аюул ч өсөн нэмэгдэх болно. Тиймээс

ийм зэвсгийн талаар улс орны хүлээх олон улсын хариуцлагыг дээшлүүлэх механизмыг олох хэрэгтэй болж байна. Өнөө үед физикийн шинэ зарчимд үндэслэсэн зэвсгийн тухай бичих, ярих нь олонтаа болсон. Ийм зэвсгийн хөнөөлийн шинж чанар, түүнээс хамгаалах арга хэмжээний талаар өргөн түмэн ямар ч ойлголтгүй байна.

Энд өгүүлэн байгаа ҮОУЗ-ийн аюул, заналын түвшингийн хувьсал, өөрчлөлт, түүнээс сэргийлэх, хамгаалах, авах арга хэмжээний цар хүрээний өргөжилт нь хүн төрөлхтний сэтгэл санааг улам бүр зовоосон асуудал болж байна. Нэн ялангуяа, олон улсын терроризм мэт урьдчилан тааварлах, үнэлэх боломжгүй халдлага, түрэмгийлэлд ҮОУЗ-ийг ашиглаж болзошгүй байдал үүсээд байгаа нь заналын түвшинг улам бүр нэмэгдүүлж байна. Супертерроризм гэсэн нэр томъёо нь чухамдаа үүнтэй холбоотой юм.

Эшлэл авсан сурвалж,  
судалгааны бүтээлийн жагсаалт

1. Уэсли Кларк. Как победить в современной войне. т.137Москва., 2004.-238с;
2. Наталия Ивановна Калинина. Оружие массового уничтожения: мифы и реальность.
3. Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсын терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс. УБ., 2006. – 232х;
4. <http://www1.voanews.com/learningenglish/home/world/Seeking-to-Secure-All-Nuclear-Materials-in-Four-Years-91116959.html>;
5. Чернобылийн АЦС-ийн осол.
6. Ц.Дашзэвэг. Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудал. УБ., - 164х;

## МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

---

*доктор, профессор Д.Тунгалаг*

### **1. Уул уурхайн салбар эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх нь**

Орчин үед олон улсын тогтолцоонд хүчний шинэ төвүүд бүрэлдэж, бүс нутгийн эвсэл холбоодын үйл ажиллагаа идэвхжиж, байгалийн баялаг, түүхий эдийн нөөц хомсдож, түүний төлөөх тэмцэл хурцдаж байна. Өндөр хөгжилтэй улс орнуудын байгалийн баялаг, ашигт малтмалын импортын хэрэгцээ өсөн нэмэгдэж, хөгжиж байгаа ба буурай хөгжилтэй орны уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх, байгалийн баялгийг олборлох, ашиглах бодлогыг хэрэгжүүлж байна.

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад уул уурхайн салбарыг түлхүү хөгжүүлснээр эдийн засгийн уналт, ядуурал, экологийн сүйрэлд хүрсэн жишээ олон байхад нөгөө талд нь эдийн засгийн өндөр өсөлтөд хүрч, ард түмний амьжиргааны өндөр түвшинд хүрсэн улс орнууд нилээд байна. Уул уурхайн салбарыг хөгжүүлж байгаа улс “Голланд өвчин”, “Байгалийн баялгийн хараал” гэж нэрлэгддэг эдийн засгийн үзэгдэлтэй тулгарч байдаг байна. “Голланд өвчин” гэдэг нь байгалийн баялгийг их

хэмжээгээр олборлож, ашигласнаар уул уурхайгаас бусад эдийн засгийн салбар хөгжихгүй, зогсонги байдалд орохыг хэлнэ. Энэ нэр томъёо 1960-аад оны эхээр Нидерландын 12 мужийн нэг Голландын Хойд тэнгист байгалийн хийн баялаг орд олсны дараа гарч ирсэн. Голланд өвчнөөр өвчилсөн улс оронд эхлээд газрын тос, алт, байгалийн хий, алмааз болон бусад байгалийн баялгаас олсон асар их валютын дүнд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш нь өснө. Хүчтэй валюттай болсноор иргэд бэлэн мөнгөөрөө импортын илүү чанартай, хямд барааг ихээр худалдан авах хандлагатай болсноор дотоодын үйлдвэрлэл зах зээлээс шахагдан гарч, уул уурхайгаас бусад салбарын үйл ажиллагаа уналтад орох болно. Ашиг орлого их өгч буй уул уурхайн салбарт эдийн засгийн нөөц хуваарилагдснаар бусад салбар ДНБ-ээс шахагдаж, зөвхөн уул уурхайн орон болж хувирна. Ийм орны газрын баялаг, ашигт малтмалын орд газруудын нөөц дуусахад эдийн засгийн хөгжлийн цаашдын ирээдүй туйлын бүрхэг болсон байна.

“Байгалийн баялгийн хараал” бол үүнтэй төстэй эдийн засгийн үзэгдэл юм. Сүүлийн 30 гаруй жилд



ямар ч байгалийн баялаггүй улсууд, жишээ нь, Азийн бар гэгдэх Сингапур, Өмнөд Солонгос, Тайван, Хонг Конг үсрэнгүй хөгжиж байхад арвин их нөөц баялагтай Африк, Латин Америк, Ойрх Дорнодын орнууд эдийн засгийн өсөлтөд хүрч чадалгүй нийгэм, эдийн засгийн амьдрал доройтож, байгаль орчин маш их сүйдэж, экологийн хурцадмал асуудал үүссэн байна. Энэхүү үзэгдлийг “байгалийн баялгийн хараал” хэмээн нэрлэдэг. “Байгалийн баялгийн хараал” онолын дагуу өнөөгийн даяаршсан эринд аливаа улсын эдийн засаг хэдий хэмжээгээр түүхий эд, тэр тусмаа уул уурхай, ашигт малтмал олборлох салбараас хамааралтай байна, төдий хэмжээгээр эдийн засгийн хэтийн төлөв нь бүрхэг, экологийн сүйрэлд хүрнэ гэж үздэг байна. Үүнийг Науру улсын жишээгээр авч үзье. Номхон далайн урд хэсэгт, Австрали, Хавайн арлуудын дунд орших Науру улс нь газар тариалангийн хамгийн сайн бордоо болдог фосфатын нөөцөө 1960-1970-аад онд экспортлон асар их валютын орлого олж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж байсан байна. Фосфатын орлогоо үр ашигтай хэрэглэж чадаагүй, эдийн засгийн өөр салбарыг хөгжүүлж чадаагүй, хэт тансаг зүйлд орлогоо үрсэн, үр хүүхэддээ дээд боловсрол эзэмшүүлэх асуудлыг орхисон зэргээс шалтгаалан фосфатын нөөц дуусахад эдийн засаг, нийгмийн амьдрал нь бүхэлдээ доройтжээ. Төр засаг ажиллагсдынхаа цалинг тавьж чадахгүй, сургууль, эмнэлэг үүдээ барьж, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээг нийлүүлэх боломжгүй

болсноо Засгийн газар нь зарласан байна. Байгалийн баялгаа олборлох явцад газар нутгаа нөхөн сэргээхгүй, том нүх үлдээгээд хаясан тул байгаль экологийн доройтолд орж, газар тариалан ч эрхлэх боломжгүй болсон байна.<sup>1</sup> Энэ нь байгалийн баялгийн хараал үзэгдлийн жишээ байж болно.

Гэхдээ “байгалийн баялгийн хараал” үзэгдлийг бүх нийтээр хүлээн зөвшөөрдөггүй. Эсрэг төлөөлөгчдийн гол үзэл санаа нь «Эдийн засгийн бодлого муутай улсуудад олборлох салбараас өөр салбарууд оршин тогтнох нөхцөл бүрддэггүй. Эдийн засгийн уналт, хямралт байдлын шалтгаан нь байгалийн баялаг бус, харин эдийн засгийн үр дүнгүй, харалган бодлого, цаашилбал төрийн институцүүдийн чадавхгүй байдалтай холбоотой. Харин эдийн засгийн үр дүнтэй бодлого хэрэгжүүлж буй улсын эдийн засаг төрөлжин хөгжих боломжтой гэж үздэг байна.

Тухайлбал, Чили улсын жишээг авч үзвэл, өнгөрсөн 50 жилд эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь зэс байсан. Тус улсын экспортын гол бүтээгдэхүүн нь хагас болон бүрэн боловсруулсан зэс, зэсэн бүтээгдэхүүн байсан ба 1960-аад онд 600 мянган тонн зэс экспортолж байв. Үүний 80 хувийг АНУ-ын хоёр томоохон компани болох Анаконда (Anaconda), Кэннэкотт (Kennecott), үлдсэн 20 хувийг үндэсний жижиг болон дунд үйлдвэрүүд бүрдүүлж байжээ. Чили улс аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, гадаадын хөрөнгө оруулалтыг бусад улсаас оруулах, боловсруулах

<sup>1</sup> Jargaldefacto.com, Д.Жаргалсайхан, Науругийн түүх, 2014 он 10 дугаар сар

үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримталсан байна. Үйлдвэржүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогуудын үр дүнд Чили улсын эдийн засаг нь уул уурхайн салбараас бага хамаардаг болж, эдийн засгийн төрөлжилтийг бий болгож, өсөлт, хөгжилд хүрч чадсан байна.

## 2. Эдийн засгийн аюулгүй байдалд уул уурхайн салбарын үзцлэх нөлөөлөл

Монгол Улс байгалийн нөөц баялаг арвин, хоёр хөрш орон төдийгүй дэлхийн бусад орныг шаардлагатай түүхий эдээр хангах боломжтой, газар зүйн байршлын хувьд ОХУ, БНХАУ гэсэн хоёр том зах зээлийн дунд оршиж, түүгээр дамжин гадаад зах зээлд хүрэх давуу талтай юм. Энэ нь Монгол Улсад дэлхийн томоохон улс орнууд болон үндэстэн дамнасан корпорацуудын ашиг сонирхолыг бий болгож байна.


Уул уурхайн салбарт олгосон ашиглалтын тусгай зөвшөөрлийн бүтцийг 2019 оны 05 сарын байдлаар авч үзвэл, нүүрс 51.5 хувь, алт 14.2 хувь, зэс 5.3 хувь, зэс, алт 5.1 хувь, уран 4.6 хувь, бусад төрлийн ашигт малтмал 19.3 хувийг тус тус эзэлж байна. Гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүтцийг улсаар нь авч үзвэл, БНХАУ 24.18 хувь, Виржиний Арлууд 11.81 хувь, Сингапур 22.78 хувь, Хонг-Конг 8.72

хувь, Канад 16.17 хувь, бусад улсууд 16.34 хувийг тус тус эзэлж байна.<sup>2</sup>

Монгол Улсын хувьд уул уурхайн салбар стратегийн ач холбогдолтой салбарын нэг болох ба эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах учиртай салбар юм.

2018 оны эцсийн байдлаар ДНБ-ний 24.6 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна. 2019 оны 06 дугаар сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын 69.1 хувийг уул уурхай, олборлох үйлдвэр эзэлж байна.<sup>3</sup> Эндээс үзвэл, манай улсын уул уурхайн салбар ДНБ-ний 20 орчим хувь, аж үйлдвэрийн салбарын 70 орчим хувь, нийт экспортын 90 орчим хувийг бүрдүүлж, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам бүр өсөн нэмэгдэж байна. Түүнчлэн төсвийн нийт орлогын 20-30 орчим хувийг зэс, нүүрс, алт зэрэг ашигт малтмал бүрдүүлж байгаагаас дэлхийн зах зээлийн үнэ ханшаас хамаарсан ихээхэн эрсдэлтэй төсөвтэй болоод байна. Улсын төсөвт уул уурхайн салбараас орох орлогыг өсгөх, түүнийг

ДНБ, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд уул уурхайн салбарын эзлэх хувийн жин (Эрдэс баялгийн статистик мэдээ, 2019 оны 06 дугаар сар, 7, 8 дахь тал)



<sup>2</sup> Эрдэс баялгийн статистик мэдээ, 2019 оны 06 дугаар сар, т. 7, 8

<sup>3</sup> www.1212.mn, ДНБ, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, 2019 оны 05 дугаар сар

оновчтой, үр ашигтай хуваарилах, улмаар үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, оюуны болон санхүү, материал техникийн бааз суурийг өргөтгөхөд анхаарал хандуулж ажиллах шаардлагатай.

Манай улсын уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах хүнд үйлдвэрүүдийн техник, технологийн түвшин доогуур, хүчин чадал багатай байгаагаас олборлосон ашигт малтмалыг экспортод шууд гаргаж байна. Экспортын бүтцэд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй газрын тос зэрэг байгалийн баялаг ашигт малтмал 90 орчим хувийг эзэлж байна. Экспортод гаргаж буй эрдэс бүтээгдэхүүнийн 90 орчим хувийг БНХАУ-д гаргаж байна. БНХАУ дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэс, алтны томоохон импортлогчийн хувьд тухайн улсын эдийн засгийн өсөлтийн хандлага, түүхий эдийн эрэлт, хэрэгцээ нь зах зээлийн үнэ ханшийг тогтооход нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Иймд Хятадын улс төр, эдийн засгийн бодлого, эдийн засгийн нөхцөл байдал нь манай улсын экспортын орлого, төсвийн орлого бүрдэлт, татварын орлого, улмаар эдийн засгийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болоод байна. Иймд дэвшилтэт техник, технологийг боловсруулах үйлдвэрлэлд нэвт-рүүлэх замаар байгалийн баялаг, түүхий эдийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн цогцолборыг барьж байгуулах, дэд бүтцийг хөгжүүлэх, олон улсын зам тээврийн сүлжээнд холбогдох, гадаад харилцаа

холбоогоо өргөжүүлэн хөгжүүлж, олон тулгуурт бодлого хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлт хөгжлийг хангах шаардлагатай байна.

### *3. Стратегийн ач холбогдолтой орд газрын ашиглалт, анхаарах асуудал*

Стратегийн ач холбогдолтой орд газраас Нарийн сухайтын нүүрсний орд, Төмөртэйн төмрийн хүдрийн орд, Цагаан суваргын зэс молебдиний орд, Бүрэн хааны фосфоритын орд, Бороогийн алтын ордыг гадаад, дотоодын хувийн компаниуд эзэмшиж байна. Мөн Бороогийн алтны орд газар, Төмөртэйн овооны цайр, хар тугалагын орд газар, Оюу толгой зэс, алтны орд газрыг ашиглуулах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газар гадаадын компанитай байгуулсан байна.

#### *Оюу толгой орд газрын ашиглалт*


Оюу толгой орд газар нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрладаг. Улаанбаатар хотоос 550 км, Монгол-Хятадын хилээс 80 км-ийн зайд оршдог. Оюу толгой ордыг 3.38 тэрбум тонн хүдэр, 37.1 сая тонн зэс, 1328 тонн алт, 7601 тонн мөнгөний нөөцтэй гэж тогтоосон. Энэхүү том төслийн ашиглалтын хугацааг анх 50 жил гэж тооцоолсон байдаг.

“Оюутолгой” ХХК бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлбэл Монгол Улсад үйлдвэрлэж байгаа зэсийн баяжмалын 80 хувь, нийт экспортыг 30-40 хувь, улсын төсөвт орох уул уурхайн салбарын орлогын 50 гаруй хувийг бүрдүүлж, ДНБ-нд эзлэх уул

уурхайн бүтээгдэхүүнийг 20 хувиар тус тус нэмэгдүүлж, манай улс зэс олборлогч 50 гаруй орноос эхний 15 дугаар байрт жагсах боломжтой болно гэж үздэг.

“Оюу толгой” компани 2010-2018 онд татвар, хураамж болон бусад төлбөрт 2.3 тэрбум ам.доллар төлсөн. Үүнээс 322 сая ам.долларыг нь 2018 онд төлж, улсын төсөвт төвлөрүүлээд байна.<sup>4</sup> Оюу толгой ХХК-ний хувь эзэмшийн бүтцийг дараах зургаас харж болно.

“Оюу толгой” ХХК-ийн эзэмшлийн бүтэц



“Оюу Толгой” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын өмчийн оролцоотой ба хувь нийлүүлэгчдийг доорх компаниуд төлөөлөн ажилладаг. Үүнд:

- “Эрдэнэс Оюу Толгой” ХХК (34 хувь)
- “Туркойз Хилл Ресурс / Рио Тинто” (66 хувь)

<sup>4</sup> Оюу толгойн 2018 оны IV-р улирлын тайлан

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг дараах 3 үе шаттай байгуулсан гэж үздэг. Үүнд:

1. 2010 оны 10 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу Майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу Майнз Лтд (одоогийн Туркуаз Хилл Ресурс) Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг хамтран байгуулсан. Энэхүү гэрээ 30 жилийн хугацаанд хүчинтэй.

2. 2011 онд “Айвенхоу Майнз” Лтд -ийн хувьцааг Туркуаз Хилл Ресурс худалдаж авсан тул гэрээнд тодотгол оруулж, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, “Туркойз Хилл Ресурс / Рио Тинто”

компанитай Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”-г байгуулсан байна.

3. 2015 оны 5 сард Монгол Улсын Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд Оюу толгойн төслийн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнд Дубай

хотноо гарын үсэг зурсан.

“Оюу Толгой” компани нь Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Татварын ерөнхий хуульд заасан татваруудыг төлөх үүрэгтэй бөгөөд үүнээс зөвхөн 7 төрлийн татварын хувь хэмжээг Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаанд тогтворжуулсан

байна. Үүнд:

1. ААНОАТ;
2. Гаалийн албан татвар;
3. НӨАТ;
4. ОАТ;
5. Ашигт малтмалын нөөц

ашигласны төлбөр;

6. Ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрлийн төлбөр;

7. үл хөдлөх хөрөнгийн албан татвар.

Харин бусад төрлийн татвар, төлбөрийг, тухайлбал, газар, ус ашигласны төлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр төлнө. Харин “Оюу Толгой” компани нь давхар татварын гэрээгээр бусад аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийн нэгэн адил тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээдэг байна.

“Оюу Толгойн” Хөрөнгө оруулалтын гэрээгээр талуудын эрх үүрэг болон төслийн нийт үргэлжлэх хугацааг тогтоосон байдаг. Энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээ нь татвар, роялти, төлбөрийн орлого, хувьцаа эзэмшил, байгаль орчны стандартууд, ажил эрхлэлт болон нийгмийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг Монгол Улсын Засгийн газарт баталгаажуулж өгсөн. Харин Хөрөнгө оруулагч талын хувьд энэхүү гэрээ нь уурхай байгуулахад зориулан олон тэрбум долларын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хийхэд шаардагдах тогтвортой, таамаглахуйц эрх зүйн орчныг баталгаажуулж, улмаар 2020 оныг хүртэл томоохон хэмжээний өргөтгөл хийх хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг хангана гэж үзжээ.

“Оюу толгой” төслийг эхлүүлэх

анхны хөрөнгө оруулалтыг 15 тэрбум ам доллараар тооцсон. Монгол Улсын Засгийн газрын гаргах зардлыг уурхайн үйл ажиллагааны ноогдол ашгаас нөхөн төлөхөөр тооцсон байна. Оюу Толгойн орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг 2009 оны 7 дугаар сард Эрдэс баялгийн зөвлөлд хүлээлгэн өгч, 2010 оны 3 дугаар сард Эрдэс баялаг, эрчим хүчний ямаар батлуулсан билээ. Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хөрөнгө оруулагч тал Оюу толгой орд газарт ил уурхай болон баяжуулах үйлдвэр 2009-2010 оноос барьж байгуулан, далд уурхай нь 2014 оноос ажиллаж эхэлсэн. 2015 он хүртэл хугацаанд 500 мянган тонноос доошгүй баяжмал боловсруулах хүчин чадалтай зэсийн заводыг барьж байгуулна гэж төлөвлөжээ.

ТЭЗҮ-д уурхайн ашиглалтын хугацаанд нийт 15 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг зарцуулахаар тусгасан бөгөөд үүнээс 5.1 тэрбум ам.доллар нь анхны хөрөнгө оруулалт буюу баяжуулах үйлдвэрийн ажиллагааг эхлүүлэхээс өмнө ил уурхайг байгуулах, хоногт 100000 тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр барих, цахилгаан станц (450 мвт-ын хүчин чадалтай), гүний уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх, бусад дагалдах дэд бүтэц зэрэгт зарцуулахаар тогтоосон байдаг.

Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийн байдлаас үзвэл анхаарах шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээнд анхны хөрөнгө

оруулалт 5.1 тэрбум ам.доллар хэмээн заасан байтал Оюутолгойн хөрөнгө оруулагчид энэ хөрөнгийг 7.1 тэрбум ам.доллар болгон 40 орчим хувиар өсгөсөн. Түүнчлэн өндөр хүүтэй зээл, зээлийн хүүгийн асуудлыг энд авч үзэх хэрэгтэй. Төсөлд оруулж буй хөрөнгө оруулалтын нийт зардал өсөхөөр манай талд ирэх өгөөж, ногдол ашиг буурна.

2. Ил уурхайн үе шатыг дотор нь хоёр хувааж үздэг. Төсөл эхэлсэн үе буюу 2009-2010 оны тайланг Засгийн газар авч үзээд зөрчил илрүүлж, засах шаардлага тавьсан байдаг. Тэр үед Оюу толгой нэг тэрбум 55 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн гэж тайлагнасныг Засгийн газар хянаад 300 гаруй сая ам.долларыг баталгаажуулах бололцоогүй гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл 300 сая ам.долларын зөрчил илэрсэн гэсэн үг. 2010-2012 оны тайланг Засгийн газар баталгаажуулах ёстой байсан. Тиймээс гурван сайдын хамтарсан тушаалаар Оюу толгойд баримтын шалгалт хийж, нэг тэрбум 880 сая ам.долларын санхүүгийн зөрчил илрүүлсэн. Үүнээс гадна анх баталсан ТЭЗҮ-ийг 1.4 тэрбум ам. доллараар хэтрүүлснийг тогтоож, үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдэг дүгнэлт шалгалтаар гарсан байдаг. Түүнчлэн 2018 онд “Оюу толгой” ХХК 150 сая ам долларын татварын зөрчилтэй байгаа талаар УТЕГ-аас “Туркойз Хилл Ресурс” компанид мэдэгдэл хүргэж байв.

3. Төслийн менежментийн институт гэдэг олон улсын байгууллага бий. Тэд “Оюу толгой” төслийг хэрэгжүүлж байгаа менежерүүдийн

цалингийн судалгааг хийхэд 2011 оны байдлаар нэг менежер 92 мянган ам.долларын цалин хөлс авчээ. Энэ нь 29 оронд хэрэгжсэн 30 мянган төсөлд хийсэн судалгаагаар тогтоогдсон менежерүүдийн дундаж цалинтай харьцуулахад гурав дахин өндөр байна гэдгийг гаргажээ. Оюу толгой дэлхийд байхгүй жишгээр менежерүүдээ цалинжуулж байж.<sup>5</sup> Дээрх маргаантай нөхцөл байдлаас шалтгаалан “Оюу толгой” хөрөнгө оруулалтын гэрээний хоёрдахь шат буюу далд уурхайн санжүүжилт зогссон байсан.

4. 2015 оны 5 сард талууд Оюу толгойн төслийн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнд Дубай хотноо гарын үсэг зурсан. Олон улсын банкууд 4.2 тэрбум ам.долларын төслийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн байна. Гэхдээ Дубайн гэрээгээр далд уурхайн бүтээн байгуулалтад 4.2 тэрбум ам.долларын санхүүжилт авах болсноор цэвэр ашиг хүртэх хугацаа 2023 он байх байсан бол 2037 он хүртэл хойшилжээ.<sup>6</sup>

5. Ил уурхайг бүтээн байгуулах үед орон нутгийн хөгжил, байгаль орчны нөлөөллийг шаардлагын түвшинд хангаагүйтэй холбоотой асуудлууд гарсан байна. Тухайлбал, ундны усны хүртээмж, чанар, бэлчээрийн хүртээмж, Ундай голын гольдролын өөрчлөлт, уурхайн дэд бүтцийн байгуулалтаар хохирсон талуудад нөхөн олговор олгох, эмнэлгүүдийн нэмэгдэх ачаалал,

<sup>5</sup> 2015 оны 6 сарын 9-ний өдрийн дугаар, УИХ-ын гишүүн Ч.Улаантай хийсэн ярилцлага  
<sup>6</sup> Д.Тунгалаг, Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал, 2019 он Улаанбаатар, 245 дах тал



нутгийнхны нүүлгэн шилжүүлэлт зэрэг олон олон асуудлууд шийдлээ олоогүй байна.

Иймд дээр дурдсан алдагдалтай үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлсэн тооцоо судалгаа, Монгол Улсын язгуур эрх ашигт үл нийцэх бусад олон асуудлуудыг манай тал нятлан шалгаж, үүссэн асуудлыг холбогдох хууль, дүрмийн дагуу шийдвэрлэж, Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээ, цаашилбал улс орны эдийн засагт чухал ач холбогдолтой стратегийн ач холбогдолтой орд газрыг ашиглах мега төслүүдийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

## ТӨРИЙН АЛБА ХААГЧ ХИЛИЙН ЧАНАДАД ЗОРЧИХ ҮЕД ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ НЬ

---

*Судлаач Г.Гэрэлчулуун*

Төрийн болон албаны нууц тээгч хилийн чанадад албан хэргээр зорчих үед биеэ хэрхэн авч явбал зохистойг товч зааварлахыг чухалчлав.

### НЭГ. БЭЛТГЭЛ АЖИЛ

#### 1. Аялалын төлөвлөгөө

Та болон таны хамтрагч, гэр бүлийн гишүүд тань аялалын маршрутыг бусдад задруулахгүй байвал зохино. Таны аялалын төлөвлөгөөг аль болох цөөн хүн мэдэж байвал сайн. Сонирхогч этгээд туслах, нарийн бичгийн дарга нарын утсаар ярьсан яриа, таны ширээний тэмдэглэлийн дэвтэрт бичсэн тэмдэглэл, найз нөхдөөс чинь болон бусад аргаар аялалын маршрутыг мэдэж болно. Та зорчих рейсийн дугаар, түр буулт хийх газар, нисэх онгоцны буудал очих болон буцах тээврийн хэрэгсэл, хийх уулзалтууд, байрлах газар зэргээ заавал баталгаажуул. Хүрэх газраа очиход угтах орон нутгийн төлөөлөлтэй бай. Замд чинь саад учирвал зорьсон газраа хүрэх нөөц төлөвлөгөөтэй бай.

#### 2. Зорчин явах баримт бичгүүд

Паспорт хүчинтэй, визийн хугацаа дуусаагүй, ангилал нь тохирч буй эсэхийг шалга. Баримт бичгийн зөрчилтэй бол гадаадын хилийн шалган нэвтрүүлэх алба, гааль зэрэгт

саатуулагдаж болзошгүй.

#### 3. Гааль

Зорчих улсынхаа гаалийн дүрэм, журмын танилцуулгыг өөрийн улсын зохих байгууллагын тухайн орныг хариуцсан ажилтан, холбогдох бусад эх сурвалжаас (ГХЯ, ГЕГ-ын холбогдох ажилтан, вэб сайт г.м) авч судла. Энэхүү дүрэм журмыг зөрчвөл эрүүгийн, захиргааны шийтгэл хүлээх, түүнчлэн “тамгалуулж” болзошгүй.

#### 4. Валют

Хүнс, замын зардал зэрэгтээ хангалттай хүрэлцэх гадаадын мөнгөн тэмдэгтийг эх орондоо байхдаа банкаар солиулж ав. Учир нь хуурамч дэвсгэрт худалдан авахаас болон гадаадын нисэх онгоцны буудлын валют солих цэг зэрэгт үйлчлүүлж орон нутгийн гэмт бүтцийнхний анхаарлыг татахаас сэргийлэхэд оршино.

#### 5. Тийз тасалбар

Түр буулт хийдэггүй рейсийн нисэх онгоцны тийз худалдан авахыг чухалчил. Террористууд цөөн зорчигчтой онгоц барьцаалахыг чухалчилдаг тул том онгоцоор зорчихыг хичээ. Бусдыг барьцаалах, тусгай хүчнийхэн барьцаалагдсан хүмүүсийг чөлөөлөх ажиллагаанд онгоцны салоны суудлын эгнээний

захад сууж буй зорчигчид илүү өртдөг тул захиалж суухгүй байхыг хичээвэл зохино.

#### 6. Ачаа тээш

Мөнгө, үнэт эдлэл, хувийн мэдээллийг тань агуулсан баримт бичгийг авч явах хэрэггүй. Ачааны цоож олон комбинацтай байвал зохино. Хатуу гадаргатай, даруулга бүстэй чемодан ашигла. Учир нь цоож эвдэрсэн тохиолдолд чемодан онгойхгүй. Гар тээшээс бусад ачаагаа орон нутгийн ачаа тээшийн албаныхны гарт шилжтэл анхаарлаа сулруулж болохгүй. Хэний ч дайврыг бүү ав, хэнээр ч ачаагаа бүү татуул.

#### 7. Баримт бичгүүд

Авч явж буй нууц баримт бичиг, паспорт, төлбөрийн карт, олон улсын жолооны үнэмлэх, нисэх онгоцны тасалбар, цусны бүлэг болон эмчийн онцлог зөвлөгөөг тусгасан эмнэлгийн карт зэргийнхээ хуулбарыг ажилдаа үлдээхэд илүүдэхгүй.

#### 8. Даатгал

Хэрэв таныг мөнгө олох, эсвэл тавьж буй шаардлагаа биелүүлэхэд ашиглах гэмт сэдлээр хулгайлах буюу барьцаалбал төлбөр төлөх, хохирлыг чинь барагдуулах бодит боломжтой Даатгалын компани байдаг бол түүнтэй ажил хэргийн холбоо тогтооход анхаар.

### ХОЁР. ЗОРЧИХ

#### 1. Нисэх онгоцны буудал дээр

Хил, гааль, цагаачлалын болон дотоод аюулгүй байдлын алба, тасалбарын шалгалтын урт дараалал үүсч болзошгүй тул нислэг эхлэхээс 3 цагийн өмнө нисэх буудалд оч. Нислэг хойшилсон зэрэг шалтгаанаар

зорчигчдын бухимдал үүссэн тохиолдолд “баатар” болох хэрэггүй. Хуулийн дагуу авч явж буй бүх мөнгө, үнэт эдлэлийг гаалийн мэдүүлэгт бич. Түр орхисон ачаандаа анхаарал тавихгүй бол устгагдах аюултай.

#### 2. Галт тэргэнд

Тасалбарыг байрласан буудал, эсвэл тухайн улсын таныг хүлээн авсан буюу үйлчилж буй хүнээр дамжуулан авбал зохино. Тухайн улсын нутаг дэвсгэрээс гартлаа тасалбараа хадгал. Галт тэргэнд суухаасаа өмнө түүний хүрэх газар, маршрут, бусад галт тэргэнд холбогддог, салгагддаг эсэх, маршрутын дугаар, зогсдог станцуудын нэр зэргийг лавлан шалга. Цонхны ойролцоох суудлыг авахыг хичээ, учир нь зайлшгүй тохиолдолд гарах, зугтахад хялбар. Паспорт, баримт бичиг, зорчих тасалбар зэрэг бүх баримт бичгээ дотор халаасандаа хадгал. Купенийхээ хаалгыг хааж, орох гэсэн хүнийг “Нэрээ хэлж байгаарай” гэж хүс. Галт тэргэний үйлчлэгчийн нэрийг тогтоож, хэрэв галт тэргээс түр гарах бол заавал түүнд хэлж бай. Урьд нь очиж байгаагүй газарт өглөө эрт, эсвэл шөнө орой очихоос зайлсхий, гарцаагүй тохиолдолд хэн нэг нь заавал угтаж авбал зохино.

#### 3. Машин

Сайн замчин, эсвэл газрын зураг ав. Жолоодох үедээ аюулгүйн бүсийг заавал зүү. Олон улсын жолооны үнэмлэхээ биедээ заавал ав. Бусдыг гүйцэж түрүүлэхдээ гэрлээ асаа. Танихгүй хүнийг замаас бүү ав. Машин хөлслөхөөсөө өмнө түүнийг анхааралтай үзэж шалга.

## ГУРАВ. БАЙРЛАХ ЗОЧИД БУУДАЛ

Аюулгүй байдлын дараах зөвлөгөө нь зочид буудалд байрлах үед учирч болзошгүй эрсдлийг аль болох доод хэмжээнд байлгахад чиглэнэ. Үүнд:

1. Ачаагаа буудлын үйлчлэгчид өгөхөөс өмнө шалга.

Ачааны хуудсаа аялалын бусад баримт бичгийн хамт буудлаас гартлаа хадгал, учир нь ачаагаа буудалд хадгалж буйг нотлох шаардлага гарч болзошгүй. Хэн нэгнийг хүлээж байх үед ачаа хөлийг чинь шүргэж байвал зохино. Өрөөнөөс түр гарах үедээ ачаагаа түгж.

2. Үйлчлэгчээс ачаагаа өрөөндөө зөөж оруулах, өрөөний утас, телевиз, халаагч, хөргөгч, буцалгагч зэрэг ахуйн цахилгаан хэрэгслүүдийг хэрхэн ашиглахыг зааварлахыг хүс.

3. Буудлын үйлчилгээний хүмүүсийн дүрэмт хувцасны загварыг ажиглан тогтоо, урилгагүй “зочин”-д хянуур хандан, өрөөнд чинь “засвар хийх” г.м шалтгаанаар ирсэн эсэхийг жижүүрээс тодруулан лавла.

4. Хувийн болон албаны баримт бичгээ машинд бүү орхи. Зайлшгүй тохиолдолд буудлын хадгалах камерт хадгалуул. Паспортаа байнга биедээ авч яв.

5. Машинаа гэрэлтүүлэгтэй талбайд тавь. Үйлчилгээний хүнд машинаа өгөх бол зөвхөн асаагч түлхүүрийг өгч, бусдыг нь ав.

6. Зөвхөн өөрийн төлбөрийн болон зээлийн картаа ашигла.

7. Машин тавих талбайд сэжигтэй этгээд ажиглагдвал машинаасаа бүү гар. Хэрэв боломжтой бол буудлын

үйлчилгээний хүмүүсээс туслахыг хүс.

8. Өрөөнийхээ түлхүүрийг жижүүрт бүү үлдээ, өөртөө авч яв. Үлдээсэн түлхүүр таны эзгүйг гэрчилнэ.

9. Өрөөнөөсөө шат хүртэлх зайг ой санамждаа тогтоо, нийтийн телефон утасны байршил, зочид буудал байгаа гудамжны нэр, буудлын ойролцоох такси, автобус, галт тэрэгний буудлын байршлыг мэд.

10. Унтахдаа хаалгаа түгж, сандлаа тулгаж тавь.

11. Үнэт эдлэл зэрэг эд зүйлийг 2 давхар дугтуйд хийж амсрыг нь зигзаг дүрсээр зурж, булан, амыг нь скочдон буудлын сейфенд хадгалуул. Аливаа зүйл хулгайлагдсан тохиолдолд Цагдаа, Даатгалын компани, өөрийн улсын ДТГ зэрэгт мэдэгд. Эд зүйлээ алдсныг нь баталсан бичгийг байрласан буудлынхаа Захиргаанаас ав.

12. Үйлчилгээний хүнээс орон нутгийн таксийн таних тэмдэг, хөлсний талаар болон хооллож, зугаалж болох аюулгүй газрын талаар зөвлөгөө ав.

13. Хулгай, гэмт халдлагаас сэргийлэх үүднээс танихгүй хүнийг өрөөндөө бүү урь.

14. Долоогоос дээш давхарт өрөө бүү ав. Учир нь шаардлагатай үед орон нутгийн гал унтраах зэрэг албаны шат түүнээс дээш давхарт хүрэхгүй байж магад.

15. Буудалд түймэр гарсан үед өрөөний түлхүүрийг авч гар, цахилгаан шат бүү ашигла. Ам, хамраа нойтон алчуур, эсвэл цамц зэргээр хаа. Шатаж буй байшингаас

гарах боломжгүй бол орны бүтээлэг, ванны алчуур зэргийг норгож хаалганы хүрээний завсрыг бөглө, шаланд наалдан хэвтэж тусламж ирэхийг хүлээ.

16. Орон нутгийн такси үйлчилгээний таних тэмдэггүй, хувийн таксинаас болгоомжил, суухаасаа өмнө үнэ хөлсөө тохиролц. Үл ойлголцол зэргээс сэргийлж очих газрынхаа хаягийг цаасан дээр урьдчилан бичиж үзүүл.

### **ДӨРӨВ. БИЕЭ АВЧ ЯВАХ БАЙДАЛ**

1. Валют хууль бусаар солих, мансууруулах бодис тээвэрлэх, худалдах мэхэнд урхидагдахаас байнга сэргийл. Олон нийтийн газар биеэ авч явах журмыг зөрчих, оюуны боломжоо алдахаас сэргийлж согтууруулах ундааг ухаалаг хэрэглэ. Нойрсуулах, тайвшруулах бодис агуулсан эмийн нэр бичсэн эмчийн жорыг биедээ авч явахад илүүдэхгүй. Уран зураг, эртний эд зүйлийг тухайн улсаас авч гарах бол заавал холбогдох байгууллагаас албан ёсны зөвшөөрөл ав.

2. Олон нийтийн арга хэмжээний үеэр тантай харилцаа тогтоохыг болон таны ажил төрөл, улс төр, гадаад хэлний талаар яриа өрнүүлэхийг санаачлан оролдсон үл таних хүнээс зайлсхий. Таныг хоолонд урьсан, хамт зугаалахыг хүссэн, тантай бага зэрэг “чалчихыг” хүссэн танихгүй хүн чинь тэндхийн тагнуулын ажилтан байж болно. “Янаг амраг”-ийн ажлаас хол бай.

3. Зөвхөн хийх ёстойгоо хийж, ярих ёстойгоол ярь. Гэхдээ энэ бүхэн нь

эсрэг тал мэдээ цуглуулах, дарамтлах зорилгоор нууцаар бичигдэж байж болзошгүй гэдгийг байнга сана. Хэрэв өөрийг чинь нууцаар даган мөрдөж буйг илрүүлбэл өөрийн улсын ДТГ-т мэдэгдэж, өгсөн зөвлөгөөг нь дага.

### **ТАВ. БАРЬЦААЛАГДАХ, ХУЛГАЙЛАГДАХ ТОХИОЛДОЛД**

1. Барьцаалагдсан үед биеэ авч явах нь

Барьцаалагдах үеийн хүнд сорилтыг тэсэн гарахын тулд барьцаалагчийн зааврыг биелүүл. Тэдний дуу хоолойн өнгө, нүүрний хэлбэр, хувцаслалт, сорви, биеэ авч яваа онцлог хэв маягийг тогтооход анхаарлаа төвлөрүүл. Паспорт, хувийн эд зүйлээ анхных нь шаардлагаар өг. Асуултад нь аль болох товч хариул, сайн дураараа ямар ч мэдээлэл өгч болохгүй. Зугтах боломж байвал хэрэв та алах, эсвэл алагдахад сэтгэл зүйн хувьд бэлэн байгаа зөвхөн тийм тохиолдолд л түүнийг ашигла. Аливаа үйлдлийг хийх үедээ эргэлзвэл энэ нь үхлийн аюултай байж болно. Барьцаалагчдыг улангасуулж болохгүй, өөрийгөө сэжиглүүлж болохгүй. Чөлөөлөх операцийн хохирогч болохгүйн тулд тусгай хүчний багийн зааврыг дага.

2. Хулгайлагдах үед биеэ авч явах нь

Хулгайлагдахаас хэрхэн сэргийлэхийг хэлэхэд хэцүү. Учир нь хэн, хэзээ, хаана болж буй зэргээс шалтгаална. Хулгайлахыг завдах үед:

1. Хэрэв олон нийтийн газар, эсвэл зочид буудлын өрөөнд болж буй бол аль болох их чимээ шуугиан гаргах, жишээлбэл унах, тийчлэх,

орилох, хана нүдэх зэргээр бусдын анхаарлыг аль болохоор тат. Энэ нь уг явдал хаана, хэзээ болсныг гэрчилнэ.

2. Өөрийн улсын ДТГ, орон нутгийн цагдаагийн зэрэг албаны утсыг ганц даралтаар дуудахаар гар утсандаа сануулсан бол түүнийг ашигла..

3. Хэрэв нүдийг чинь боож, машины тээшинд чихсэн бол чимээ шуугиан, үнэр, замын эргэлт ,гэрлэн дохио хүлээсэн, машины хөдөлгөөний чиглэлийн өөрчлөлт, хулгайлуулснаас хойшхи хөдөлгөөний хугацаа зэргийг санан тогтооход анхаарлаа төвлөрүүл.

4. Гэмт этгээдүүдэд нийтэд ил мэдээ л өг. “Би одоо үүнийг санахгүй байна” гэдэг товч хариулт хамгийн оновчтой. Ширээ, эсвэл ханан дээр байгаа ямар нэг цэгт хараагаа төвлөрүүлж, анхаарлаа хөвчил. Хэрэв хүч хэрэглэхгүй л бол ямар ч цаасан дээр гарын үсгээ бүү зур. Өвдсөн, ядарсан дүр эсгэ. Хулгайлсан этгээдүүдтэй бүү марга.

5. Хэрэв таныг удаанаар хоривол биеийн хүчний болон оюуны дасгал хий. Эсрэг этгээдүүдийн дуу хоолойн өнгө, сорви, онцлог зуршил, нэр, хоч, нүүр царай, өдрийн дэглэм зэргийг тогтоо. Он, сар, өдөр, байшин, өрөө тасалгааны байршил, дуу чимээ, үнэр зэргийг тогтоо. Зугтах боломжийн тухай байнга бод. Хэрэв зугтаж чадвал өөрийн болон найрсаг харилцаат улсын ДТГ-т хамгийн түрүүнд оч.

### **ЗУРГАА. МЭДЭЭЛЛЭЭ ХАДГАЛАХ**

Эрүүл ухаан, сонор сэрэмжтэй бай. Таны авч явж буй болон таны мэдэх мэдээ мэдээлэл гадаадын тусгай албад, гэмт бүтцийн хувьд үнэ цэнэтэй

зүйл. Иймээс Та эсрэг Талын тусгай албаны элсүүлэх ажиллагаа, гэмт бүтцийн халдлагад өртөх магадлалтай. Дор дурдсан аюулгүй байдлын арга хэмжээг хилийн чанадад зорчиход төдийгүй өдөр тутмын амьдралдаа сахихыг хичээ. Үүнд:

1. Гэр-ажил, зочид буудал-ажилдаа очих, буцах маршрутаа байнга өөрчил. Олон хүнтэй газар нууц материал авч яваа үедээ сэрэмжтэй бай. Гар утсаар ярих, зөөврийн компьютерээ ажиллуулах үед чинь онгоцны салонд хажуугийн сандал дээр сууж буй “зорчигч”, эсвэл байрласан буудлын чинь “үйлчлэгч” сонсож, нууц бичлэг хийж магадгүй.

2. Өөрийн улсын ДТГ, орон нутгийн цагдаа, эмнэлгийн түргэн тусламж зэргийн утастай нэг даралтаар холбогдохоор гар утсаа зохицуул. Флашаа кодло.

3. Нууц баримт бичгээ буудлын өрөө, жижүүр дээр бүү орхи. Үнэтэй автомашин, гял цал хувцас, үнэт эдлэлээр бусдын анхаарлыг бүү тат.

4. Халаасны камер, диктофонтой явахад илүүдэхгүй. (Гэмт халдлага, эрсдэлтэй байдлыг баримтжуулах боломж гарахыг үгүйсгэхгүй).

5. Галт тэрэгний буудлын тавцан-платформын болон засмал замын хашлагын ойр бүү зогс. Учир нь явж буй тээврийн хэрэгслийн доогуур таныг хоромхон зуур түлхэх эрсдэлтэй.

6. Мотоцикльтэй этгээд явган зорчигчийн цүнх, гар тээшийг хялбархан шүүрч зугтдагийг санаж яв. Иймээс замын хашлагын ойр явж болохгүй. Зөөврийн компьютертай цүнхнийхээ оосрыг мөрлө, цүнх чинь хамт явж буй хүний талд, замын



эсрэг талд байх ёстой.

### ДОЛОО. БИЕЭ ХАМГААЛАХ

Олон жилээр сургуулилж, сайтар эзэмшээгүй мэх хэрэглэхээс зайлсхий. Довтолгоо хийх ганц боломж л танд олдоно. Үүнийг зөв, эсвэл огт бүү ашигла. Өөрийгөө хамгаалах зарим арга:

1. Гэрлийн эх сурвалж (нар, чийдэн г.м) таны нуруун талаас, гэхдээ эсрэг этгээдийн нүүрэнд тусаж байх.

2. Тамхины үнс, тоос, элс зэрэг гарын дорх зүйлийг нүд рүү нь цацаж харааг нь муутга. Зогсоо байрлалаас өшиглөхийн тулд нүдийг нь хуруугаараа, эсвэл үзэг, түлхүүр, сэрээ г.м-ээр хатга.

3. Довтлогчийн гэвэрлээс чөлөөлөгдөхийг оролдох хэрэггүй. Учир нь таныг гэвэрч буй тул түүний гар хөдөлж чадахгүй, ингэснээрээ түүнийг хамгаалалтгүй болгодог. Иймд түүний эмзэг эрхтэн, өвдөг рүү өшиглө. Эсвэл гарынхаа алгаар чихэн тус газар нь, хүчтэй цохь, нударгаараа нүд.

4. Өвдөгнөөс нь дээш өшиглөх хэрэггүй. Та тэнцвэрээ алдаж болзошгүй. Гараар хийх цохилт нь довтлогчийн толгой, бөөр, наран сүлжээ зэрэг амин чухал эрхтнийг гэмтээх цохилт байвал сайн.

5. Буланд шахуулахгүй бай. Биеэ хамгаалахын тулд орчиндоо байгаа бүх зүйлийг, жишээлбэл стаканыг ёроолыг нь алгандаа атган цохих, довтолохдоо ашигла.

6. Довтлогчийг алмайруулах зарим арга болох: нударга, алгаараа түүний хамар, уруул руу цохих,

эмзэг эрхтэн рүү өшиглөх, эрүү рүү нь цохих г.м. Эдгээр арга нь түүнийг хурц өвдөлтийн шоконд түр зуур оруулах, хөдөлгөөнгүй болгодог. Энэ хооронд зугт, эсвэл довтло.

7. Довтлогчийн зэвсгийг булаахыг оролдох хэрэггүй. Харин зэвсэгтэй гарыг нь хажуу тийш түлх, эсвэл зэвсгийн хажуу тал руу зайл. Ингэснээр галын шугамаас зайлна.

8. Довтлогч ярьж байгаа тохиолдолд нүдээд л бай. Учир нь хүн ярьж буй үедээ хангалттай хүчтэй цохиж чаддаггүй. Довтлогч муужирсан, эсвэл өөр тийш нь чиглүүлсэн тохиолдолд зэвсгийг нь булаа.

9. Анхаарлыг нь сарниулахын тулд гар, хуруугаа дээш, эсвэл өөр тодорхой зүйл рүү зааж “Энд цагдаа байгаа шүү” гэж хашгирах, эсвэл шал руу стакан шид. Үүний дараа цохь.

10. Хэрэв таныг олон хүн бүсэлвэл “намайг явуулчих” гээд хэлэлцэн тохирохыг оролд. Бүтэлгүйтвэл эхэлж довтол. Тэдний нүд, чих, хоолой руу үзэг, түлхүүрээр сүлбэ, хатга, гарыг нь хаз.

11. Өвдөлт, гэмтлээс бүү ай. Айдас бол бодит зүйл биш. Айдас зөвхөн таны толгойд байгаа зүйл. Довтолгоонд төвлөрөх, айдсаа бууруулахын тулд амьсгалаа түгжин, аажим амьсгал. Амьсгалаа түгжсэн, эсвэл гаргаж байх үедээ цохь, нүд. Хэрэв та довтолохоор шийдсэн бол бүх хүчээ ашигла. Хурд нь жингээс (массаас) чухал. Учир нь хурд их үед мөргөлт 2 дахин нэмэгддэг. Өрсөлдөгчөө айлгахын тулд сайн хашгир. Гэхдээ хэзээ, яаж хашгирахаа мэдэх хэрэгтэй.

## ГАДААДЫН ТУСГАЙ АЛБАД

ГАДААДЫН ТУСГАЙ АЛБАДЫН ТАЛААР  
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**СОЛОНГОСЫН ХОЙГ*****Хойд Солонгосын удирдагчийн  
дцү тушаал дэвшжээ***

БНСУ-ын тагнуулын мэдээнд Хойд Солонгосын удирдагч Ким Жон Уны дүү Ким Ён Жоныг тушаал дэвшиж тус улсын шийдвэр гаргах хоёрдугаар зэргийн удирдах албан тушаалыг хаших болсон талаар дурджээ. Ким Ён Жон нь одоо 30 настай бөгөөд Хойд Солонгосын эрх баригч Солонгосын хөдөлмөрийн намын суртал ухуулгын хэлтсийн даргаар ажиллаж байсан юм.

Тэрээр 2019 оны 06 дугаар сарын эхээр Пёнъян хотод зохион байгуулагдсан олон нийтийн томоохон арга хэмжээнд оролцохдоо Солонгосын хөдөлмөрийн намын Төв хорооны орлогч дарга Ким Ён Жонтой зэрэгцэн суусан байна. Ийм төрлийн арга хэмжээнд Хойд Солонгосын албан тушаалтнуудын эрэмбэ дарааллыг нарийн тооцож суулгадаг бөгөөд Ким Ён Жон нь тус улсад хоёр эсвэл гуравт орох удирдах албан тушаалд дэвшсэн байж болзошгүй ажээ.

Өмнөд Солонгосын гадаад тагнуулын байгууллага болох Үндэсний тагнуулын алба (ҮТА) нь 2019 оны 06 дугаар 25-ны өдөр тус улсын төрийн удирдлагуудад хаалттай

мэдээлэл бэлтгэж танилцуулсан байна. Тус улсын парламентын харьяанд байдаг Тагнуулын хорооны хэвлэлийн төлөөлөгч Ли Хе Хүүн ҮТА-ны танилцуулсан мэдээллийн дүгнэлтийг олон нийтэд хүргэсэн бөгөөд түүнд Ким Ён Жоныг Хойд Солонгосын төрийн удирдах албан тушаалд шинээр томилогдсон тухай дурдсан байна.

**ИРАН*****Иран 16 албан тушаалтнаа  
АНУ-ын ТТГ-тай хамтран  
ажилласан хэмээн баривчилжээ***

Ираны олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл тус улсын Газрын тосны яамны 16 албан тушаалтныг Ираны эрчим хүчний бодлогын эсрэг хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байсантай холбоотойгоор баривчлагдсан хэмээн мэдээлжээ. Тэдгээр албан хаагчид нь бүгд Ираны газрын тосны үйлдвэрлэлийн судалгаа шинжилгээ, боловсруулалт, түгээлтийн салбарт удирдах албан тушаал хашдаг нөлөө бүхий хүмүүс ажээ.

Баривчилгааны талаарх мэдээллийг Ираны парламентын Консерватив намын ахлах хуульч Хусейн Али Хажид Делигани олон

нийтэд хүргэсэн бөгөөд тэрээр “Газрын тосны яамны албан тушаалтнуудад чиглэсэн арга хэмжээ явууллаа, тэдгээр албан тушаалтнууд нь бүгд газрын тосны салбарт шийдвэр гаргахад нөлөө бүхий хүмүүс байсан ба Иран, АНУ-ын хооронд өрнөж буй эдийн засгийн дайнд Ираны үндэсний ашиг сонирхлын эсрэг гадаад улсын эрх ашгийг хамгаалж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлж байсан” гэжээ.

Баривчилгаа болохоос хоёр өдрийн өмнө Ираны Батлан хамгаалахын яамны Сансрын үйлдвэрлэлийн газрын ажилтан Жалал Хажи Завар гэгчийг АНУ-ын ТТГ-т ажилласан хэмээн шүүхээр шийдвэрлэж цаазаар авах ажиллагааг гүйцэтгээд байсан.

## **ИЗРАИЛЬ**

### ***Израильд Ираны гүн халхавчийн тагнуулыг баривчилсан байна***

Израилийн эрх баригчид Ираны тагнуулын байгууллагын баазыг Израиль, Йорданы “Вест Банк”-д байгуулахаар санаархаж байсан тус улсын гүн халхавчийн тагнуулын ажилтныг баривчилсан талаар мэдээлжээ. Израилийн Дотоодаюулгүй байдал, сөрөх тагнуулын агентлагаас Йорданы иргэн Таер Шаафут гэгчийг 2019 оны 4-р сард тагнуул хийх гэмт хэрэг үйлдсэн хэмээн баривчилсан бөгөөд Израилийн тал түүнийг Ираны тагнуулын байгууллагад элссэн, Израиль, Йорданы “Вест Банк”-д өөрийн сүлжээг байгуулах үүрэг даалгавартай байсан талаар дурджээ.

Түүнийг гардан ажиллаж байсан

Ираны тагнуулын байгууллагын ажилтан 2018 оны 07, 08-р сард Израильд ирж үүрэг зааварчилга өгсөн бөгөөд Таер Шаафут гэгч нь шийт урсгалын мусульманчуудыг хөлсөлж Йорданд үйлдвэр байгуулан Ираны Йордан, Израильд явуулах тагнуулын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой байжээ. Түүнийг Ливан, Сири зэрэг улсад үүрэг гүйцэтгэж байсан Ираны тагнуулын байгууллагын ажилтнууд болох Абу Садек, Абу Жаффар нар гардан ажилладаг ба Таер Шаафутад тусгай нууцлал бүхий төхөөрөмж дамжуулан түүнийхээ тусламжтайгаар уулзалтаа товлодог ажээ.

Ираны тагнуулын байгууллагаас Таер Шаафутыг үйлдвэрээ байгуулахад нь эхний ээлжинд 500.000 ам.долларын санхүүжилт гаргаж, үйлдвэрээ байгуулсных нь дараа түүнийг Иранд авчирч сургаж дадлагажуулах төлөвлөгөөтэй байсан. Израилийн прокурорын байгууллагаас түүнийг “гадаад улсын тагнуулын байгууллагатай хамтран ажилласан, гадаад улсын тусгай албаны халхавчийн байгууллага байгуулахыг оролдсон” гэх үндэслэлээр баривчлах зөвшөөрөл олгосон байна.

## **ПАКИСТАН**

***Томилогдоод 8 сар болж байсан Пакистаны тагнуулын байгууллагын дарга ажлаасаа чөлөөлөгджээ***

Пакистаны армиас тус улсын тагнуулын байгууллагын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шийдвэрийг гэнэт гаргажээ. Тус

шийдвэрийг Пакистаны Зэвсэгт хүчний Олон нийттэй харилцах албанаас мэдээлсэн бөгөөд Пакистаны тагнуулын байгууллагын даргаар ажиллаж байсан дэслэгч генерал Асим Мунир албан тушаалаа өгч Пакистаны Пунжаб мужийн цэргийн корпусын командлагчаар ажиллахаар болжээ. Тус байгууллагын даргаар томилогдсон хүн 3 жил ажилладаг боловч түүнийг яагаад үүрэгт ажлаас нь гэнэт чөлөөлсөн талаар тайлбарлаагүй ажээ.

Пакистаны тагнуулын байгууллагын шинэ даргаар сөрөх тагнуулын байгууллагын дарга, дэслэгч генерал Файз Хамийд гэгч томилогдсон байна. Асим Мунир нь ажлаасаа чөлөөлөгдөхөөсөө өмнө ойрхон хугацаанд хэд хэдэн удаа тушаал дэвшсэн байсан юм. Тэрээр 2017 оны сүүлчээр Пакистаны засгийн газар, Пунжаб мужаас гаралтай Ислам шашны Ахмадияа хөдөлгөөний хооронд зуучлагчийн үүргийг амжилттай гүйцэтгэсэн бөгөөд сүүлийн үед тус хөдөлгөөний зүгээс тохиролцооноосоо буцаж засгийн газрыг шүүмжлэх өнгө аясыг дахин гаргах болсон.

Пакистаны тагнуулын байгууллагын дарга Файз Хамийдын зүгээс тус хөдөлгөөнийг жагсаал цуглаанаа зогсоохгүй байх тохиолдолд цэргийн хүч оруулахыг анхааруулж байна. Харин Пакистаны эрх баригчдын зүгээс тус хөдөлгөөний үйл ажиллагааг намжаах зорилгоор Асим Мунирыг Пунжаб мужийн цэргийн корпусын командлагчаар томилсон байх магадлалтай байна.

**ТУРК**

### *БНТУ-ын тусгай алба гар утасны шинэ аппликэшин гаргажээ*

БНТУ-ын тусгай албанаас Германд ажиллаж амьдарч буй тус улсын засгийн газар, эрх баригч Шударга ёс, хөгжлийн нам (ШЁХН)-ыг дэмжигч иргэдэд зориулж ухаалаг гар утасны аппликэшин гаргасан байна. Энэ талаарх мэдээллийг ХБНГУ-ын сөрөх тагнуулын байгууллага болох Үндсэн хуулийг хамгаалах холбооны албаны өнгөрсөн жилийн тайланд тусгажээ. Уг тайланд тус улсын өмнөд муж Баден-Вюртембергт зохион байгуулагдсан террорист болон гадаад тагнуулын үйл ажиллагааны талаар оруулсан байна. Хятад, Орос, Иран, Турк зэрэг улсын тагнуулын үйл ажиллагаа 2018 онд Германд үлэмж хэмжээгээр нэмэгдсэн гэжээ. Турк иргэд Баден-Вюртембергт олноор суурьшдаг учир Туркийн тусгай албадын үйл ажиллагаа тус мужид ерөнхийдөө зонхилсон байна.

Туркийн тусгай албадын ашиг сонирхол 2 бүлэг хүмүүст чиглэдэг бөгөөд нэгд, Курдийн тусгаар тогтнолын төлөө тэмцэгч зэвсэгт бүлэглэл болох Курдийн ажилчны намын гишүүд дэмжигчид, хоёрт, Туркийн засгийн газрын эсрэг тэмцэгч Фетуллах Гүленийг дэмжигч турк иргэд ажээ. Туркийн эрх баригч ШЁХН-ыг дэмжигч иргэд тус аппликэшний тусламжтайгаар Курдийн ажилчны намын гишүүд болон Ф.Гүленийг дэмжигч турк иргэдийн талаарх мэдээллийг илгээдэг байна.

Түүнчлэн уг тайланд ХБНГУ-д үздэг ажээ. үйл ажиллагаа явуулж буй Туркийн тусгай албаны халхавчийн зарим байгууллагын нэрсийг оруулжээ. Эдгээр нь Олон улсын ардчилсан үзэлтнүүдийн холбоо, Туркийн ислам шашны хэрэг эрхлэх холбоо ажээ. Туркийн ислам шашны хэрэг эрхлэх холбоо нь Герман дахь ислам шашны олон байгууллага, сүмийг эгнээндээ нэгтгэж үйл ажиллагааг нь удирддаг бөгөөд Туркийн эрх баригч ШЕХН, Ерөнхийлөгч Р.Т.Эрдоган нарын эрх ашгийн төлөө ажилладаг болохыг баримтаар нотолсон байна. ХБНГУ-ын тагнуулын зарим албан тушаалтнууд уг байгууллагыг Туркийн тус улс дахь товчлогчийн байгууллага гэж

# “ТУСГААР ТОГТНОЛ”

Үндэсний аюулгүй байдал, тагнуул судлалын эрдэм шинжилгээ,  
судалгаа, онол, аргазүйн сэтгүүл

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Эрхлэгч:

Г.Батжаргал докторант

Нарийн бичгийн дарга:

Авирмэд доктор, дэд профессор

Гишүүд:

Д.Тунгалаг доктор, профессор

Д.Мөнх-Очир докторант

Ц.Дашдэндэв

## EDITORIAL BOARD

Editor in Chief:

Г.Батжаргал (Ph.D candidate)

Secretary:

D.Avirmed (Ph.D), assoc.prof

Members:

D.Tungalag (Ph.D), prof

D.Munkh-Ochir (Ph.D candidate)

Ts.Dashdendev

Эрхлэн гаргасан:

Үндэсний тагнуулын академи

Тус сэтгүүлд нийтлэгдсэн материалын агуулга, тоо баримтын бодит үнэн, эх сурвалжаа заасан байдлыг зохиогч, нийтлүүлэгч өөрөө хариуцах бөгөөд үзэл бодол, үнэлэлт дүгнэлт нь Сэтгүүлийн зөвлөлийн байр суурийг илэрхийлэхгүй.



Тус сэтгүүлд материал нийтлүүлэх буюу санал, хүсэлт  
гаргах бол дараах хаягаар хандана уу.

Сэтгүүлийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
10-р хороо, Ногоон нуурын гудамж

Утас: 92263508

E-mail: [nat\\_int\\_academy@gia.gov.mn](mailto:nat_int_academy@gia.gov.mn)

Улсын бүртгэлийн дугаар: № 390